# АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ "БУЛГАНЫ СЭРГЭЛТ" ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

2025.11.20 Булган аймаг

| № | / ТЕЗ / Хөтөлбөрийн нэр | Үр дүн, үндсэн үйл ажиллагаа | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь түвшин | | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Хэрэгжилтийн хувь | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Хэрэгжилт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | он | түвшин | | | | | | | |
| **НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН СЭРГЭЛТ** | | | | | | | | | | | | | |
| **Эрүүл мэнд** | | | | | | | | | | | | | |
| **1.1** | **ТЕЗ** | Хүн амын эрүүл мэндийн зөв дадал хэвшүүлж, нийгмийн эрүүл мэндийн сэргэлтээр дундаж наслалтыг нэмэгдүүлнэ. | Хүн амын дундаж наслалт | Жилээр | 2024 | 74.37 | 74.62 | 75.01 | 100 | - | - | - | Хүн амын дундаж наслалтад нөлөөлөх хүчин зүйл болох 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг бууруулах зорилгоор ЭХЭМҮТ-ийн Тандалт судалгааны албатай хамтран "Нярайн амьсгал гачаалын хам шинж", "Дутуу нярайн халдвар", "Нярайн гипокси-ишемийн шалтгаант энцефалопати" сэдэвт 4 цахим сургалтыг зохион байгуулж, 42 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулсан. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх хүрээнд 12721 эмнэлгийн үйлчлүүлэгч, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэгт 20314 иргэн, сургуульд суурилсан үзлэг, дархлаажуулалтад 3017 хүүхэд, нийт 36052 иргэнийг хамруулж, цахим орчинд 212 төрлийн контент, сурталчилгааг 20 цахим хуудсанд байршуулан 47684 хүнд хүргэжээ. Үндэсний статистикийн хорооны мэдээгээр аймгийн хүн амын дундаж наслалт 75.01 жил байна. |
| **1.1.1** | | Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна. | Эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалт | Хувь | 2024 | 43.2 | 50.0 | 50.5 | 100 | 7.9 | 7.9 | 100 | Эрүүл мэндийн сайд, Боловсролын сайдын хамтарсан 2024 оны А/415, А/151 дүгээр тушаалаар зохион байгуулагдаж буй ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангийн 6 настай сурагчдын нүд, шүд, зүрхний урьдчилан сэргийлэх үзлэгийн явц 2025 оны байдлаар нүд 98.2 хувь, шүд 95 хувь, зүрх 96.2 хувьд хүрсэн бөгөөд анхан шатны илрүүлгээр 157 хүүхдийн нүд, 645 хүүхдийн шүд, 209 хүүхдийн зүрхэнд өөрчлөлт илэрч, дараагийн шатлалын оношилгоо, эмчилгээнд хамруулж ажиллав. Аймгийн Засаг даргын нэрэмжит нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгийг 8 суманд зохион байгуулж, 2178 иргэнийг хамруулан 18 иргэнийг дээд шатлалын эмнэлэгт шилжүүлсэн. Дээрх ажлуудын үр дүнд эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалт 50.5 хувьд хүрч, өмнөх оноос 7.3 пунктээр нэмэгдсэн байна. |
| | | | Хамрагдсан иргэд | Тоо | 2024 | 14000 | 15000 | 15529 | 100 | - | - | - | 2025 онд нийгмийн эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгааны арга хэмжээг идэвхжүүлж, 136 удаагийн танхимын сургалтад 9106 иргэн, цахим сургалтад 6423 иргэн, нийт давхардсан тоогоор 15529 иргэнийг хамруулсан. ЭМБ-ууд нэрэмжит сарын аян, тэмдэглэлт өдрүүд, сургуульд суурилсан үзлэг, оношилгоо, дархлаажуулалтын аяны хүрээнд 27506 иргэнд нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж, нийт 43035 иргэнийг хамруулсан. Мөн цахим орчинд эрүүл мэндийн мэдлэг, боловсрол олгох 252 төрлийн контент байршуулж, 47684 хүн хандалт хийжээ. |
| | | | Зүрх судасны өвчний шалтгаант нас баралтын түвшин /10,000 хүн амд ногдох/ | Түвшин | 2024 | 25.9 | 25.4 | 20.1 | 100 | - | - | - | Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Улсын 3 дугаар төв эмнэлэг, МҮОНРТ, ХААН банктай хамтран "Цусны даралт ихсэлтийн аян"-ыг зохион байгуулж, 16 сумын 2097 иргэнийг зүрх судасны өвчлөл, цусны даралт ихсэлтийн эрсдэлийн үнэлгээ, нарийн мэргэжлийн эмчийн үзлэг оношилгоонд хамруулсан. ДЭМБ-ын халдварт бус өвчин, зүрх судасны өвчний нэн шаардлагатай тусламж үйлчилгээг нэвтрүүлэх МонПэн төслийн хүрээнд 50 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. Аймгийн хэмжээнд 2025 оны 10 дугаар сарын статистик үзүүлэлтээр 10000 хүн амд ногдох зүрх судасны өвчний шалтгаант нас баралтын түвшин 20.1 байна. |
| | | | Хорт хавдар өвчний шалтгаант нас баралтын түвшин /10,000 хүн амд ногдох/ | Түвшин | 2024 | 14.1 | 13.1 | 14.3 | 0 | - | - | - | Хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан болж байгаа хавдрын өвчлөлийг бууруулах, эрт илрүүлэх зорилгоор аймгийн Нэгдсэн эмнэлэгт 4 ортой тасгийг нээн ажиллуулж, өргөжүүлэх бэлтгэл ажлыг хангаж, хавдрын 58 тохиолдлыг шинээр илрүүлж, 74 иргэнийг хэвтүүлэн эмчиллээ. "Хүн амыг хорт хавдраас урьдчилан сэргийлэх илрүүлэх" 6 сарын аяныг зохион байгуулж, умайн хүзүүний өмөн, хөхний өмөн, элэг, улаан хоолой, ходоод, бүдүүн шулуун гэдэс, уушгины хорт хавдрын эрт илрүүлэгт 2937 иргэнийг хамрууллаа. 2025 оны 10 дугаар сарын статистик мэдээгээр 10000 хүн амд ногдох хорт хавдрын шалтгаант нас баралт 14.3 байгаа нь суурь түвшнээс нэмэгдсэн үзүүлэлттэй байна. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **1.1.2** | **Хөтөлбөрийн** | Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ. | Эхийн эндэгдлийн түвшин (100 000 амьд төрөлт тутамд) | Промиль | 2024 | 0 | 0 | 0 | 100 | - | - | - | 2025 онд эхийн ноцтой хүндрэлийн нэг тохиолдол бүртгэгдсэн бөгөөд эмнэлгийн тусламж, үйлчилгээг цаг алдалгүй, чанартай үзүүлж, эхийн амь нас аврагдсан байна. Гарсан тохиолдлыг "Эхийн ноцтой хүндрэлийг ажлын хэсэг"-ийн хурлаар хэлэлцэн, жирэмсний эрт үеийн хяналтыг сайжруулах, жирэмсний хяналтын үзлэг, оношилгоог сайжруулах, алслагдсан багийн малчин, отроор явж байгаа жирэмсэн эхийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг эрүүл мэндийн байгууллагуудад өгч, хэрэгжүүлж байна. 2025 оны 10 дугаар сарын статистик мэдээгээр аймгийн хэмжээнд 405 эх төрсөн бөгөөд одоогийн байдлаар эхийн эндэгдэл бүртгэгдээгүй байна. |
| | | | Нялхсын эндэгдлийн түвшин /1,000 амьд төрөлтөд ногдох/ | Промиль | 2024 | 9.0 | 8.9 | 17.3 | 0 | - | - | - | 2025 оны 10 дугаар сарын статистик мэдээгээр нялхсын эндэгдлийн түвшин 1000 амьд төрөлтөд 17.3 байгаа нь улсын дунджаас 3.6, аймгуудын дунджаас 4.6 промилиэр өндөр байна.<br>Нярайн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор хүүхдийн 1 их эмчийг нярайн чиглэлээр төрөлжсөн мэргэшил эзэмшүүлэн ажиллуулж байна. ЭХЭМҮТ-ийн Тандалт, судалгааны албанаас зохион байгуулсан “Нярайн амьсгал гачаал хам шинж”, “Дутуу нярайн халдвар”, “Нярайн гипокси-ишемийн шалтгаант энцефалопати”, “Дутуу нярайн менежмент”, “ХӨЦМ” сэдэвт цахим болон танхимын сургалтуудыг зохион байгуулж, эрүүл мэндийн байгууллагуудын давхардсан тоогоор 112 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан байна. |
| | | | 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин /1,000 амьд төрөлтөд ногдох/ | Промиль | 2024 | 21.1 | 21.0 | 24.8 | 0 | - | - | - | 2025 оны 10 дугаар сарын статистик мэдээгээр тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 1000 амьд төрөлтөд 24.8 байгаа нь улсын дунджаас 8.0, аймгуудын дунджаас 8.3 промилиэр өндөр байна.<br>Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 2.2 хувь нь осол гэмтэл, гадны шалтгаант, 44.4 хувь нь перинаталь үеийн эмгэг, 11.1 хувь нь хорт хавдар, 22.2 хувь нь амьсгалын тогтолцооны эмгэгийн шалтгаанаар эндсэн байна. НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр “Бага насны хүүхдийг осол гэмтлээс сэргийлэх” чиглэлээр эцэг, эх асран хамгаалагчдад сургалт зохион байгуулахад зориулсан 250 ширхэг гарын авлагыг боловсруулан хэвлүүлж, эрүүл мэндийн байгууллагуудад тараасан. Эрүүл мэндийн байгууллагууд уг чиглэлээр сургалтыг зохион байгуулж, нийт 465 иргэнийг хамруулсан байна. |
| **1.1.3** | | Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалт, чадавхыг нэмэгдүүлнэ. | Мэргэжлийн зэрэгтэй эмч, эмнэлгийн мэргэжилтний тоо | Тоо | 2024 | 139 | 144 | 145 | 100 | - | - | - | 2025 онд аймгийн эрүүл мэндийн байгууллагуудаас их эмчийн тэргүүлэх зэрэгт 1, сувилагчийн ахлах зэрэгт 3, бага эмч ахлах зэрэгт 2, нийт 6 мэргэжилтэн нэмэгдэж, мэргэшлийн зэрэгтэй эмч, эмнэлгийн мэргэжилтэн 145 болсноор нийт эмнэлгийн мэргэжилтний 22 хувийг эзэлж байна. |
| | | | 10.000 хүн амд ногдох сувилагчийн тоо | Тоо | 2024 | 30.9 | 32.9 | 30.1 | 0 | - | - | - | Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй эрүүл мэндийн байгууллагуудад 210 сувилагч ажиллаж, 60130 хүн амд сувилахуйн тусламж үйлчилгээг үзүүлж байна. 2024 онд 23 сувилагчийн дутагдалтай байсан бөгөөд 4 сувилагчаар хангагдсанаар эрүүл мэндийн салбарт дутагдалтай сувилагчийн тоо 19 болж буурсан. АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар сургуулийн төгсөгчидтэй хүний нөөцийн хангалтыг нэмэгдүүлэх чиглэлээр уулзалт зохион байгуулж, 5 төгсөгчтэй гэрээ байгуулаад байна. 2025 онд 10000 хүн амд ногдох сувилагчийн тоо 30.1 байгаа нь суурь түвшнээс буурсан үзүүлэлттэй байна. |
| | | | Нэг эмчид ногдох үйлчлүүлэгчийн тоо | Тоо | 2024 | 585 | 540 | 546.6 | 85..3 | - | - | - | Төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад нийт 115 эмч ажиллаж, хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж байна. 2025 онд 11 их эмчээр хүний нөөцийн хангалтыг нэмэгдүүлснээр 1 эмчид ногдох хүний тоо 546.6 болж, суурь түвшнээс 38.4-өөр буурсан байна. |
| | | | Сургалтад хамрагдсан иргэд | тоо | 2024 | 14000 | 15000 | 16792 | 100 | - | - | - | Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох сургалт сурталчилгааны чиглэлээр нийгмийн эрүүл мэндийн тэмдэглэлт өдрүүд 19, нэрэмжит сарын аян 9 удаа, иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр 153 удаагийн танхимын сургалт болон хөдөлгөөнт хэлбэрээр 16792 иргэнийг хамруулж, сурталчилгаанд давхардсан тоогоор 17624 иргэнийг хамруулсан. Эрүүл мэндийн газрын албан ёсны цахим хаяг www.bu.mohs.go.mn болон эрүүл мэндийн байгууллагуудын цахим хуудсаар цаг үеийн мэдээ, мэдээллийг түргэн шуурхай, үнэн зөв хүргэх зорилгоор давхардсан тоогоор 252 мэдээллийг цахим хуудсанд байршуулж, 47684 хүн хандаж мэдээлэл авсан байна. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **1.1.1.1** | | Эрүүл амьдралын хэв маягийг дэмжиж, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэн, хөдөөгийн хүн амд нүүдлийн амбулаторийн үйлчилгээг нэвтрүүлж, урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн үзлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлнэ. | Эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалт | Хувь | 2024 | 43.2 | 50 | 50.5 | 100 | 15 | 5.9 | 39.3 | Сургуульд суурилсан 1 дүгээр ангийн 6 настай хүүхдүүдийн нүд, шүд, зүрхний эмгэгийг эрт илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэгт 2025 онд нүдний анхан шатны үзлэгт 98.2 хувь, шүдний үзлэгт 95 хувь, зүрхний үзлэгт 96.2 хувь хамрагдсан. Анхан шатны илрүүлгээр 157 хүүхэд нүд, 645 хүүхэд шүд, 209 хүүхэд зүрхний өөрчлөлттэй илэрч, дараагийн шатны оношилгоо, эмчилгээнд хамруулж ажиллав. Мөн халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгт 3996 иргэнийг хамруулсан. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Улсын гуравдугаар төв эмнэлэг, МҮОНРТ, ХААН банктай хамтран хэрэгжүүлж буй “Цусны даралт ихсэлтийн эсрэг аян–2025” аян зохион байгуулагдаж, 2097 иргэнийг зүрх судасны өвчлөл, цусны даралт ихсэлтийн эрсдэлийн үнэлгээ, нарийн мэргэжлийн үзлэг оношилгоонд хамруулсан. Эдгээр илрүүлэг үзлэгүүдийн үр дүнд аймгийн хэмжээнд эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалт 50.5 хувьд хүрч, өмнөх оноос 7.3 пунктээр нэмэгдсэн байна. |
| | | | Шинээр бий болсон амбулатори | тоо | 2024 | 0 | 1 | 1 | 100 | - | - | - | Нэгдсэн эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээнд хавдрын төрөлжсөн нарийн мэргэжлийн эмчийн тусламж үйлчилгээг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс нэвтрүүлж эхэлсэн. Аймгийн хэмжээнд хавдрын нарийн мэргэжлийн эмчийн хяналтад байх шаардлагатай 713 иргэн байдаг бөгөөд хавдрын нарийн мэргэжлийн эмчийн амбулаторийн тусламж үйлчилгээг эхлүүлснээс хойш 102 иргэн үзлэгт хамрагдсан байна. Нүүдлийн амбулаторийн тоноглогдсон автомашин нь 3.4 тэрбум төгрөгийн өртөгтэй бөгөөд техникийн тодорхойлолт бүхий саналыг Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн. |
| **1.1.1.2** | | Хүн амын дундах зонхилон тохиолдох өвчлөлийг бууруулна. | Зүрх судасны тогтолцооны өвчлөл | Промиль | 2024 | 3726.7 | 3720.2 | 3678.8 | 100 | - | - | - | 2025 онд Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Улсын гуравдугаар төв эмнэлэг, МҮОНРТ, ХААН банктай хамтран “Цусны даралт ихсэлтийн эсрэг аян”-ыг зохион байгуулж, 16 сумын 2097 иргэнийг зүрх судасны өвчлөл, цусны даралт ихсэлтийн эрсдэлийн үнэлгээ, нарийн мэргэжлийн үзлэг оношилгоонд хамруулллаа. Мөн ДЭМБ-ын МонПэн төслийг хэрэгжүүлэх сургалтад 50 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. “Зүрхээ хамгаалах”, “Тархины харвалтын эсрэг дэлхийн өдөр”-ийн хүрээнд цусны даралт, холестерины хэмжилт, эрүүл хооллолт, идэвхтэй хөдөлгөөн, хорт зуршлаас зайлсхийх, давсны хэрэглээг бууруулах чиглэлээр мэдээлэл, сурталчилгааг цахим хуудсаар дамжуулан иргэдэд хүргэлээ. Үүний үр дүнд 2025 оны 10 дугаар сарын статистик мэдээгээр 10000 хүн амд ногдох зүрх судасны өвчлөл 3678.8 болж буурсан байна. |
| | | | Хоол боловсруулах тогтолцооны өвчлөл | Промиль | 2024 | 1790.2 | 1789.2 | 3005.3 | 0 | - | - | - | 2025 онд хоол боловсруулах тогтолцооны өвчлөлөөс сэргийлэх чиглэлээр ЭМЯ, НЭМҮТ-өөс зарласан “САХАРГҮЙ 30 ХОНОГ CHALLENGE”-д нэгдэж, “ДОЛОО ХОНОГИЙН НЭГ ӨДРИЙГ ЧИХЭРТЭЙ” арга хэмжээг эрүүл мэндийн байгууллага, ерөнхий боловсролын сургуулиудад зохион байгууллаа. “Сахарын хэрэглээнээс татгалзъя” сэдвээр 7 төрлийн постер, 3 төрлийн видео бичлэгийг түгээж, 350 гаруй хүүхдэд мэдлэг олгосон. Мөн “Тэнцвэртэй хооллолт”, “Эрүүл бус хүнсний хэрэглээ” сургалтыг 22 удаа явуулж, 489 иргэнийг хамруулан 2 төрлийн гарын авлагыг 174 иргэнд тараасан. Эрүүл мэндийн байгууллагуудын цахим хуудсанд 15 төрлийн постер, 4 видео бичлэг байршуулан иргэдэд хүргэв. 2025 оны 10 дугаар сарын байдлаар 10000 хүн амд ногдох хоол боловсруулах тогтолцооны өвчлөл 3005.3 промиль байна. |
| | | | Хожуу үедээ оношлогдсон хорт хавдрын өвчлөлийн эзлэх хувь | хувь | 2024 | 49.6 | 44.1 | 72.1 | 0 | - | - | - | 2025 оны эхний 10 сарын байдлаар 122 хорт хавдар өвчин оношлогдсоны 34 буюу 27.8 хувь нь эрт үедээ, 88 буюу 72.1 хувь нь хожуу үедээ оношлогдож, эмчилгээнд хамрагдсан. |
| | | | Осол гэмтлийн өвчлөл | Промиль | 2024 | 161.0 | 141.0 | 172.6 | 0 | - | - | - | 2025 онд хүн амыг осол гэмтлээс сэргийлэх чиглэлээр “Аюулгүй байдлын төлөө үгээ хэлцгээе” үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу осол гэмтлээс урьдчилан сэргийлэх сарын аяныг зарлаж, “Түлэгдэлтийн үед үзүүлэх тусламж үйлчилгээ”, “Ахуйн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх”, “Бага насны хүүхдийг хахалтаас сэргийлэх нь” сэдвээр цуврал сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулан 447 хүнийг сургалтад хамруулж, 2574 хүнд зөвлөмж, мэдээлэл түгээв. Мөн “Цус алдалтын үед үзүүлэх анхны тусламж”, “Гэмтлийн үеийн тээвэрлэлт”, “Гэр бүлийн хүчирхийлэл” сэдвээр 9 байгууллагын 56 албан хаагчийг хамруулсан сургалт явуулсан. Эхний 10 сарын статистик мэдээгээр 10,000 хүн амд ногдох осол гэмтлийн өвчлөл 172.6 болж, суурь түвшнээс 11.6 промилиор өссөн үзүүлэлттэй байна. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Сүрьеэгийн өвчлөл | Өвчлөлийн түвшин | 2024 | 4 | 4 | 3 | 100 | - | - | - | Сүрьеэ илрүүлэх үзлэг, оношилгоог хиймэл оюун ухаанд суурилсан тоног төхөөрөмжийн тусламжтайгаар Баяннуур, Рашаант, Дашинчилэн, Гурванбулаг, Баян-Агт, Тэшиг, Хутаг-Өндөр, Сэлэнгэ, Бугат, Хангал сум, Хялганат тосгонд зохион байгуулан 1709 хүнийг хамрууллаа. Үүнээс 30 сэжигтэй тохиолдолд онош баталгаажуулах арьсны сорил тавьж, 99.0 хувийг рентген шилжилгээнд хамруулж, 147 иргэний гэрт очиж айлаас айлд тусламж үйлчилгээг үзүүллээ. Эрт илрүүлэг үзлэгээр 4 өвчлөл шинээр илрүүлэн, эмчилгээнд хамруулсан. Эхний 10 сарын статистик мэдээгээр 10000 хүн амд ногдох сүрьеэгийн өвчлөл 3.2 байгаа нь суурь түвшнээс 0.8 промилиэр буурсан үзүүлэлттэй байна. |
| 1.1.2.1 | **Үйл ажиллагаа** | Эмнэлгийн тусламж үйлчилгээнд шаардлагатай тоног, төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлж, барилга байгууламжийн их засвар, өргөтгөл, шинэчлэлийг хийж, стандартын шаардлагад нийцүүлнэ. | Барилга, байгууламжийн тоо | тоо | 2024 | 5 | 5 | 7 | 100 | 1,927 | 1,927 | 100 | Азийн хөгжлийн банк, орон нутгийн төсвийн 2024 оны 6.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Дашинчилэн сумын ЭМТ-ийн 15 ортой барилгын ажил дуусаж ашиглалтад өгсөн. Мөн 2025 онд орон нутгийн төсвийн 1,927.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар эрүүл мэндийн салбарын 7 барилга, байгууламжид их засвар хийгдэв. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн барилгын Б блокийн хэсгийн засвар 350.0 сая төгрөг, Хангал сумын ЭМТ-ийн барилгын засвар 305.0 сая төгрөг, Тэшиг сумын ЭМТ-ийн барилгын засвар 400.0 сая төгрөг, Сайхан сумын ЭМТ-ийн 2 барилгыг ариутгах татуургын төвлөрсөн шугамд холбох ажил 68.0 сая төгрөг, Могод сумын ЭМТ-ийн моорог, гражийн барилгын ариутгах татуурга, цэвэр ус, цахилгаан хангамжийн ажил 104.0 сая төгрөг, Булган сумын “Эмийн цэцэглэн” өрхийн эрүүл мэндийн төвийн дулаан, цэвэр усны шугамыг төвлөрсөн системд холбох ажил 300.0 сая төгрөг, Нэгдсэн эмнэлгийн 2 барилгад лифт угсарч суурилуулах ажил 400.0 сая төгрөгөөр хийгдэж, 100 хувь ашиглалтад оруулав. 2026 оны улсын төсөвт Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 38,669.0 сая төгрөгийн өртөг бүхий 100 ортой өргөтгөлийн барилгын 7,650.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт батлагдаад байна. |
| | | | Нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалт | хувь | 2024 | 90.0 | 92.0 | 93.2 | 100 | 523.5 | 523.5 | 100 | Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын 192.0 сая төгрөгийн санхүүжилтээр 16 сумын эрүүл мэндийн төвийг 8 нэр төрлийн 16 ширхэг Мобайл технологийн төхөөрөмжөөр хангасан. Улсын төсвийн 126.0 сая төгрөгийн санхүүжилтээр хүүхдийн тусламж үйлчилгээнд шаардлагатай зүрхний цахилгаан бичлэгийн аппаратыг 16 сум, 1 тосгоны 18 эрүүл мэндийн төв, Сайхан сумын ЭМТ-д 35.0 сая төгрөгийн ЭХО аппарат, аймгийн нэгдсэн эмнэлэгт 30 ширхэг тэргэнцэр, нярайн шарлалтын аппарат, Сэлэнгэ сумын ЭМТ-д 5.5 сая төгрөгийн шүдний эмчилгээний багаж, Тэшиг сумын ЭМТ-ийн шүдний кабинетыг 5.0 сая төгрөгийг багаж хэрэгслээр тус тус хангалаа. Орон нутгийн төсвийн 160.0 сая төгрөгийн санхүүжилтээр аймгийн Нэгдсэн эмнэлэгт гемодиализын 2 аппарат, шүдний тоног төхөөрөмж 2 ширхэгийг тус тус суурилуулснаар эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмжийн хангалт 93.2 хувьд хүрч суурь түвшнээс 3.2 пунктээр нэмэгдсэн байна. |
| | | | Түргэн тусламжийн автомашины парк шинэчлэлт | хувь | 2024 | 76.2 | 80.0 | 77.2 | 26.3 | 320 | 25 | 7.8 | Баян-Агт сумын эрүүл мэндийн төв иргэдийн хандив, тусламжийн 25.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар түргэн тусламжийн автомашинаар хангагдсан. 2025 онд 4 сумын эрүүл мэндийн төвийн автомашины парк шинэчлэлт хийгдэхээс 1 байгууллага хангагдсан. |
| | | | Хиймэл оюун ухаан (Cervicare AI)-ы оношилгоонд хамрагдсан иргэд | тоо | 2024 | 1200 | 1400 | 680 | 48.6 | - | - | - | Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийг хиймэл оюун ухаан дээр суурилсан “CERVICARI AI” аппаратаар умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэгт хамруулах явуулын үзлэг, оношилгоог Могод, Баяннуур, Дашинчилэн, Рашаант, Гурванбулаг суманд зохион байгуулж, 334 эмэгтэйг хамруулсан. Мөн Нэгдсэн эмнэлгийн эмэгтэйчүүдийн зөвлөгөө өгөх кабинетаар 312 эмэгтэй үзлэгт хамрагдсан. 2025 онд нийт 680 эмэгтэй тус үзлэгт хамрагдаж, 525 эмэгтэй хэвийн, 155 эмэгтэй эс болон эдийн шинжилгээ өгөх шаардлагатайг илрүүлж, эсийн шинжилгээнд 113 эмэгтэй, эдийн шинжилгээнд 10 эмэгтэйг хамруулж, оношийг тодруулан эмчилгээнд хамруулсан. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **1.1.2.2** | | Хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан болсон хавдрын өвчлөлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, эмчлэн эрүүлжүүлэхэд чиглэсэн "Эрүүл Булган" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | Хөтөлбөрийн хэрэгжилт | Хувь | 2024 | 0 | 70 | 50 | 71.4 | 150 | 150 | 100 | "Эрүүл Булган" хөтөлбөрийг 4 зорилт 47 арга хэмжээтэйгээр төлөвлөн Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын VI/32 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжүүлж байна. Хавдар судлалын үндэсний төвтэй хамтран ажиллах санамж бичиг байгуулж, аймгийн Нэгдсэн эмнэлэгт хавдрын тасгийг байгуулан, хавдар судлал, хими эмчилгээний 1 эмчийг бэлтгэн ажиллуулж, амбулаториор 1345 хүнд эмнэлгийн болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлсэн байна. Энэ онд хавдрын 144 тохиолдол бүртгэгдсэнээс 24.5 хувийг эрт үед нь илрүүлэн, эмчилгээнд бүрэн хамрууллаа. 2025 онд аймгийн хэмжээнд эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалт 50.5 хувьд хүрч, өмнөх оноос 7.3 пунктээр нэмэгдсэн байна. "Эрүүл шүд" арга хэмжээний хүрээнд "Мишээл сан"-тай хамтран 2 сумын 1381 хүүхдийг хамруулан, шүдний цоорол илэрсэн хүүхдүүдийн 90 хувийг эмчилсэн. Мөн Япон-Азийн эрүүл мэндийг дэмжих байгууллага, "Ц.Бадрал сан", АШУИС-ийн Нүүр ам судлалын сургууль хамтран үзлэг зохион байгуулж, 1187 хүүхдэд шүдний үзлэг, зөвлөгөө, эмчилгээ хийгдсэн. Үүнээс тусгай хэрэгцээт 4 хүүхдэд шүдний тусламж үйлчилгээ үзүүлсэн. 2025 оны эхний 10 сарын байдлаар шүдний кабинетийн үйл ажиллагаа явуулж байгаа эрүүл мэндийн байгууллагууд 5700 хүүхдийн шүдийг эмчлэн эрүүлжүүлсэн байна. Нийгмийн эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгааны арга хэмжээг идэвхжүүлж, 136 удаагийн танхимын сургалтад 9106 иргэн, цахим сургалтад 6423 иргэн, нийт давхардсан тоогоор 15529 иргэнийг хамруулсан. Мөн цахим орчинд эрүүл мэндийн мэдлэг, боловсрол олгох 252 төрлийн контент байршуулж, 47684 хүн хандалт хийсэн байна. |
| **1.1.3.1** | | Эмнэлгийн мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх, давтан, гадаад, дотоодод сургах замаар эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэн, залгамж халааг бэлтгэнэ. | Сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний тоо | тоо | 2024 | 46 | 12 | 22 | 100 | - | - | - | Эрүүл мэндийн байгууллагуудын хүний нөөцийн хангалтыг нэмэгдүүлэх зорилгоор 2025 онд хүүхэд судлал, дүрс оношилгоо, мэдээгүйжүүлэг, хавдрын хими, дотоод шүүрэл зэрэг 20 чиглэлээр 22 эмч, сувилагч мэргэжилтэн төгсөлтийн дараах 3 сараас 2 жил хүртэлх хугацааны төрөлжсөн, мэргэшил дээшлүүлэх сургалтад хамрагдаад байна. Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуультай хамтран халдварт бус өвчин, эх, хүүхдийн эрүүл мэндийн чиглэлээр чадавхжуулах сургалтыг зохион байгуулж, 44 багийн эмч хамрагдсан нь нийт багийн эмч нарын 95.6 хувь байна. |
| | | | | тоо | 2024 | 19 | 7 | 18 | 100 | 10 | 8 | 80 | Өндөр хөгжилтэй оронд эмч, эмнэлгийн мэргэжилтнийг сургах, мэдлэг, ур чадварыг сайжруулах зорилгоор эрүүл мэндийн удирдлага, чих хамар хоолой, нүдний өвчин судлал, өрхийн анагаах ухаан, дүрс оношилгоо чиглэлээр БНСУ, БНХАУ, БНЭУ, Казакстан зэрэг улсад 7 чиглэлээр 18 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаад байна. |
| **1.1.3.2** | | Эрүүл мэндийн салбарын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны нийгмийн баталгааг сайжруулж, орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтанд олгох дэмжлэг, урамшууллыг нэмэгдүүлнэ. | Дэмжлэг үзүүлсэн үйл ажиллагаа | тоо | 2024 | 2 | 4 | 4 | 100 | | | | Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн нийгмийн баталгааг хангах, тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор 20 албан хаагчдад зуслангийн газар олгож, 28 албан хаагчид амьдрах байраар хангах, орон байрны түрээсэд дэмжлэг үзүүлэх, цахилгаан, дулааны төлбөр, өвлийн идэш зэрэг бодит дэмжлэг үзүүлж, 419 албан хаагчийг илрүүлэг үзлэгт хамруулж, нийт 340.0 сая төгрөг зарцуулагдсан. |
| | | | Эрүүл мэндийн салбарын албан хаагч | тоо | 2024 | 10 | 20 | 28 | 100 | | | | Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн нийгмийн баталгааг хангах, тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор 28 албан хаагчид дэмжлэг үзүүлсэн нь суурь түвшнээс 18 албан хаагчаар нэмэгдсэн байна. |
| | | | Зарцуулсан хөрөнгө | сая төгрөг | 2024 | 7.3 | 40.0 | 392 | 100 | 340 | 392 | 100 | Эрүүл мэндийн салбарын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг сайжруулж, орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтанд хуулийн дагуу олгох дэмжлэг, урамшуулалд 340.0 сая төгрөг, өндөр хөгжилтэй оронд эмч, эмнэлгийн мэргэжилтнийг орон байр, хоол унд, хэрэглээний зардалд 52.0 сая, нийт улс, орон нутгийн төсвөөс 392.0 сая төгрөг зарцуулсан байна. |
| **Боловсрол** | | | | | | | | | | | | | |
| **1.2** | **ТЕЗ** | Бүх шатны боловсролын хүртээмж, чанар, үр дүнг нэмэгдүүлнэ. | СӨБ-ын гүйцэтгэлийн үнэлгээний дундаж | Хувь | 2023 | 88.6 | 89.5 | 91.7 | 100 | - | - | - | Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээнд 22 цэцэрлэг үнэлэгдэж, үүнээс 8 цэцэрлэг буюу 36.3 хувь нь урамшуулалд хамрагдсан ба гүйцэтгэлийн үнэлгээний дундаж 91.7 хувьтай дүгнэгдэж, өмнөх оноос 3.1 пунктээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. |
| | | | ЕБС-ийн гүйцэтгэлийн үнэлгээний дундаж | Хувь | 2024 | 73.05 | 74.0 | 79.18 | 100 | - | - | - | Ерөнхий боловсролын сургуулийн гүйцэтгэлийн үнэлгээнд 20 сургууль үнэлэгдэж, үүнээс 1 сургууль урамшуулалд хамрагдсан. Аймгийн ерөнхий боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэлийн дундаж 79.18 хувьтай дүгнэгдэж, өмнөх оноос 6.13 пунктээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.2.1 | | Сургууль, цэцэрлэг, дотуур байр, спорт заал, Политехник коллежийн барилга байгууламжийн хүчин чадал, тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлж, сургалтын тохируулгат орчныг бий болгоно. | Цэцэрлэгийн барилга байгууламжийн хүчин чадал | Ор | 2024 | 3065 | 3190 | 3200 | 100 | 2,634.5 | 2,634.5 | 100 | Рашаант суманд 75 ортой цэцэрлэгийн барилгын өргөтгөл, Булган суманд тусгай хэрэгцээт хүүхдийн яслийн 60 ортой шинэ барилга ашиглалтад орсноор нийт 135 ор нэмэгдээд байна. |
| | | | Ерөнхий боловсролын сургуулийн барилга байгууламжийн хүчин чадал | Суудлын тоо | 2024 | 10525 | 10525 | 10525 | 100 | 5,959.6 | 5,959.6 | 100 | Сайхан сумын сургуулийн 320 хүүхдийн суудалтай барилгын ажил 2,844.1 сая төгрөгийн төсөвт өртгөөр хийгдэж байгаа бөгөөд ажлын явц 45 хувьтай, Баян-Агт сумын сургуулийн 320 хүүхдийн суудалтай барилгын ажил 2,238.6 сая төгрөгийн төсөвт өртгөөр хийгдэх ба ажлын явц 20 хувьтай, 2026 оны 3-р улиралд ашиглалтад орно. Мөн Баяннуур сумын ерөнхий боловсролын сургуулийн өргөтгөл 876.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж барилгын ажил 75 хувьтай байна. |
| | | | Сургуулийн дотуур байрны барилга байгууламжийн хүчин чадал | Ор | 2024 | 1920 | 2200 | 1920 | 0 | 1,498.1 | 630.3 | 42.1 | Хангал сумын Хялганат тосгоны сургуулийн 150 ортой дотуур байрны барилга 3,343.3 сая төгрөгийн төсөвт өртгөөр хийгдэж байгаа бөгөөд ажлын явц 15 хувьтай, газар шороо суурийн ажил хийгдэж дууссан. Техникийн зогсолт 2024 оны 10 дугаар сараас хийж, ажил зогссон тул ажлыг эхлүүлэх албан шаардлага хүргүүлж, гэрээг цуцалсан. |
| | | | Тоног төхөөрөмжийн хангалт | Хувь | 2024 | 75.0 | 80 | 78 | 60 | 973.5 | 973.5 | 100 | Улсын төсвөөс 296.3 сая төгрөг, сум, орон нутгийн төсвөөс 677.2 сая төгрөгийг зарцуулан сургууль цэцэрлэгийн тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүллээ. Тоног төхөөрөмжийн хангалт өмнөх оноос 3 пунктээр нэмэгдсэн байна. |
| | | | Стандарт шаардлага хангасан ариун цэврийн байгууламж | Тоо | 2024 | 61 | 70 | 70 | 100 | 1348.4 | 1348.4 | 100 | Хутаг-Өндөр сумын Уньт, Хантай баг, Сэлэнгэ сумын Атар багийн бага сургууль, 1 дүгээр сургуулийн дотуур байранд хийгдсэн стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг үүрэг даалгаврын биелэлтээр улсын комисс хүлээн авч, ашиглалтад бүрэн орсон. |
| 1.2.2 | Хөтөлбөрийн | Багш, удирдах ажилтны мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлнэ | Цэцэрлэгийн багшийн гүйцэтгэлийн үнэлгээний дундаж | Хувь | 2023 | 88.02 | 89 | 94.5 | 100 | | | | Цэцэрлэгийн багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд 22 цэцэрлэгийн 118 багш, 1519 хүүхэд оролцож, гүйцэтгэлийн дундаж 94.56 хувь болж, өмнөх оноос 6.54 пунктээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. |
| | | | Ерөнхий боловсролын сургуулийн багшийн гүйцэтгэлийн үнэлгээний дундаж | Хувь | 2024 | 82.1 | 83.1 | 76.5 | 0 | | | | Ерөнхий боловсролын сургуулийн багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд 20 сургуулийн 598 багш үнэлэгдэж, гүйцэтгэлийн дундаж 76.5 хувьтай дүгнэгдэж, өмнөх оноос 5.6 пунктээр буурсан үзүүлэлттэй, нийт багш нарын 42.9 хувь нь урамшууллад хамрагдаж байна. |
| | | | Тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр сургалтад хамрагдсан цэцэрлэгийн багш | тоогоор | 2023 | 135 | 140 | 168 | 100 | | | | 2025 оны хичээлийн жилд тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр 3 багш бэлтгэгдсэн. Сургуулийн өмнөх боловсролын сургалтын шинэчилсэн хөтөлбөрийн хүрээнд 18 эрхлэгч, 17 арга зүйч, 130 багшид тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажиллах арга зүйн талаар мэдээлэл, сургалтыг зохион байгуулж, шинэчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэгч сургагч багш нар бэлтгэгдсэн. |
| 1.2.3 | | Суралцагсдын сурлагын ахиц, | Элсэлтийн ерөнхий шалгалтын хэмжээст онооны дундаж | Оноо | 2024 | 509 | 512 | 491.7 | 0 | | | | 2025 оны элсэлтийн ерөнхий шалгалтад 10 судлагдахууны чиглэлээр 637 шалгуулагч оролцож хэмжээст онооны дундаж 491.7 байгаа нь өмнөх оноос 17.3 оноогоор буурсан. Элсэлтийн шалгалтын 10 судлагдахууны 5 буюу 50 хувь нь улсын дундаж онооноос дээгүүр үнэлэгдсэн. |
| | | | Бага боловсролын суралцагчдын монгол, хэл математикийн хичээлийн гүйцэтгэлийн дундаж | Хувь | 2024 | Математик-54.4 Монгол хэл - 57.6 | Математик-56.4 Монгол хэл - 59.7 | мате 49.4, Монгол хэл 49.8 | 0 | | | | 2025 оны багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд 22 сургуулийн бага ангийн сурагчдын математикийн хичээлийн гүйцэтгэлийн дундаж үнэлгээ 49.4 хувь буюу өмнөх оноос 5 хувиар, монгол хэлний хичээлийн гүйцэтгэлийн дундаж үнэлгээ 48.9 хувь буюу өмнөх оноос 8.7 пунктээр буурсан байна. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.2.3 | | амжилтыг дээшлүүлнэ | 9 дүгээр ангийн сурагчдын унших чадварын дундаж | Хувь | 2024 | 54 | 56 | 69.2 | 100 | | | | Сурагчдын сурлагын чанарыг ахиулах зорилгоор үндэсний бичиг, монгол хэл бичгийн масс олимпиад, мэргэжлийн хөгжлийн бүлгийн багш нарын сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж ажиллалаа. Аймгийн ерөнхий боловсролын сургуулиудын 9 дүгээр ангийн сурагчдын унших чадварын дундаж 69.2 хувь болж өмнөх оноос 15.2 пунктээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. |
| | | | 9 дүгээр ангийн сурагчдын математикийн хичээлийн гүйцэтгэлийн дундаж | Хувь | 2024 | 36.7 | 38.7 | 44.4 | 100 | | | | Математикийн багш нарын мэргэжлийн хөгжлийн бүлгийн сургалт зохион байгуулан мозайк интерактив хичээлийн платформыг хичээлд ашиглан эдүтен хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна. 2025 оны багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд түүврээр хамрагдсан 9 дүгээр ангийн сурагчдын математикийн хичээлийн гүйцэтгэлийн дундаж үнэлгээ 44.48 хувь болж өмнөх оноос 7.78 пунктээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. |
| 1.2.1.1 | | Багш, сурагчдын сурч, хөгжих орчныг сайжруулж, боловсролын байгууллагуудад шаардлагатай хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар шийдвэрлэн хүүхдэд ээлтэй сургалтын орчныг бүрдүүлнэ. | ЕБС-ийн хамран сургалт | Хувь | 2024 | 86.96 | 89.46 | 88.4 | 57.6 | 163.6 | 163.6 | 100 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 163.6 сая төгрөгийн 19 ширхэг зөөврийн комьютер, 8 ширхэг смарт телевиз, 6 ширхэг ухаалаг дэлгэц, 1 иж бүрэн физикийн кабинет, 2 биеийн тамирын хичээлийн багцыг ерөнхий боловсролын сургуульд хуваарилан хэрэглэгдэхүүнээр хангах орчин нөхцөлийг бүрдүүлснээр ерөнхий боловсролын сургуулийн бага боловсролын хамран сургалт 89 хувь буюу өнгөрсөн оноос 0.7 пункт, суурь боловсролын хамран сургалт 87.8 хувь буюу өнгөрсөн оноос 0.8 пунктээр тус тус өссөн үзүүлэлттэй байна. Бүлэг дүүргэлт 25 хүүхэд байгаа нь стандарт түвшинд байна. |
| | | | СӨБ-ын хамран сургалт | Хувь | 2024 | 84.28 | 86.3 | 87 | 100 | 677.2 | 677.2 | 100 | Сум орон нутгийн төсвөөс 677.2 сая төгрөгөөр иж бүрэн камер, дрож, дуу хөгжмийн тоног төхөөрөмж, ухаалаг самбар, STEAM хэрэглэгдэхүүнээр хангаж орчин нөхцөлийг бүрдүүлснээр сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 87 хувь (бохир жин) буюу өмнөх оноос 2.7 пунктээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Цэцэрлэгийн бүлэг дүүргэлт дунджаар 25 хүүхэдтэй байна. |
| | | | Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн ерөнхий боловсрол хамрагдалт | Хувь | 2024 | 89.3 | 90.3 | 32.9 | 0 | 0 | | | Аймгийн хэмжээнд 6-18 насны хөгжлийн бэрхшээлтэй 231 хүүхэд байгаагаас ерөнхий боловсролын сургуульд 76 хүүхэд, сургуулийн өмнөх боловсролд 25, нийт 101 хүүхэд суралцаж байна. Нийт 101 суралцагчаас эрэгтэй 66, эмэгтэй 35 байна. Бэрхшээлийн хэлбэрээр авч үзвэл харааны бэрхшээлтэй 13, сонсголын бэрхшээлтэй 10, хэл ярианы бэрхшээлтэй 5, оюун ухааны 9, аутизм 12, дауны синдром 2, хөдөлгөөний бэрхшээлтэй 20, хавсарсан бэрхшээлтэй 30 хүүхэд тус тус байна. 2024-2025 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд 76 хүүхэд, сургуулийн өмнөх боловсролд 19 хүүхэд хамрагдаж байсан ба сургуулийн өмнөх боловсролд хамруулсан хүүхдийн тоо өссөн дүнтэй байна. |
| 1.2.1.2 | | Бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг төрөлжүүлж, салбар дундын дадлага, үйлдвэрлэлийн баазыг байгуулна. | Шинээр нээгдсэн анги | Тоо | 2024 | 0 | 1 | 1 | 100 | | | | Булган аймаг дахь Политехникийн коллежид 2025-2026 оны хичээлийн жилд "Мэдээллийн системийн мэргэжлийн анги" шинээр нээгдэж, 15 суралцагч суралцаж байна. |
| | | | Дадлага, үйлдвэрлэлийн бааз | Тоо | 2024 | 0 | 1 | 1 | 100 | 846.7 | 888.7 | 100 | Япон улсын Засгийн газрын "Өвсний үндэс" хөтөлбөрийн "Хүний аюулгүй байдлын хангах буцалтгүй тусламж"-ийн хүрээнд Политехникийн коллежийн дадлагын байранд 888.7 сая төгрөгөөр их засвар хийж, улсын комисс хүлээж авч ашиглалтад өгөөд байна. Үүний үр дүнд мэдээллийн систем, компьютерийн оператор, программ хөгжүүлэлтийг дадлага, үйлдвэрлэлийн лабораторийг шинээр байгуулан, төмөр, даавуу, фото зэрэг 5 төрлийн бүтээгдэхүүн гаргаж байна. Мөн хоол үйлдвэрлэлийн дадлагын баазад 5 хүүхэд ажилладаг байсан бол 15 хүүхэд хамрагдах боломжтой болсон. |
| | | СӨБ, ЕБС-иудад стандартын шаардлагад нийцсэн ариун | Барилга, байгууламжийн тоо | тоо | 2024 | 1 | 3 | 3 | 100 | 10092.2 | 9224.4 | 91.4 | 2025 онд улсын төсвөөс 33,963.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 сургуулийн барилга, 3 цэцэрлэг, 2 дотуур байрны ажил хийгдэж байна. Тухайлбал: Сайхан, Баян-Агт, Баяннуур сумын 3 сургуулийн барилгын ажил явагдаж байна. Булган сумын тусгай хэрэгцээт ясли /цэцэрлэг/, Рашаант сумын 75 ортой цэцэрлэгийн өргөтгөлийн барилгыг улсын комисс хүлээн авч ашиглалтад орсон. Мөн Хутаг-Өндөр сумын дотуур байрны барилга ашиглалтад орсон. Булган сумын 6-р цэцэрлэгийн барилгын тендерт гүйцэтгэгч шалгараагүй байна. Хялганат тосгоны дотуур байрны барилгын ажлыг төсвийн ерөнхийлөн захирагчаар гэрээ цуцлах асуудал хэлэлцүүлж гэрээ цуцлагдах шийдвэр гарсан. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **1.2.1.3** | | шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжийг бүрэн шийдвэрлэж, боловсролын салбарын өргөтгөл шинэчлэл засварын ажлыг хэрэгжүүлнэ. | Тоног төхөөрөмжийн хангалтын хувь | хувь | 2024 | 75.0 | 80 | 78 | 60 | 973.5 | 973.5 | 100 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 163.6 сая төгрөгийн 19 ширхэг зөөврийн комьютер, 8 ширхэг смарт телевиз, 6 ширхэг ухаалаг дэлгэц, 1 иж бүрэн физикийн кабинет, 2 биеийн тамирын хичээлийн багцыг ерөнхий боловсролын сургуульд хуваарилсан байна. Сум орон нутгийн төсвөөс нийт 677.2 сая төгрөгөөр сурууль цэцэрлэгийн иж бүрэн камер, дрож, дуу хөгжмийн тоног төхөөрөмж, бага ангийн цахим кабинет, ухаалаг самбар, STEM хэрэглэгдэхүүнээр хангасан байна. |
| | | | Стандарт шаардлага хангасан ариун цэврийн байгууламж | Тоо | 2024 | 82 | 5 | 5 | 100 | 1348.4 | 1348.4 | 100 | Хутаг-Өндөр сумын Уньт, Хантай баг, Сэлэнгэ сумын Атар багийн бага сургууль, 1 дүгээр сургуулийн дотуур байранд хийгдсэн стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг үүрэг даалгаврын биелэлтээр улсын комисс хүлээн авч, ашиглалтад бүрэн орсон. |
| **1.2.2.1** | | Багш мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх, гадаад, дотоодод сургах, туршлага судлуулах замаар суралцагчийн хөгжлийн хэрэгцээ шаардлагыг хангасан, чадварлаг багшийг бэлтгэнэ. | Сургалтад хамрагдсан багш ажилчид | Тоо | 2024 | 1440 | 1500 | 1557 | 100 | 90 | 100 | 100 | 2025-2026 оны хичээлийн жилийн багш нарын бага хурал, семинарт 680 багш удирдах ажилтан, математик, мэдээллийн технологийн багш нарын сургалтад 55 багш, сургуулийн дотуур байрын багш, эмч, нийгмийн ажилтныг чадваржуулах сургалтад 65 албан хаагч, амжилтын гараа хөтөлбөрийн сургалтад 207 бага ангийн багш, англи хэлтэй Булган хөтөлбөрийн сургалтад 67 багш, СӨБ-ын шинэчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх сургалтад цэцэрлэгийн 135 багш, удирдах ажилтан, мозайк цахим системийн сургалтад давхардсан тоогоор 120 багш, удирдах ажилтан, 2025-2026 оны хичээлийн жилд баримталж ажиллах дүрэм журмын танилцуулга сургалтад давхардсан тоогоор 228 удирдах ажилтан, нийт 1557 албан хаагчийг хамрууллаа. |
| | | | Туршлага судалсан багш, ажилчид | Тоо | 2024 | 60 | 65 | 956 | 100 | 5 | 5 | 100 | 2025 оны багш нарын бага хурлын үед зохион байгуулагдсан салбар бүлгийн уулзалтаар ерөнхий боловсролын сургуулийн 36 сургалтын менежер сайн туршлага солилцож хэлэлцүүлэг өрнүүллээ. Мөн Хишиг-Өндөр сумын ерөнхий боловсролын сургуулийн "Унших чадварыг дэмжих арга зүй"-г аймгийн нийт 800 гаруй багшид түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгууллаа. Бага боловсролын багш, менежерүүдийн туршлага солилцох өдөрлөгийг зохион байгуулж 120 албан хаагчийг хамруулж, нийт 956 багш, удирдах ажилтан хамрагдсан байна.<br>2025 оны 10-р сарын 28-31-ний өдрийн хооронд ЕБС-ийн нийгмийн ажилтан нарыг чадавхжуулах, шинэ технологийг ашиглах нь сургалтыг Бүгд Найрамдах Буриад Улсын "Бурятсъий республиканский педагогический колледж"-тай хамтран зохион байгууллаа. |
| **1.2.2.2** | | Багш нарын нийгмийн баталгааг сайжруулж, орон нутагт ажиллаж байгаа багш нарт олгох дэмжлэг, урамшууллыг нэмэгдүүлнэ. | Дэмжлэг үзүүлсэн үйл ажиллагаа | тоо | 2024 | 1 | 3 | 4 | 100 | | | | 2025 онд БНСУ-д 20 багш, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Бугат хотын Ажил мэргэжлийн дээд сургуульд Политехникийн коллежийн 3 багш, ОХУ-д боловсролын сургалтын байгууллагын 11 хөгжмийн багш, 3 захирал, 28 технологийн багшийг мэргэжил дээшлүүлэх, туршлага судлах үйл ажиллагаанд хамруулсан.<br>2025 оны 10-р сарын 28-31-ний өдрийн хооронд ЕБС-ийн нийгмийн ажилтан нарыг чадавхжуулах, шинэ технологийг ашиглах нь сургалтыг Бүгд Найрамдах Буриад Улсын "Бурятсъий республиканский педагогический колледж"-тай хамтран зохион байгууллаа. |
| | **Үйл ажиллагаа** | | Дэмжлэг, урамшуулалд хамрагдсан албан хаагч | тоо | 2024 | 40 | 45 | 69 | 100 | | | | 2025 онд орон нутгийн төсвөөс БНСУ-д туршлага судалсан 20 багшид 20.0 сая, элсэлтийн шалгалтад амжилт гаргасан 1 багшид 1.0 сая, боловсролын салбарын шилдэг 3 алба хаагчид тус бүр 1.0 сая төгрөг, нийт 25.0 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүллээ. Мөн 20 сургуулийн 45 албан хаагчид улс, орон нутгийн төсвөөс 18.4 сая төгрөгийн мөнгөн дэмжлэг үзүүлсэн байна. |
| | | | Зарцуулсан хөрөнгө | сая.төг | 2024 | 114.5 | 115.0 | 97 | 100 | 43.4 | 43.4 | 100 | 2025 оны хичээлийн жилд 69 албан хаагчид 97.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. |
| | | | Англи хэлний сурлагын чанар | хувь | 2024 | 41 | 42 | 56.3 | 100 | | | | 2025 оны багшийн гүйцэтгэлийн үнэлгээний бичгийн шалгалтын түгвэрт англи хэлний хичээлээр хамрагдсан суралцагчдын гүйцэтгэлийн үнэлгээний дундаж 56.3 хувьтай дүгнэгдэж, өмнөх оноос 15.3 пунктээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. |
| | | | Математикийн сурлагын чанар | хувь | 2024 | 37.6 | 39 | 38.05 | 32.1 | | | | 2025 оны багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд математикийн хичээлээр хамрагдсан сурагчдын гүйцэтгэлийн дундаж үнэлгээ 38.05 хувьтай гарч өмнөх оноос 0.45 пунктээр нэмэгдсэн байна. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **1.2.3.1** | | Дэлхийд өрсөлдөх чадвартай иргэнийг бэлтгэх зорилгоор математик, мэдээлэл зүй, англи хэлний судлагдахууныг түлхүү анхаарч, "Код бичих хөтөлбөр", "Англи хэлтэй Булган" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | Мэдээлэл зүйн сурлагын чанар | хувь | 2024 | 43.3 | 48.3 | 51.9 | 100 | | | | 2025 оны багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд мэдээллийн технологийн хичээлээр хамрагдсан сурагчдын гүйцэтгэлийн дундаж үнэлгээ 51.9 хувьтай гарч өмнөх оноос 8.6 пунктээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. |
| | | | Хөтөлбөрийн хэрэгжилт | хувь | 2024 | 0 | 75 | 25 | 33.3 | 635 | 199.9 | 31.4 | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 77 дугаар тогтоолоор батлагдсан "Код бичих" хөтөлбөрийн 2025 оны төлөвлөгөөг боловсруулсан. Хөтөлбөрийн хүрээнд Булган сумын 3 дугаар сургуульд математик, мэдээлэл зүйн 1 цахим кабинетийг байгуулав. "Англи хэлтэй Булган" хөтөлбөрийн 2025-2028 онд хэрэгжүүлэх 36 арга хэмжээ, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж үйл ажиллагааг эхлүүлээд байна. 2025 оны 7-10 дугаар сард нийт 18 арга хэмжээг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн. Хөтөлбөрийн хэрэгжилт 2025 оны 10-р сарын байдлаар 50 хувьтай хэрэгжиж байна. Хөтөлбөрийн хүрээнд "Монголын англи хэлний академи"-тай хамтран ажиллах "Санамж бичиг"-ийг байгуулснаар ерөнхий боловсролын сургуулийн багш, сурагчид болон төрийн албан хаагчдад зориулсан сургалтад 156 иргэн, хүүхдийн “Жаргалант” зусланд амрагч 149 хүүхэд, англи хэлний 67 багш, ахлах ангийн 42 суралцагчийн англи хэлний мэдлэг чадварыг сайжруулах, IELTS, TOEFL оноотой болоход дэмжлэг үзүүлэх сургалтад 80 сая, Гурванбулаг сумын ерөнхий боловсролын сургуульд цахим танхимын 80 сая, зуны зуслангийн сурагчдын англи хэлний сургалтад 19.9 сая, нийт 179.9 сая төгрөгийг зарцуулаад байна. |
| **1.2.3.2** | | Сургуулийн өмнөх боловсролд шинжлэх ухаан, инженерчлэл, математик, технологи, уран бүтээл хийх, амьдрах ухаан, ур дүй хөгжүүлэх STEAM үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. | Цэцэрлэгийн тоо | тоо | 2024 | 1 | 5 | 9 | 100 | 40 | 167.6 | 100 | 2024–2025 оны хичээлийн жилд байгууллага, сум орон нутгийн удирдлагуудтай хамтран орон нутгийн төсвийн 134.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 22 цэцэрлэгийн 9 нь STEAM хэрэглэгдэхүүнтэй болж, сургалтын үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тус 9 цэцэрлэгийн дунд аймгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулагдаж, Булган сумын 7 дугаар цэцэрлэг тэргүүлэн улсын аварга шалгаруулах тэмцээнд III байр эзэлж, Тайвань улсад болсон “GREEN MECH–2025” олон улсын тэмцээнд оролцож, тусгай байр эзэлсэн амжилт гаргалаа. Тус тэмцээнд оролцоход 5.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэв. Хөтөлбөрийн хүрээнд STEAM үйл ажиллагааг дэмжих зорилгоор баг тамирчдад 7.5 сая төгрөг, мөн STEAM зардлаас 22 цэцэрлэгт 28.6 сая төгрөгийн AR сургалтын хэрэглэгдэхүүн хүлээлгэн өгсөн. |
| **1.2.3.3** | | Бага боловсролыг дэмжих “Амжилтын гараа” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | Хөтөлбөрийн хэрэгжилт | хувь | 2024 | 0 | 90 | 10 | 11.1 | 15 | 5.7 | 38 | Аймгийн ИТХ-ын 76 дугаар тогтоолоор “Амжилтын гараа” хөтөлбөр батлагдаж, 35 үйл ажиллагаатай төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг зохион байгуулж байна. Хөтөлбөрийн нээлтийг Хишиг-Өндөр сум, Сайхан суманд 2 бүсээр зохион байгуулж нийт 656 багш, сургалтын менежер хамрагдаж, 10 гаруй албан хаагч, сургагч багш нар мэргэжлийн зөвлөгөө, арга зүйн дэмжлэг үзүүллээ. Арга хэмжээний явцад 25 багш сайн туршлагаа түгээн дэлгэрүүлж, хөтөлбөрийн хэрэгжилтэд нийт 5.7 сая төгрөг зарцууллаа. |
| **1.2.3.4** | | Суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжааг олгож, мэргэжлийн эрх олгох, сонгох боломжтой төрөлжсөн ахлах сургуулийг бий болгож, бодлогоор дэмжинэ. | Төрөлжсөн ахлах сургууль | тоо | 2024 | 0 | | | ХБ | | | | Аймгийн хэмжээнд 15 сургуулийн 8-12 дугаар ангийн суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох чиглэлээр мэргэжил сонголт хэлэлцүүлгийг зохион байгуулж нийт 2104 суралцагч хамрагдлаа. |
| **1.2.3.5** | | Элсэлтийн ерөнхий шалгалтын хэмжээст оноог улсын дунджаас нэмэгдүүлнэ. | Хэмжээст онооны дундаж | Оноо | 2024 | 509 | 511 | 491.7 | 0 | 17.1 | 17.1 | 100 | 2024-2025 оны хичээлийн жилийн элсэлтийн ерөнхий шалгалтын бэлтгэл ажлын хүрээнд "Булганы сорил 2025" арга хэмжээг зохион байгуулж, бүлгээр болон ганцаарчилсан сэтгэл зүйн зөвлөгөө, шалгалтын судлагдахууныг сонгох сургалтад 12 дугаар анги төгсөж байгаа 480 сурагчийг хамруулсан. 2025 оны элсэлтийн ерөнхий шалгалтад 10 судлагдахууны чиглэлээр 637 шалгуулагч оролцож хэмжээст онооны дундаж 491.7 буюу өмнөх оноос 17.3 оноогоор буурсан байна. Элсэлтийн ерөнхий шалгалтын хэмжээст онооны дундаж улсын дундажтай харьцуулахад 8.5 оноогоор бага байна. Элсэлтийн шалгалтын 10 судлагдахууны 5 нь улсын дунджаас дээш үнэлэгдсэн байна. |
| | | Жил бүр 12 дугаар анги төгсөгчдөөс аймагт нэн шаардлагатай мэргэжлээр | Дотоодын тэтгэлэгт хамрагдсан оюутан | Тоо | 2024 | 74 | 94 | 126 | 100 | 220 | 211.5 | 96.1 | 2025 онд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын VIII/56 дугаар тогтоолоор батлагдсан "Засаг даргын нэрэмжит сургалтын төлбөрийн тэтгэлэг олгох, урамшуулал, дэмжлэг үзүүлэх журам"-ын дагуу 2024-2025 оны хичээлийн жилд элсэлтийн ерөнхий шалгалтын оноо, олимпиад, урлаг, спортын амжилтаар тэргүүлсэн болон зорилтот өрхийн болон төгсөх курсийн 33 оюутан, "Эрдэнэт цогцолбор" дээд сургуульд элссэн 19, нийт дотоодын их, дээд сургуульд элссэн 52 оюутанд 211.5 сая төгрөгийн сургалтын төлбөрийн тэтгэлэг олгосон. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.2.3.6 | | гадаад, дотоодын их дээд сургуульд суралцах боломжийг бүрдүүлэн тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлнэ. | Гадаадын тэтгэлэгт хамрагдсан оюутан | Тоо | 2024 | 87 | 89 | 87 | 97.7 | 360 | 591 | 100 | Орон нутагт нэн шаардлагатай хүний нөөцийн хангалтыг нэмэгдүүлэх, гадаад хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор гурвалсан гэрээгээр суралцаж, гэрээний нөхцөлийг хангасан гадаадын их, дээд сургуульд суралцаж байгаа нийт 57 оюутанд 591 сая төгрөгийн сургалтын төлбөр, дотуур байрны төлбөрийн тэтгэлгийг орон нутгийн төсвийн хөрөнгөөр олгосон. Үүнд: БНСУ-ын Шинхан их сургуульд суралцаж буй 24, Хусо их сургуульд суралцах 18, ОХУ-ын Буриадын ХААИС-д суралцаж байгаа 15 оюутанд тэтгэлэг олгоод байна. |
| 1.2.3.7 | | Насан туршдаа суралцах, хөгжих боломжийг бүрдүүлнэ. | Боловсрол нөхөн олгосон хүний тоо | тоо | 2024 | бага -14 суурь -14 бүрэн дунд-16 | бага -17 суурь -17 бүрэн дунд-20 | бага-44 суурь-54 бүрэн дунд-59 | 100 | | | | Насан туршийн суралцахуйн төвийн дүйцсэн хөтөлбөрт бага боловсролын 44, суурь боловсролын 54, бүрэн дунд боловсролын 59, нийт 157 суралцагч хамрагдаж байна. |
| | | | | тоо | 2024 | 808 | 858 | 711 | 82.8 | | | | Цахим ур чадвар олгох 75 удаагийн сургалтад 25-45 насны давхардсан тоогоор 711 иргэнийг хамруулсан байна. |
| **Гэр бүл, хүүхэд, залуучууд** | | | | | | | | | | | | | |
| **1.3** | **ТЕЗ** | Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил хамгааллын тэгш оролцоог хангана. | Хамрагдсан иргэдийн хувь | Хувь | 2024 | 49.6 | 55 | 54.7 | 94.4 | | | | Гэр бүлийн хөгжлийг дэмжих гэр бүлийн боловсрол олгох сургалт нөлөөллийн ажилд 6848, жендэрийн эрх тэгш байдлыг хангах хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр 2080, хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд 15690 хүүхэд, 8340 залуусыг хамруулсан нь нийт хүн амын 54.7 хувийг эзэлж байна. |
| **1.3.1** | **Хөтөлбөрийн** | Хүүхэд, залуучуудын хөгжил оролцоог нэмэгдүүлнэ. | Хөгжил оролцоонд хамрагдсан нийт хүүхэд, залуучуудын тоо | Тоо | 2024 | 17790 | 20790 | 24030 | 100 | 40.0 | 39.9 | 99.7 | 2025 онд давхардсан тоогоор 15690 хүүхэд, 8340 залуус хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан нь аймгийн нийт хүүхдийн 74.3 хувь, нийт залуучуудын 51.3 хувьтай тэнцүү байна. |
| **1.3.2** | | Залуу гэр бүл амьдрах олон талт таатай нөхцөлийг бүрдүүлэх замаар шилжилт хөдөлгөөнийг бууруулж, хүн амын тогтвортой өсөлтийг дэмжинэ. | Нийт хүн амын тоо | Тоо | 2024 | 60437 | 61000 | 60130 | 0 | - | - | - | 2025 оны жилийн эцсийн байдлаар аймгийн нийт хүн амын тоо 60130 байгаагийн 30635 нь эрэгтэй, 29495 нь эмэгтэй байна. Залуу гэр бүл амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх ажлын хүрээнд "Булган-Орон сууц", "Залуусын хөгжил", "Эрүүл мэнд" зэрэг дэд хөтөлбөрүүдийг батлан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. |
| | | | Шилжин ирсэн хүний тоо | Тоо | 2024 | 924 | 950 | 1239 | 100 | - | - | - | 2025 оны жилийн эцсийн байдлаар орон нутагт шилжин ирсэн 1239 иргэн байгаагийн 625 нь эрэгтэй, 614 нь эмэгтэй байна. |
| **1.3.1.1** | | Өсвөр үе, залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон, сонирхолтой өнгөрүүлэх, идэвхи, оролцоог дэмжих “Залуусын хөгжил” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | Хөтөлбөрийн хэрэгжилт | Хувь | 2024 | 0 | 70 | 26 | 37.1 | 10.0 | 9.9 | 99 | Аймгийн ИТХ-ын IX/69 дүгээр тогтоолоор "Залуусын хөгжил" хөтөлбөрийг баталсан. Хөтөлбөрийг 5 зорилт 22 үйл ажиллагааны хүрээнд төлөвлөн хэрэгжилт 26 хувьтай байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 124 төрлийн тэмцээн уралдаан, 2 төрлийн сайн дурын ажил, 175 урлаг соёлын арга хэмжээ, 2 удаагийн залуучуудын чуулганд нийт 8340 залуусыг хамруулаа. Аймгийн 20, Япон улсын GOOD сайн дурын байгууллагын 25 залуу хамтран хүүхэд, өсвөр үеийнхний чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх зорилгоор "Хүүхэд залуучуудын цэцэрлэгт хүрээлэн"-д байрлах волейболын талбайг сэргээн, задгай талбайн "Open Mic" тайзыг шинээр хийв. Дээрх сайн дурын ажилд оролцсон аймгийн 20 залуус 7 хоног Япон улсад сайн дурын ажилд оролцож, орон нутгийн төсвөөс 9.9 төгрөг зарцуулаад байна. |
| | | | Хамрагдсан нийт залуучууд | Тоо | 2024 | 6402 | 6450 | 8340 | 100 | - | - | - | Хөтөлбөрийн хүрээнд 124 төрлийн тэмцээн уралдаан, 2 төрлийн сайн дурын ажил, 175 удаагийн урлаг соёлын арга хэмжээ, 2 удаагийн залуучуудын чуулганд нийт 8340 залуусыг хамруулаа. |
| **1.3.1.2** | | Иргэн, хувийн хэвшлийн санаачилгатай хүүхдийн хөгжил, оролцоог дэмжсэн секц дугуйлан, сургалтын төвүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ. | Дугуйлан секц | Тоо | 2024 | 54 | 60 | 61 | 100 | - | - | - | Аймгийн хэмжээнд хүүхэд, залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор 61 нэр төрлийн дугуйлан, секц хичээллэж байна. |
| | | | Хамрагдсан хүүхэд | хувь | 2024 | 54.1 | 60.1 | 56.7 | 43.3 | - | - | - | Аймгийн хэмжээнд хүүхэд, залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор спортын 13 төрлөөр 25 секц, дугуйлан тогтмол үйл ажиллагаа явуулж 780, соёл урлагийн 12 төрлийн дугуйланд 656, ерөнхий боловсролын 22 сургуульд 33 төрлийн 198 дугуйланд 10541 буюу нийт 11977 хүүхэд хамрагдаж байна. "Амьд хөгжим", "Код бичих", Англи хэлтэй Булган" зэрэг хөтөлбөрүүдийг АИТХ-аар батлуулан 3 төрлийн дугуйлан шинээр нэмэгдэн нийт 61 нэр төрлийн дугуйлан, секцэд нийт хүүхдийн 56.7 хувь хамрагдаж байна. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.3.2.1 | Үйл ажиллагаа | Гэр бүлийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн арга хэмжээг нэмэгдүүлнэ. | Арга хэмжээний тоо | Тоо | 2024 | 3 | 4 | 4 | 100 | 30 | 30 | 100 | Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх зорилгоор “Харилцан хүндэтгэе”, “Гэртээ эрт харья” 2 аян, гэр бүлийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх, гэр бүлийн боловсрол олгох 8 модуль сургалтыг орон нутаг, байгууллага аж ахуйн нэгжид зохион байгуулах гэсэн нийт 4 арга хэмжээг зохион байгууллаа. |
| | | | Хамрагдсан иргэд | Тоо | 2024 | 6433 | 6450 | 6841 | 100 | - | - | - | Гэр бүлийн боловсрол олгох 8 модуль сургалтыг аймгийн 16 сум, 1 тосгон, албан байгууллага, сургууль цэцэрлэгүүдийн хүүхдүүдийн асран хамгаалагчдад зориулсан 67 удаагийн сургалт зохион байгуулж 3896 хүнд хүргэсэн. Олон улсын гэр бүлийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хүрээнд 799 хүнийг гэр бүлийн боловсрол олгох сургалтад хамруулсан байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрх хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар 2146 иргэнд мэдээлэл хийж сурталчилсан ба нийт 6848 иргэнийг хамруулж ажилласны үр дүнд аймгийн хэмжээнд гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн тоо 23 буюу өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5 нэгжээр /17.8 хувь/ буурсан байна. |
| 1.3.2.2 | | Орон нутгийн түвшин дэх нийгмийн бүх харилцаанд жендэрийн (эрэгтэй, эмэгтэй) эрх тэгш байдлыг хангах арга хэмжээг зохион байгуулна. | Жендэрийн индекс | Хувь | 2024 | 1.047 | 1.046 | 1.05 | 0 | 8.0 | 2.5 | 31.2 | Орон нутгийн түвшин дэх нийгмийн бүх харилцаанд жендэрийн тэгш байдлыг хангах хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр 4 зорилтын хүрээнд 24 ажлыг төлөвлөн жилийн эцсийн байдлаар 77 хувьтай гүйцэтгээд байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажилласны үр дүнд төрийн болон төрийн бус байгууллага, хүүхэд, өсвөр үеийнхэн зэрэг 2080 иргэнд хүрч, жендэрийн эрх тэгш байдлын талаарх ойлголт өгөв. |
| 1.3.2.3 | | Хүүхэд, гэр бүл, залуучуудын салбарын барилга байгууламжийн өргөтгөл шинэчлэл, засварын ажлыг хэрэгжүүлнэ. | Шинээр баригдсан барилгын гүйцэтгэлийн хувь | Хувь | 2024 | 0 | 60 | 30 | 50 | 822.5 | 822.5 | 100 | "Жаргалант" хүүхдийн зуслангийн 2-р ээлжийн барилгын ажил болох 60 хүүхдийн Жаргалант хотхоны барилгын ажил эхэлсэн. Жаргалант хотхоны нийт төсөв 1597.5 сая төгрөг бөгөөд 2024 онд 822.5 сая төгрөгийн төсөв батлагдсаныг 2025 онд шилжүүлэн тендер зарлаж "Төсөв төсөл" компани шалгарсан. Жаргалант хотхон 60 хүүхдийн багтаамжтай 10 байшин баригдахаар зураг төсөв гарсан бөгөөд 2025 оны 10 дугаар сарын байдлаар гүний худаг гарган, ариун цэврийн байгууламж, амрах 10 байрны суурь бүрэн тавигдаж, бетон хийц бүрэн дуусаж төмөр карказууд босгогдлоо. Барилгын ажлын гүйцэтгэл 30 хувьтай байна. |
| | | | Барилгын их засварын гүйцэтгэлийн хувь | Хувь | 2024 | 0 | 100 | 0 | 0 | 35.0 | 0 | 0 | Хүүхдийн хөгжлийн ордонд 2024 оны 8 дугаар сард газрын гүнээс ус нэвчин гарч суурийн давхар усанд автсан. 2024 онд барилгын суурийг хүчитгэх, засвар хийх ажлын зураг төсөв хийлгэх зардал 26 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс шийдэж тендер зарласан боловч гүйцэтгэгч санал ирүүлээгүй. 2025 онд 35 сая төгрөг төсөвлөж тендер зарласан боловч оролцох аж ахуйн нэгж байхгүй байна. |
| **Хөдөлмөр эрхлэлт** | | | | | | | | | | | | | |
| 1.4 | ТЕЗ | Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, ажилгүйдлийн түвшнийг 1.2 пунктээр бууруулна. | Ажилгүйдлийн түвшин | Хувь | 2023 | 5.9 | 5.7 | 5.1 | 100 | | | | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр байнгын ажлын байранд 517, түр ажлын байранд 304, улирлын ажлын байранд 232, нийт 1053 иргэнийг тус тус зуучиллаа. Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн ажлын байрыг хадгалах, шинээр ажлын байр бий болгох зорилгоор хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, малчдад зориулсан санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 236 иргэнийг хамруулсан байна. |
| 1.4.1 | Хөтөлбөрийн | Өрхийн хөгжлийг дэмжиж, дундаж давхаргыг нэмэгдүүлнэ. | Өрхийн амьжиргааны баталгаажих түвшин | Хувь | 2024 | 16.5 | 16 | 11.7 | 100 | 1400.0 | 1400.0 | 100 | Өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй нийт өрхийн 11.7 хувь нь амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрх байна. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/187 дугаар тушаалаар амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрхийн босго шугам 409 байснаас 401.2 болон шинэчлэгдэн батлагдсан нь өрхийн амьжиргааны баталгаажих түвшин буурах шалтгаан болсон байна. Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, малчдад зориулан 1.4 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож, 201 иргэний ажлын байрыг хадгалан 32 иргэнд шинээр ажлын байр бий болголоо. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.4.1.1 | Үйл ажиллагаа | Орон нутгийн онцлог, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн мэргэжилтэй ажилтан бэлтгэх "Чадварлаг мэргэжилтэн" хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ. | Мэргэжилтэй ажилтан | Тоо | 2024 | 431 | 450 | 401 | 89.1 | 7.4 | 7.4 | 100 | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн IX/70 дугаар тогтоолоор "Чадварлаг мэргэжилтэн" хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байна. Тус хөтөлбөрийн хүрээнд ОХУ, БНСУ, БНХАУ зэрэг улсад 29 багш, 11 суралцагчийг сургалтад хамруулсан байна. Суурь ур чадвар олгох сургалтыг Рашаант, Хишиг-Өндөр, Орхон, Булган, Бугат сумын зорилтот бүлгийн 165 иргэнд зохион байгуулсан. ХААИС-ийн харьяа Булган аймаг дахь Политехникийн коллежийн 1 жилийн ангид 352 суралцагч, 2.5 жилийн курсэд 49 суралцагч, нийт 401 суралцагч суралцаж төгссөн байна. |
| | | | Ажлын байртай болсон мэргэжилтэй ажилтан | Хувь | 2024 | 40 | 40 | 66 | 100 | - | - | - | Суурь ур чадварын сургалт болон санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдийг хөдөлмөр эрхлэлтийн нэгдсэн цахим систем /Ejob.gov.mn/-д ажил хайгчаар бүртгэн, 10 иргэнийг байнгын ажлын байранд, 22 иргэнийг түр ажлын байранд тус тус зуучлаад байна. Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Булган аймаг дахь политехникийн коллежийг 2019-2024 оны хугацаанд буюу 5 жилийн хугацаанд 28 мэргэжлээр 2266 суралцагч төгссөн. Нийт төгсөгчдөөс 32 хувь нь мэргэжлийн ажил, 39 хувь нь мэргэжлийн бус ажил эрхэлж, 2 хувь нь дэвшин суралцсан байна. ХААИС-ийн харьяа Булган аймаг дахь Политехникийн коллежийг 2024-2025 оны хичээлийн жилд 401 суралцагч суралцаж төгссөнөөс 43 хувь нь мэргэжлийнхээ дагуу, 23 хувь нь мэргэжлийн бус хөдөлмөр эрхэлж байна. |
| 1.4.1.2 | | Үйлдвэрлэл, бүтээн байгуулалт, төсөл хөтөлбөрийн хүрээнд 4000-аас доошгүй байнгын болон улирлын чанартай ажлын байрыг бий болгоно. | Шинээр бий болсон ажлын байр | Тоо | 2024 | 901 | 1000 | 1110 | 100 | - | - | - | Төр болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 1110 ажлын байр шинээр бий болсныг хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн санд бүртгэлжүүлэв. Үүнд: байнгын ажлын байр 471, түр ажлын байр 279, улирлын ажлын байр 360 тус тус бий болсон байна. |
| 1.4.1.3 | | Халамжаас хөдөлмөрт шилжиж, амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрхийн хөдөлмөрийн насны, хөдөлмөр эрхлэх чадвартай иргэдийг ажлын байраар хангана. | Сургалтад хамрагдсан иргэн | Тоо | 2024 | 83 | 90 | 151 | 100 | - | - | | Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж байгаа өрхийн иргэн ба "Зөв өрх-20" арга хэмжээнд хамрагддаг өрхийн хөдөлмөрийн насны 151 иргэнийг "Ажлын байрны ярилцлага", "Хөдөлмөрийн тухай хууль", "Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох" сургалтад тус тус хамруулсан. |
| | | | Ажлын байранд зуучлагдсан иргэн | Тоо | 2024 | 200 | 250 | 302 | 100 | | | | Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны 71 иргэнийг байнгын ажлын байранд, 231 иргэнийг түр ажлын байранд тус тус зуучиллаа. |
| | | | Дэмжлэгт хамрагдсан иргэн | Тоо | 2024 | 128 | 130 | 44 | 33.8 | 350.8 | 350.8 | 100 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хувиараа хөдөлмөр эрхэлдэг 44 иргэнд 350.8 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгон, өрхийн орлогыг бодитоор нэмэгдүүлэн ажилласан байна. Халамжаас хөдөлмөрт арга хэмжээний хүрээнд нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны 71 иргэнийг байнгын ажлын байранд, 231 иргэнийг түр ажлын байранд зуучилж ажилласан байна. |
| **Нийгмийн халамж, хамгаалал** | | | | | | | | | | | | | |
| 1.5 | ТЕЗ | Нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулна. | Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрх | Хувь | 2024 | 16.5 | 16 | 11.7 | 100 | | | | Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой 2281 өрх байгаа нь нийт өрхийн 11.7 хувийг эзэлж байна. Нийгмийн халамжийн үйлчилгээ бүрэн цахимжсан. Төрийн үйлчилгээний Emongolia цахим системээр нийгмийн халамжийн 11 төрлийн үйлчилгээ, Ehalamj.mn цахим системээр нийгмийн халамжийн 72 нэр төрлийн 411 үйлчилгээг хүргэж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан ажиллаж байна. |
| 1.5.1 | **Хөтөлбөрийн** | Зорилтот бүлгийн иргэдийн бие даан амьдрах чадварыг сайжруулна | Амьжиргаа дээшилсэн өрх | Тоо | 2024 | 326 | 380 | 316 | 83.1 | | | | Халамжаас-Хөдөлмөрт дэвших зорилтын хүрээнд "Зөв өрх-20" арга хэмжээг хэрэгжүүлэхээр сум тус бүрээс 20, Булган сумын баг тус бүрээс 10, нийт 380 өрхийг сонгон авч, тайлант хугацаанд 316 өрхийг эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын арга хэмжээнд оролцуулан 160.0 сая төгрөг зарцуулав. Хөдөлмөр эрхлэх боломжтой хөдөлмөрийн насны 71 иргэнийг байнгын, 231 иргэнийг түр ажлын байранд тус тус зуучилж, 156 өрхийн орлогыг нэмэгдүүлэх ажлыг сум орон нутагтай хамтран зохион байгуулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 9, малжуулах хөтөлбөрт 11, нийт 20 өрхийг хамруулсан байна. |
| | | | Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авч буй өрх | Тоо | 2024 | 400 | 385 | 325 | 85.5 | 187 | 187 | 100 | Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээгээр 8 сумын 325 өрхийн 1578 иргэнд 187.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Хүнсний эрхийн бичиг авдаг өрхийн орлогыг нэмэгдүүлэх, ажлын байраар хангах чиглэлээр хөдөлмөрийн насны 101 иргэнийг байнгын ажлын байранд, 66 иргэнийг түр ажлын байранд зуучилж ажилласан байна. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **1.5.1.1** | | Зорилтот бүлгийн өрхийн гишүүдийн хөгжил, оролцоог хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлнэ | Хөтөлбөрт хамрагдсан өрх | Тоо | 2024 | 326 | 380 | 316 | 83.2 | | | | Халамжаас-Хөдөлмөрт дэвших "Зөв өрх-20" арга хэмжээг хэрэгжүүлэхээр 16 сум, 1 тосгоноос нийт 380 өрхийг сонгож тайлант хугацаанд 316 өрхийн амьжиргааны түвшин бодитоор дээшилсэн байна. Тухайлбал, эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд 149 өрхийн 496 иргэн, 101 хүүхдийг хамруулан өрхийн хөгжлийг дэмжих чиглэлээр зохион байгуулсан сургалт, нөлөөллийн арга хэмжээнд нийт насанд хүрэгчдийн 47 хувийг хамрууллаа. |
| **1.5.1.2** | | Төрөөс үзүүлж байгаа нийгмийн халамж, тусламж, үйлчилгээг зөвхөн зорилтот бүлэгт чиглүүлнэ | Хамрагдсан иргэн | Тоо | 2024 | 22,000 | 22,000 | 21,821 | 100 | 39600 | 39600 | 100 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт тусламжид давхардсан тоогоор 21821 иргэнд 14.7 тэрбум төгрөгийг олгоод байна. |
| **1.5.1.3** | **Үйл ажиллагаа** | Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлж, төрийн болон үйлчилгээний байгууллагуудын ажилтнуудын зэрэг харилцаа, хандлагыг төлөвшүүлж, ээлтэй орчныг бүрдүүлнэ. | Төрийн байгууллагад ирсэн ёс зүйн гомдол, санал | тоо | 2024 | 0 | 0 | 0 | 100 | | | | Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлж, төрийн болон үйлчилгээний байгууллагуудын ажилтнуудын зэрэг харилцаа, хандлагыг төлөвшүүлж, ээлтэй орчныг бүрдүүлэх чиглэлээр 19 байгууллагын 360 ажилтан албан хаагчид сургалт, мэдээллийн ажлыг зохион байгуулж ажилласны үр дүнд тайлант хугацаанд төрийн байгууллагын ёс зүйтэй холбоотой гомдол, санал ирээгүй байна. |
| | | | Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн | Хувь | 2024 | 7055/66,5 | 70 | 70 | 100 | | | | Олон улсын ахмадын баярыг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд аймгийн хэмжээнд 5405 ахмад настныг хүлээн авч хүндэтгэл үзүүлэн, урлаг соёлын арга хэмжээнд 2977 ахмад, спортын олон талт арга хэмжээнд 1764 ахмад настан, нийт давхардсан тоогоор 10146 ахмад настныг хамруулж, 136.8 сая төгрөг зарцуулсан байна. Тус онд аймгийн ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлж, ахмадын өргөөгөөр 4741 иргэн үйлчлүүлсэн байна. Тусгай хэрэгцээт иргэдэд ээлтэй хүртээмжтэй орчныг нэмэгдүүлэх зорилгоор төрийн байгууллага болон хувийн хэвшлийн үйлчилгээний байгууллагуудад "Тусламжийн хонх" байршуулж үйлчлэх уриалгыг гаргаснаар 44 байгууллага хэрэгжүүлэн ажиллаж байна. Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор үзлэг, хяналтыг зохион байгуулж, 47 байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй 80 иргэн ажиллаж байна. |
| **Биеийн тамир,спорт** | | | | | | | | | | | | | |
| **1.6** | **ТЕЗ** | Хүн амын эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг дэмжинэ. | Дэмжих чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагаа | Тоо | 2024 | 16 | 17 | 25 | 100 | 194.4 | 194.4 | 100 | Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх, иргэдийн эрүүл зөв амьдралын хэвшлийг дэмжих зорилгоор 25 арга хэмжээ зохион байгуулж, давхардсан 20011 иргэнийг хамрууллаа. Тухайлбал: “Идэвхтэй алхалтад цаг гаргая” аяны хүрээнд шугаман болон цэнгээнт бүжгийн сургалтуудыг мэргэжлийн багш нартай хамтран зохион байгуулж, иргэдийг алхалт, гүйлт, дасгалд тогтмол хамруулж байна. Хойд бүсийн спорт наадмын анхан шат, шигшээ 2 тэмцээнийг улсын төсвийн 168.0, орон нутгийн 6.0 сая төгрөгийн санхүүжилтээр 7 төрлөөр зохион байгуулж, 670 гаруй иргэн оролцож, аймгийн 120 тамирчны хувцас хэрэгсэл, материалд орон нутгийн төсвөөс 4.4 сая төгрөг зарцуулсан. Мөн Баянхонгор аймагт зохион байгуулагдсан Бүх ард түмний спортын зуны наадамд оролцсон баг, тамирчдад 5.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, “Сансар марафон 2025” бүх нийтийн гүйлтийг орон нутгийн төсвийн 6.0 сая төгрөгийн санхүүжилтээр 10 насны ангилалд 1–21 км зайд зохион байгуулж, Булган, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ, Хөвсгөл, Дундговь, Завхан, Баянхонгор, Улаанбаатар хотын 405 тамирчин оролцов. Залуучуудын спортын идэвх, санаачилгыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд волейболын насанд хүрэгчид болон идэрчүүдийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулахад 5.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. |
| | | | Хамрагдсан иргэд | Тоо | 2024 | 27000 | 29000 | 20011 | 69.0 | - | - | - | Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх, иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, амьдралын зөв дадал хэвшлийг төлөвшүүлэх зорилгоор 2025 онд 25 арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 20011 иргэнийг хамрууллаа. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **1.6.1** | **Хөтөлбөрийн** | Иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэх идэвхийг өрнүүлж, ээлтэй орчныг бүрдүүлнэ. | Тоног төхөөрөмжийн хангалт | Хувь | 2024 | 40 | 50 | 50 | 100 | 95.4 | 95.4 | 100 | Орон нутгийн төсвийн 16.0 сая төгрөгийн санхүүжилтээр цанын өсвөрийн шигшээ багийн тамирчдыг 10 ширхэг цанын гутал, сагсан бөмбөг, волейболын секц дугуйланд 10 ширхэг бөмбөг болон бусад шаардлагатай хэрэглэгдэхүүн, материал худалдан авч, секц дугуйлангийн хангалтыг 5 хувиар нэмэгдүүлэв. Хойд бүсийн иргэдийн спортын наадамд аймаг, орон нутгаа төлөөлөн спортын 7 төрөлд оролцсон 120 тамирчны хэрэглэгдэхүүн, материалын зардалд орон нутгийн төсвөөс 4.4 сая төгрөгийг зарцууллаа. Мөн сум бүрийг зориулалтын үндэсний бөхийн дэвжээтэй болгох зорилтын хүрээнд орон нутгийн төсөв болон хандив тусламжийн 75.0 сая төгрөгийн санхүүжилтээр Рашаант, Сайхан, Могод, Хутаг-Өндөр, Баяннуур суманд бөхийн зориулалтын дэвжээ, татами авч, бэлтгэл сургуулилт хийх нөхцөлийг сайжруулан бөхийн спортын медалийн тоо 52 хувиар өсөж, тогтмол хичээллэгсдийн тоо 123 болж хамрагдалт 12 хувиар өссөн үзүүлэлттэй байна. |
| | | | Засвар үйлчилгээ хийгдэж ашиглалтад орсон барилга байгууламж | Тоо | 2024 | 1 | 1 | 0 | 0 | 20 | 20 | 100 | Орон нутгийн төсвийн 20.0 сая төгрөгийн санхүүжилтээр Усан спорт, сургалтын төвийн 1300.0 төсөв өртөг бүхий барилгын их засварын зураг төсвийн ажлыг "Үүлэн прожект" ХХК хийж гүйцэтгэв. Тус их засварын ажлыг 2026 оны орон нутгийн төсөвт тусгахаар төлөвлөж байна. |
| **1.6.2** | | Өвлийн болон үндэсний спортыг хөгжүүлж, спортын амжилтыг нэмэгдүүлнэ. | Үндэсний спортоор амжилт үзүүлсэн тамирчин | Тоо | 2024 | 0 | 5 | 3 | 60 | - | - | - | 2025 онд үндэсний спортын тэмцээн уралдаанд 3 тамирчин амжилт гаргаж, сурын улсын нээлттийн харвааанд Булган сумын нэг харваач "Спортын дэд мастер", Буриад сурын харвааанд нэг харваач тэргүүн байр эзэлж "Буриад сурын спортын мастер", шагайн харвааны улсын аварга шалгаруулах тэмцээнд О.Энхтүвшин ганцаарчилсан төрөлд II байр эзэлсэн байна. |
| | | | Үндэсний спортоор хичээллэгсдийн тоо | Тоо | 2024 | 1326 | 1376 | 1441 | 100 | - | - | - | Аймгийн хэмжээнд хүүхэд, залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх ажлын хүрээнд үндэсний бөхөөр 130, үндэсний сурын харваагаар 300, шагайн харваагаар 350 хүүхэд, 410 залуучууд, ахмадын нумт харваагаар 150 харваач, мөсний шагайн харваагаар 56 харваач, мөсний сурын харваагаар 45 харваач, нийт 1441 ахмад, хүүхэд, залуучууд тогтмол хичээллэж байна. |
| | | | Өвлийн спортоор амжилт үзүүлсэн тамирчин | Тоо | 2024 | 23 | 20 | 35 | 100 | 33 | 33 | 100 | Монголын Хүүхдийн спортын өвлийн VIII их наадмын шигшээ тэмцээнд оролцох баг, тамирчдад орон нутгийн төсвөөс 33.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, гүйлтийн тэшүүр, уулын цана, цана, шорт трек, багийн төрөлд аймгийн өсвөрийн шигшээ багийн 35 тамирчин 7 алтан медаль, 16 мөнгөн медаль, 13 хүрэл медаль, нийт 36 медаль хүртэж, багийн дүнгээр 3 дугаар байр эзэлж, шилдэг аймгаар шалгарсан амжилт үзүүллээ. |
| | | | Өвлийн спортоор хичээллэгсдийн тоо | Тоо | 2024 | 80 | 100 | 149 | 100 | - | - | - | 2025 онд аймгийн хэмжээнд өвлийн спортын цана, тэшүүр, мөсний сур, шагайн төрлүүдээр 149 тамирчин тогтмол бэлтгэл сургуулилтад хамрагдан, аймаг болон улсын чанартай тэмцээн уралдаанд амжилттай оролцож байна. |
| **1.6.1.1** | | Иргэдэд үйлчлэх стандартын шаардлага хангасан зам талбай, заал танхимыг нэмэгдүүлнэ. | Барилга байгууламж, заал, талбай | Тоо | 2024 | 1 | 2 | 2 | 100 | 2,996.4 | 2,996.4 | 100 | Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, иргэдэд зориулсан стандартын шаардлага хангасан спорт талбайн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Булган сумын соёл амралтын цэцэрлэгт хүрээлэнд орон нутгийн төсвийн 1.3 тэрбум төгрөгийн санхүүжилтээр явган хүний зам, хүүхэд бүрийн насны онцлогт тохирсон тоглоомын талбайн бүтээн байгуулалт хийгдлээ. Мөн улсын төсвийн 1676.4 сая төгрөгийн санхүүжилтээр 6 суманд (Булган, Дашинчилэн, Хангал, Хутаг-Өндөр, Бугат, Баян-Агт) хүүхдийн тоглоомын талбай барих ажилд "Өвөлжөөн булаг" ХХК шалгаран 50 хувьтай гүйцэтгээд байна. Энэхүү багц ажлаас Бугат сумын хүүхдийн тоглоомын талбайн ажлын бүрэн хийж гүйцэтгэн ашиглалтад хүлээлгэн өгсөн. |
| | | | Тоног төхөөрөмжийн хангалт | Хувь | 2024 | 40 | 50 | 50 | 100 | 20.4 | 20.4 | 100 | Орон нутгийн төсвийн 16.0 сая төгрөгийн санхүүжилтээр цанын өсвөрийн шигшээ багийн тамирчдыг 10 ширхэг цанын гутал, сагсан бөмбөг, волейболын секц дугуйланд 10 ширхэг бөмбөг болон бусад шаардлагатай хэрэглэгдэхүүн, материал худалдан авч, секц дугуйлангийн хангалтыг 5 хувиар нэмэгдүүлэв. Хойд бүсийн иргэдийн спортын наадамд аймаг, орон нутгаа төлөөлөн спортын 7 төрөлд оролцсон 120 тамирчны хэрэглэгдэхүүн, материалын зардалд орон нутгийн төсвөөс 4.4 сая төгрөгийг зарцууллаа. Мөн сум бүрийг зориулалтын үндэсний бөхийн дэвжээтэй болгох зорилтын хүрээнд орон нутгийн төсөв болон хандив тусламжийн 75.0 сая төгрөгийн санхүүжилтээр Рашаант, Сайхан, Могод, Хутаг-Өндөр, Баяннуур суманд бөхийн зориулалтын дэвжээ, татами авч, бэлтгэл сургуулилт хийх нөхцөлийг сайжруулав. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **1.6.1.2** | **Үйл ажиллагаа** | Хүн амын эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг дэмжихэд чиглэсэн олон талт арга хэмжээг зохион байгуулж, спорт бүжгийн төрлийг хөгжүүлнэ. | Зохион байгуулсан арга хэмжээ | Тоо | 2024 | 16 | 17 | 25 | 100 | | | | Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх, иргэдийн эрүүл зөв амьдралын хэвшлийг дэмжих зорилгоор 25 арга хэмжээ зохион байгуулж, давхардсан 20011 иргэнийг хамрууллаа. Тухайлбал: “Идэвхтэй алхалтад цаг гаргая” аяны хүрээнд шугаман болон цэнгээнт бүжгийн сургалтуудыг мэргэжлийн багш нартай хамтран зохион байгуулж, иргэдийг алхалт, гүйлт, дасгалд тогтмол хамруулж байна. Хойд бүсийн спорт наадмын анхан шат, шигшээ 2 тэмцээнийг улсын төсвийн 168.0, орон нутгийн 6.0 сая төгрөгийн санхүүжилтээр 7 төрлөөр зохион байгуулж, 670 гаруй иргэн оролцож, аймгийн 120 тамирчны хувцас хэрэгсэл, материалд орон нутгийн төсвөөс 4.4 сая төгрөг зарцуулсан. Мөн Баянхонгор аймагт зохион байгуулагдсан Бүх ард түмний спортын зуны наадамд оролцсон баг, тамирчдад 5.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, “Сансар марафон 2025” бүх нийтийн гүйлтийг орон нутгийн төсвийн 6.0 сая төгрөгийн санхүүжилтээр 10 насны ангилалд 1–21 км зайд зохион байгуулж, Булган, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ, Хөвсгөл, Дундговь, Завхан, Баянхонгор, Улаанбаатар хотын 405 тамирчин оролцов. Залуучуудын спортын идэвх, санаачилгыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд волейболын насанд хүрэгчид болон идэрчүүдийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулахад 5.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. |
| | | | Хамрагдсан иргэд | Тоо | 2024 | 27000 | 29000 | 20011 | 69 | - | - | - | Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх, иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, амьдралын зөв дадал хэвшлийг төлөвшүүлэх зорилгоор 2025 онд 25 арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 20011 иргэнийг хамрууллаа. |
| | | | Спорт бүжгээр хичээллэдэг иргэд | Тоо | 2024 | 0 | 60 | 75 | 100 | 5 | 5 | 100 | Аймгийн хэмжээнд ахмад настнуудын эрүүл мэндийг дэмжих, чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор шугаман бүжгийн 5 хамтлаг тогтмол үйл ажиллагаа явуулж, 75 ахмад настан идэвхтэй хамрагдаж байна.<br>Мөн аймгийн хэмжээнд идэвхтэй дасгал хөдөлгөөнийг сурталчлахаар цахимаар нийтийн шугаман бүжгийн сургалтыг 3 насны ангиллаар зохион байгуулж “Идэвхтэй алхалтад- Цаг гаргая” аяны хүрээнд нийтийн цэнгээнт бүжгийн анхан шат, олон нийтийн цэнгээнт бүжиг, шугаман бүжгийн сургалтыг "Монгол бүжгийн спортын нэгдсэн холбоо", "Монголын гимнастик шугаман бүжгийн холбоо", Булган сумын ахмадын хороотой хамтран зохион явуулж 238 хүн хамрагдлаа. |
| **1.6.2.1** | | Спортын холбоо, клубтэй хамтран спортын авьяастнуудыг нээн илрүүлэх, хөгжүүлэх ажлыг зохион байгуулна. | Секц дугуйлангийн төрөл | Тоо | 2024 | 23 | 24 | 25 | 100 | - | - | - | 2025 онд хүүхэд, залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор волейбол, сагсан бөмбөг, бокс, жүдо, ширээний теннис, шатар, таеквондо, үндэсний бөх, буудлага, цана, тэшүүр, хөнгөн атлетик, үндэсний сур зэрэг спортын 13 төрлөөр албан ёсны 25 секц, дугуйлан тогтмол үйл ажиллагаа явуулж байна. |
| | | | Амжилт гаргасан тамирчид | Тоо | 2024 | 217 | 237 | 284 | 100 | 44.2 | 44.2 | 100 | Өсвөрийн шигшээ багийн бэлтгэл сургуулилт, хэрэглэл материал, тэмцээний зардалд орон нутгийн төсвөөс 44.2 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, Монголын хүүхдийн спортын өвөл, зуны наадам болон улс, бүс, олон хотын нэрэмжит уралдаан, тэмцээнд өсвөрийн шигшээ багийн 604 тамирчин оролцож, нийт 284 медаль хүртэж амжилтын чанар 8.8 хувиар өссөн байна. |
| **1.6.2.2** | | Үндэсний спорт, багийн спортоор хичээллэгсдийн тоог нэмэгдүүлнэ. | Үндэсний спортоор хичээллэгсдийн тоо | Тоо | 2024 | 1326 | 1376 | 1441 | 100 | - | - | - | Аймгийн хэмжээнд хүүхэд, залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх ажлын хүрээнд үндэсний бөхөөр 130, үндэсний сурын харваагаар 300, шагайн харваагаар 350 хүүхэд, 410 залуучууд, ахмадын нумт харваагаар 150 харваач, мэсний шагайн харваагаар 56 харваач, мэсний сурын харваагаар 45 харваач, нийт 1441 ахмад, хүүхэд, залуучууд тогтмол хичээллэж байна. |
| | | | Зохион байгуулсан тэмцээн уралдаан | Тоо | 2024 | 38 | 39 | 12 | 30.7 | 46.5 | 46.5 | 100 | Аймгийн хэмжээнд үндэсний спортыг хөгжүүлэх, залуу үеийг үндэсний өв, соёлоор дамжуулан бие бялдар, ёс суртахууны төлөвшлийг дэмжих зорилгоор орон нутгийн төсвийн 46.5 сая төгрөгөөр 2025 онд үндэсний спортын 3 төрлөөр 12 тэмцээнийг зохион байгууллаа. Үүнд: Өсвөрийн үндэсний бөхийн аварга шалгаруулах барилдаан, “Таван аварга”-ын нэрэмжит улс, аймгийн цолтой хүчит 128 бөхийн барилдаан, үндэсний сурын аймгийн аварга, сурын отог харваа аймгийн аварга шалгаруулах тэмцээн, нээлтийн харваа, шагайн харвааны өсвөр үе, насанд хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн, шагайн харваан “Хойд бүсийн лиг-2025”, ахмадын отог харваа тэмцээн, сар шинийн баяр, Монгол эр цэргийн баярт зориулсан шагайн харваа, “Хангинахын шугуйн шагайн тойром” зэрэг тэмцээн уралдаанд 2042 тамирчин оролцсон байна. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Оролцсон тамирчид | Тоо | 2024 | 2322 | 2422 | 2042 | 84.3 | | | | Аймгийн хэмжээнд үндэсний спортыг хөгжүүлэх, залуу үеийг үндэсний өв, соёлоор дамжуулан бие бялдар, ёс суртахууны төлөвшлийг дэмжих зорилгоор 2025 онд үндэсний спортын 3 төрлөөр 12 тэмцээн, уралдааныг зохион байгуулж, 2042 тамирчин оролцлоо. Дээр арга хэмжээний үр дүнд өмнөх оны мөн үетэй харьцуулахад үндэсний спортоор хичээллэгчдийн тоо 8.7 хувиар өсөж, багийн спортоор хичээллэгсэд 2025 онд 1697 болж, 81.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна. |
| **1.6.2.3** | | Улс, олон улс, тив дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцсон тамирчдын амжилтыг ахиулна. | Амжилт гаргасан тамирчид | Тоо | 2024 | 217 | 237 | 284 | 100 | 122.2 | 122.2 | 100 | 2025 онд тив дэлхий, олон улс, бүсийн тэмцээн уралдаанд оролцсон 144 тамирчинд орон нутгийн төсвийн 56.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэв. Тухайлбал: Монголын Хүүхдийн спортын өвлийн VIII их наадмын шигшээ тэмцээнд 35 тамирчин, зуны спортын наадамд 100 тамирчин, Бүгд Найрамдах Казахстан улсын Чимкент хотод зохион байгуулагдах ази тивийн аварга шалгаруулах буудлагын тэмцээнд 2 тамирчин, Киргиз улсын Бишкек хотод зохион байгуулагдах самбо бөхийн насанд хүрэгчдийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд 2 тамирчин, Тайланд улсын Бангкок хотод зохион байгуулагдах ази, номхон далайн орнуудын хэт холын марафонд 1 тамирчин, Ласвегас хотод зохион байгуулагдах бодибилдингийн “MR.OLIMPIA AMATEUR” тэмцээнд 1 тамирчин, Макао улсад зохион байгуулагдсан “Macau cadet Asian cup 2025” жүдо бөхийн аварга шалгаруулах 1 тамирчин, Ази тивийн самбо бөхийн насанд хүрэгчдийн аварга шалгаруулах тэмцээнд 2 тамирчин оролцлоо. Мөн орон нутгийн төсвөөс 44.2 сая төгрөгийн санхүүжилтээр тамирчдын хэрэглэгдэхүүн, материал болон улс, бүс, олон хотын нэрэмжит уралдаан, тэмцээнд өсвөрийн шигшээ багийн 604 тамирчин оролцож, нийт 284 медаль хүртэж амжилтын чанар 8.8 хувиар өссөн байна. |
| **1.6.2.4** | | Өвлийн спортын төрлийг хөгжүүлж, спортоор хичээллэгсдийн тоог нэмэгдүүлнэ. | Оролцсон тамирчид | Тоо | 2024 | 70 | 80 | 283 | 100 | - | - | - | Өвлийн спортын төрлүүдийг хөгжүүлэх, оролцогчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор "Анхдагчдын цом-2025" гүйлтийн цанын аварга шалгаруулах, мөсний сур, шагай, тэшүүрийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж, нийт 4 тэмцээнд 283 тамирчин оролцлоо. |
| | | | Тоног төхөөрөмжийн хангалт | Хувь | 2024 | 0 | 20 | 15 | 75 | 12 | 12 | 100 | Өсвөрийн тамирчдын ур чадварыг нэмэгдүүлэх, цанын спортыг орон нутагт тогтвортой хөгжүүлэх зорилгоор орон нутгийн төсвийн 12.0 сая төгрөгийн санхүүжилтээр цанын өсвөрийн шигшээ багийн тамирчдын хэрэглэгдэхүүн материалыг 15 хувиар нэмэгдүүлсэн. |
| | | | Зохион байгуулсан арга хэмжээ | Тоо | 2024 | 3 | 5 | 4 | 80 | - | - | - | Өвлийн спортын төрлүүдийг хөгжүүлэх, тамирчдын ур чадварыг ахиулах зорилгоор цана, тэшүүр, мөсний шагай, мөсний сурын төрлүүдээр 4 тэмцээнийг амжилттай зохион байгууллаа. “Анхдагчдын цом–2025” гүйлтийн цанын аварга шалгаруулах нээлттэй тэмцээнийг Тэшиг сумд зохион байгуулж, Завхан, Орхон, Сэлэнгэ, Хэнтий аймгаас өсвөр үеийн 3 насны ангилалд 48 тамирчин, насанд хүрэгчдийн төрөлд 22 тамирчин, нийт 70 тамирчин хурд хүчээ сорин өрсөлдлөө. Тус тэмцээнд өсвөр насны төрөлд аймгийн өсвөрийн шигшээ багийн тамирчин 1 дүгээр байр, насанд хүрэгчдийн төрөлд Хилийн цэргийн 0277 дугаар ангийн баг тамирчид 1 дүгээр байр эзэлснээр багийн дүнгээр тэргүүн байр эзлэв. Тэшүүрийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 6 багийн 76 тамирчин, мөсний сур харваанд 86 харваач, мөсний шагайн харваанд 4 сумын 29 харваач хурд, авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө. |
| **Соёл, урлаг** | | | | | | | | | | | | | |
| **1.7** | **ТЕЗ** | Соёл, урлагийн байгууллагуудын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ. | Соёл, урлагийн байгууллагуудаар үйлчлүүлсэн иргэд | Тоо | 2024 | 71649 | 72000 | 219493 | 100 | - | - | - | Аймгийн хэмжээнд бүх нийтийн соёлын боловсролыг түгээн дэлгэрүүлэх, иргэдийн соёлын мэдлэг, боловсролыг нэмэгдүүлэх зорилгоор 4 зорилт, 19 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг боловсруулан батлуулж, 94.7 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлээд байна. Төлөвлөгөөний хүрээнд утга зохиол, үндэсний бичиг соёлыг түгээн дэлгэрүүлэх, урлаг уран бүтээлээр дамжуулан гоо зүйн боловсрол олгох, түүх соёлын дурсгалт газар болон соёлын өвийг таниулж сурталчлах, нийгмийн харилцааны соёлыг дээшлүүлэх чиглэлээр 18 арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 33700 иргэнийг хамрууллаа. Мөн соёлын 20 байгууллага давхардсан тоогоор соёл, урлагийн 25485 үзвэр, үйлчилгээг 219493 иргэнд хүргэв. |
| | | | Мэргэшсэн хүний нөөцийн хангалт | Хувь | 2024 | 68.2 | 70 | 71.7 | 100 | - | - | - | Аймгийн соёл, урлагийн салбарт 184 ажилтан ажиллаж байна. Үүнээс мэргэжил шаардагдах 145 орон тоонд 71.7 хувь буюу 104 мэргэжлийн, 41 мэргэжлийн бус ажилтан байна. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **1.7.1** | | Соёл, урлагийн салбарын мэргэжилтэй боловсон хүчний хангалтыг нэмэгдүүлнэ. | Мэргэшүүлэхэд дэмжлэг үзүүлсэн албан хаагчид | Тоо | 2024 | 1 | 2 | 12 | 100 | - | - | - | Соёлын салбарын мэргэжлийн бус ажилтнуудыг мэргэшүүлэх зорилгоор Гурванбулаг сумын бүжгийн багш 1, хөгжмийн багш 1, Бүрэгхангай сумын соёлын төвийн номын санч 1, Баян-Агт сумын соёлын төвийн номын санч 1, Бугат сумын бүжгийн багш 1, номын санч 1, Нийтийн номын сангийн 4, Хөгжимт жүжгийн театрын 2 албан хаагчийг Соёл урлагийн их сургууль болон Сити их сургуульд эчнээгээр суралцуулж, суралцах хугацаанд байгууллагаас цалинтай чөлөө олгон дэмжлэг үзүүлж байна. |
| **1.7.2** | | Соёлын байгууллагуудын орчин нөхцөл, тоног төхөөрөмжийг сайжруулна. | Барилга, байгууламж | Тоо | 2024 | 4 | 1 | 1 | 100 | УТ-2,000.0, ОНТ-53.3 | УТ-2,000.0, ОНТ-53.3 | 100 | Соёлын байгууллагуудын орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор Нийтийн номын сангийн барилгын ажлыг улсын төсвийн 2,000.0 сая төгрөгөөр “Зууны сод хийц” ХХК гэрээний дагуу хийж гүйцэтгэн, 2025 оны 01 дүгээр сард ашиглалтад хүлээлгэн өгсөн. Бүрэгхангай сумын соёлын төвийн шинэ барилгын суурийн хана болон дүүргэлтийн ажлууд хийгдэж, гүйцэтгэл 50 хувь, Бугат сумын 240 хүний суудалтай соёлын төвийн барилгын ажлын гүйцэтгэл 60 хувьтай байна. Мөн орон нутгийн төсвийн 10.0 сая төгрөгийн санхүүжилтээр Баяннуур сумын соёлын төвийн дээврийн засвар, орон нутгийн төсвийн 38.0 сая төгрөгийн санхүүжилтээр Орхон сумын соёлын төвийн дотор нойлын инженерийн шугам сүлжээ, сантехникийн тоноглол, хана, шал, таазны засвар шинэчлэл зэрэг орчин үеийн шаардлагад нийцсэн тохижилтын ажлуудыг иж бүрнээр хийж, Тэшиг сум, Хялганат тосгоны соёлын төвүүдэд номын сангийн өрөө, хөгжмийн багшийн өрөө, эрхлэгчийн өрөө, хувцас солих өрөө зэрэг зориулалтын өрөөнүүдэд орон нутгийн төсвийн 5.3 сая төгрөгийн санхүүжилтээр шаардлагатай засвар, тохижилтын ажлуудыг хийж, үйл ажиллагааны нөхцөлийг сайжрууллаа. |
| | | | Тоног төхөөрөмжийн хангалт | Хувь | 2024 | 70 | 73 | 73 | 100 | УТ-837.8, ОНТ-155.1, хандив-260.4 | УТ-837.8, ОНТ-155.1, хандив-260.4 | 100 | Соёлын байгууллагыг орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр хангах ажлын хүрээнд улс, орон нутгийн төсөв болон хандив, тусламжийн 1,253.3 сая төгрөгийн хөрөнгөөр Нийтийн номын сан, Сайхан, Бугат, Баян-Агт сумын соёлын төвийг тавилга, эд хогшил, техник тоног төхөөрөмжөөр хангав. Мөн мэргэжлийн урлагийн байгууллагад иж бүрэн цахилгаан хөгжмийн зэмсэг, Хөгжимт жүжгийн театрт 8 ширхэг, Соёлын ордонд 20 ширхэг сургалтын гитар, Хутаг-Өндөр, Тэшиг, Бугат, Сэлэнгэ, Хангал сум, Хялганат тосгонд тус бүр 2 ширхэг сургалтын гитар олгов. Үүнээс гадна Сайхан, Булган сум, Орхон, Баян-Агт, Хангал, Бүрэгхангай сумын соёлын төвүүдэд лед дэлгэцийг суурилуулж ашиглалтад хүлээлгэн өгсөн. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас Тэшиг сумын соёлын төвд үзэгчийн сандал, номын тавиурын дэмжлэг үзүүлсэн. Дээрх ажлуудын үр дүнд сумын соёлын төвүүдийн техник, тоног төхөөрөмжийн хангалт 73.0 хувьд хүрч, иргэдэд соёлын үйлчилгээг чанартай, тасралтгүй хүргэх нөхцөл бүрдээд байна. |
| | **Хөтөлбөрийн** | | Шинээр бүртгэсэн үл хөдлөх дурсгал | Тоо | 2024 | 8 | 8 | 8 | 100 | 3 | 3 | 100 | Баян-Агт, Гурванбулаг, Баяннуур, Дашинчилэн, Бүрэгхангай сумдын нутаг дэвсгэрт орших Бүрээ толгойн хийдийн туурь, Хөшөө чулуу, Хадны сүг зураг, Согтуугийн голын хадны бичиг үсгийн дурсгал, Хэрмэн дэрсний балгас, Улаан тугалган хийдийн туурь, Хөх чулуутын хадны сүг зураг, Дашинчилэн сумын Найдаг уулын агуйд байрлах Хятаны их бага бичгийн дурсгал зэрэг 8 үл хөдлөх дурсгалыг бүртгэн баримтжуулсан. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **1.7.3** | | Соёлын биет болон биет бус өвийг хадгалан хамгаалж, өвлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ. | Шинээр бүртгэсэн баримтат өв | Тоо | 2024 | 20 | 25 | 25 | 100 | - | - | - | Иргэдийн гар дээр болон сүм хийдэд хадгалагдаж буй түүхэн тодорхой он цагийг илтгэх байгаль, нийгэм, түүх, соёл, урлаг, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдол бүхий мэдээлэл агуулсан баримтат өвийг бүртгэн баримтжуулах зорилгоор Баян-Агт сумын 1 иргэнд хадгалагдаж буй 225-300 жилийн түүхтэй шүрэн чимэгтэй эхнэр малгай, Сампин зангидаж оройг нь үүлэн хээгээр бүрсэн ширмэл оёдолтой лам малгай, Чин ван 13-р Далай ламын хантааз, Баяннуур сумын 1 иргэнд хадгалагдаж буй 1930-аад оны үед хамаарах бороонш хариулга судар, Бугат сумын 1 иргэнд хадгалагдаж буй 17-р зууны үед хамаарах Алтангэрэл судар, Булган сумын Дашчойнхорлин хийдэд хадгалагдаж буй 18-р зууны үед хамаарах төрийн долоон эрдэнэ мөнгөн цөгц, Бүрэгхангай сумын 1 иргэнд хадгалагдаж буй 18-р зууны үед хамаарах төвөд үсгээр муутуу цаасан дээр хар бэхээр бичсэн 400 гаруй хуудастай судар, Могод сумын хийдэд хадгалагдаж буй Өндөр гэгээн Занабазарын дэг сургуулиар нухмал алтаар бүрж хүрлээр цутгаж хийсэн нүд, мэлмий болон бусад зүйлсийг шороон будгаар бүтээсэн Ногоон дарь эх, Улаан жамсран бурхан, Сэлэнгэ сумын 1 иргэнд хадгалагдаж буй 1940-д оны үед хамаарах Цэнд судар, Сэлэнгэ сумын 1 иргэнд хадгалагдаж буй 18-р зууны сүүл үед хамаарах Цөгц, Гурванбулаг сумын 1 иргэнд хадгалагдаж буй 1930-аад оны үед хамаарах төвөд үсгээр муутуу цаасан дээр бичсэн судар, мөнгөн гуутай алтан бурхан, Сайхан сумын хийдэд хадгалагдаж буй 12 баримтат өв, жамсран сахиус цутгамал бурхан, дамдин сахиус бурхны зураг, хэнгэрэг шашны хөгжмийн зэмсэг, цан шашны хөгжмийн зэмсэг, дун шашны хөгжмийн зэмсэг, арван хангал сахиус ном судар, их манал бурхны зураг, сандуйнжуд судар ном, их чээжүү судар ном, ногоон дарь эхийн мандал шиваа судар ном, цагаан дарь эхийн мандал шиваа судар ном, Найман чого судар ном зэрэг нийт 25 баримтат өвийг бүртгэн баримтжуулсан. |
| | | | Сурталчлан таниулсан өв | Тоо | 2024 | 5 | 6 | 27 | 100 | 8 | 8 | 100 | 2025 онд соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгэгдсэн өвийг өвлүүлэн уламжлуулах зорилгоор 7 сумын соёлын төв монгол гэрийн уламжлалт зан үйл, бий биелгээ зэрэг соёлын боловсролын сургалтын 3 төрлийн өвийг сурталчлах хөтөлбөрийг хэрэгжүүлж, шавь сургалтад 630 хүүхэд тогтмол хичээллэж байна. Мөн соёлын биет бус өвийг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр 7 сумын соёлын төв 8 төрлийн тэмцээн уралдаанд 1147 иргэнийг хамруулж, Нүүдэлчин Монгол дэлхийн соёлын фестивальд соёлын боловсролын хөтөлбөрөөр дамжуулан 6 ай савын 24 өвийн төрлийг 10 мянга орчим хүнд түгээн дэлгэрүүллээ. |
| **1.7.4** | | Бүх нийтийн соёлын боловсролыг хөгжүүлэх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | Төлөвлөгөөний хэрэгжилт | Хувь | 2024 | 80 | 85 | 94.7 | 100 | - | - | - | Аймгийн хэмжээнд бүх нийтийн соёлын боловсролыг түгээн дэлгэрүүлэх, иргэдийн соёлын мэдлэг, боловсролыг дээшлүүлэх зорилгоор 4 зорилт, 19 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг боловсруулан батлуулж, 94.7 хувьтай хэрэгжүүлээд байна. Тус ажлын хүрээнд утга зохиол, үндэсний бичиг соёлоор дамжуулан бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлэх, урлаг, уран бүтээлээр дамжуулан бүх нийтэд гоо зүйн боловсрол олгох, түүх, соёлын дурсгалт газрууд болон соёлын өвийг таниулах замаар үндэсний соёлын дархлаатай иргэдийг нэмэгдүүлэх, нийгмийн харилцааны соёлыг дээшлүүлэх сургалт, нөлөөллийн 18 арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 33700 иргэнд соёлын үйлчилгээ үзүүллээ. Мөн "Соёлын орон зай-Бидний орчин" бүтээлч аяны хүрээнд 93 арга хэмжээг төлөвлөн зохион байгуулж, 7814 иргэнийг хамруулав. |
| **1.7.1.1** | | Соёл урлагийн ажилтнуудыг гадаад дотоодод мэргэшүүлэх, давтан сургах ажлыг ээлж дараатай зохион байгуулна. | Мэргэшсэн хүний нөөцийн хангалт | Хувь | 2024 | 68.2 | 70 | 71.7 | 100 | - | - | - | Аймгийн соёл, урлагийн салбарт 184 ажилтан ажиллаж байна. Үүнээс мэргэжил шаардагдах 145 орон тоонд 71.7 хувь буюу 104 мэргэжлийн, 41 мэргэжлийн бус ажилтан байна. |
| | | | Мэргэшүүлэх сургалтад хамрагдсан албан хаагчид | Тоо | 2024 | 1 | 2 | 12 | 100 | - | - | - | Аймгийн соёл, урлагийн салбарт нийт 184 ажилтан ажиллаж байгаагаас мэргэжил шаардах 145 орон тоонд 71.7 хувь буюу 104 мэргэжлийн, 41 мэргэжлийн бус ажилтан байна. Эдгээрээс 12 ажилтан Соёл урлагийн их сургууль болон Сити их сургуулийн эчнээ ангид суралцаж байгаа бөгөөд байгууллагууд мэргэжлийн ажилтан болгон бэлтгэхэд дэмжлэг үзүүлж, суралцах хугацаанд нь цалинтай чөлөө олгон ажиллаж байна. Мөн музейн ажилтнуудыг чадавхжуулах "Музейн үзүүллэг дэглэлт" танхимын сургалтад 30 албан хаагч, үндэсний Урлагийн их театр туршлага судлах сургалтад Хөгжимт жүжгийн театрын хор ангийн 9 албан хаагч, соёлын байгууллагуудын техникчдийг чадавхжуулах танхимын сургалтад 13 албан хаагчийг хамруулав. |
| | | | Тэтгэлэгт хамрагдсан сурагчид | Тоо | 2024 | 6 | 5 | 7 | 100 | 43.0 | 43.0 | 100 | Соёлын салбарын мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх ажлын хүрээнд Соёл урлагийн их сургуулийн Хөгжим, бүжиг, соёлын менежментийн ангид элсэн суралцах 7 хүүхдэд аймгийн Засаг даргын нэрэмжит тэтгэлэг олгож, орон нутгийн төсвөөс 43.0 сая төгрөг зарцуулав. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **1.7.1.2** | | Шилдэг бүтээл болон улсын, олон улсын чанартай уралдаан, тэмцээнд онцгой амжилт гаргасан орон нутгийн уран бүтээлчдийг шагнаж урамшуулах бодлого баримтална. | Урамшуулал олгосон албан хаагчид | Тоо | 2024 | 0 | 2 | 1 | 50 | 3.0 | 3.0 | 100 | Шилдэг бүтээл болон улс, олон улсын чанартай уралдаан, тэмцээнд онцгой амжилт гаргасан уран бүтээлчдийг урамшуулах журмын төсөлд санал авч боловсруулан иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна. Мөн 32 дахь удаагийн "Соёл урлагийн ажилтны өдөр"-ийг тохиолдуулан 2025 онд үр бүтээлтэй ажиллаж, тэмцээн уралдаанд амжилт гарган бусдыгаа манлайлан ажилласан Хөгжимт жүжгийн театрын дарга, Хөгжимт жүжгийн театрын уран бүтээлч, Гурванбулаг сумын соёлын төвийн номын санч, Бүрэгхангай сумын соёлын төвийн хөгжмийн багш, Баяннуур сумын соёлын төвийн үйлчлэгч зэрэг 5 албан хаагчийг 2.0 сая төгрөг, соёлын үнэт өвийг түгээн дэлгэрүүлэх, хадгалж хамгаалах, хойч үедээ өвлүүлэн үлдээх үйлсэд бодит хувь нэмэр оруулсан Музейн захирал Т.Бэхтөрийг "Оюу мэлмий" тэргүүн шагналаар шагнаж 1.0 сая төгрөгөөр урамшууллаа. |
| **1.7.2.1** | | Соёлын төвүүдийн засвар үйлчилгээг сайжруулж, аймгийн Хөгжимт жүжгийн театр, Музейн барилгыг шинээр барина. | Засвар үйлчилгээ хийгдсэн барилга, байгууламж | Тоо | 2024 | 4 | 1 | 3 | 100 | 53.3 | 58.3 | 100 | Соёлын байгууллагуудын засвар үйлчилгээ орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор орон нутгийн төсвийн 10.0 сая төгрөгийн санхүүжилтээр Баяннуур сумын соёлын төвийн дээврийн засвар, орон нутгийн төсвийн 38.0 сая төгрөгийн санхүүжилтээр Орхон сумын соёлын төвийн дотор нойлын инженерийн шугам сүлжээ, сантехникийн тоноглол, хана, шал, таазны засвар шинэчлэл зэрэг орчин үеийн шаардлагад нийцсэн тохижилтын ажлуудыг иж бүрнээр хийж, Тэшиг сум, Хялганат тосгоны соёлын төвүүдэд номын сангийн өрөө, хөгжмийн багшийн өрөө, эрхлэгчийн өрөө, хувцас солих өрөө зэрэг зориулалтын өрөөнүүдэд орон нутгийн төсвийн 5.3 сая төгрөгийн санхүүжилтээр шаардлагатай засвар, тохижилтын ажлуудыг хийж, үйл ажиллагааны нөхцөлийг сайжрууллаа. |
| **1.7.2.2** | | Мэргэжлийн урлагийн байгууллага болон соёлын төвүүдийн тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлж, шаардлагатай хувцас хэрэглэлээр хангана. | Тоног төхөөрөмжийн хангалт | Хувь | 2024 | 70 | 73 | 73 | 100 | | | | Соёлын байгууллагыг орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр хангах ажлын хүрээнд улс, орон нутгийн төсөв болон хандив, тусламжийн 1,253.3 сая төгрөгийн хөрөнгөөр Нийтийн номын сан, Сайхан, Бугат, Баян-Агт сумын соёлын төвийг тавилга, эд хогшил, техник тоног төхөөрөмжөөр хангав. Мөн мэргэжлийн урлагийн байгууллагад иж бүрэн цахилгаан хөгжмийн зэмсэг, Хөгжимт жүжгийн театрт 8 ширхэг, Соёлын ордонд 20 ширхэг сургалтын гитар, Хутаг-Өндөр, Тэшиг, Бугат, Сэлэнгэ, Хангал сум, Хялганат тосгонд тус бүр 2 ширхэг сургалтын гитар олгов. Үүнээс гадна Сайхан, Булган сум, Орхон, Баян-Агт, Хангал, Бүрэгхангай сумын соёлын төвүүдэд лед дэлгэцийг суурилуулж ашиглалтад хүлээлгэн өгсөн. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас Тэшиг сумын соёлын төвд үзэгчийн сандал, номын тавиурын дэмжлэг үзүүлсэн. Дээрх ажлуудын үр дүнд сумын соёлын төвүүдийн техник, тоног төхөөрөмжийн хангалт 73.0 хувьд хүрч, иргэдэд соёлын үйлчилгээг чанартай, тасралтгүй хүргэх нөхцөл бүрдээд байна. |
| **1.7.2.3** | | Номын сангийн фонд баяжилт хийж, цахим номын сан, явуулын номын сангийн үйл ажиллагааг өргөжүүлнэ. | Явуулын номын сангийн үйлчилгээнд хамрагдсан иргэд | Тоо | 2024 | 1128 | 1240 | 3365 | 100 | - | - | - | Нийтийн номын сан болон 16 сум, 1 тосгоны соёлын төв 3365 иргэнд гэрээр номын сангийн үйлчилгээ үзүүлсэн байна. Мөн хүүхэд өсвөр үеийнхнийг номтой нөхөрлүүлэх зорилгоор "Хүүхдийн бүтээлч уншлага" аяныг зохион байгуулж, ерөнхий боловсролын 5 сургуулийн 27 бүлгийн давхардсан тоогоор 7237 хүүхдийг хамруулсан. Аймгийн хэмжээнд 370 удаагийн ангийн уншлагад давхардсан тоогоор 9237 сурагчийг хамруулж, явуулын номын сангийн үйлчилгээг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Политехникийн коллеж, Нийгмийн даатгалын газар, Булган сумын ЗДТГ, 3-р, 4-р, 7-р цэцэрлэг, Байгаль орчны газар, Авто тээврийн төв, Тагнуулын байгууллага, Татварын газар, Ус цаг уур орчны шинжилгээний төв зэрэг төрийн байгууллагууд болон Хан жаргалант төвийн худалдаа эрхлэгчдэд үзүүлэв. |
| | | | Дэмжлэг үзүүлсэн байгууллага | Тоо | 2024 | 0 | 1 | 14 | 100 | - | - | - | Уншигчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн шинэ номоор сан хөмрөгийг баяжуулах ажлын хүрээнд аймгийн хэмжээнд 14 соёлын байгууллага 1434 ширхэг номын сан хөмрөгийн баяжилт хийсэн. Нийтийн номын сан, Баян-Агт, Баяннуур, Бугат, Орхон, Рашаант, Хангал, Хишиг-Өндөр, Булган, Бүрэгхангай, Сайхан, Сэлэнгэ, Хутаг-Өндөр сум, Хялганат тосгоны соёлын төвийн номын санд худалдаагаар 153, хандиваар 699 ширхэг номоор сан хөмрөгийн баяжилт хийгдэж, хангалтыг 11.7 хувиар нэмэгдүүлээд байна. |
| | | | Шинээр бүртгэсэн үл хөдлөх дурсгал | Тоо | 2024 | 8 | 8 | 8 | 100 | 3 | 3 | 100 | Баян-Агт, Гурванбулаг, Баяннуур, Дашинчилэн, Бүрэгхангай сумдын нутаг дэвсгэрт орших Бүрээ толгойн хийдийн туурь, Хөшөө чулуу, Хадны сүг зураг, Согтуугийн голын хадны бичиг үсгийн дурсгал, Хэрмэн дэрсний балгас, Улаан тугалган хийдийн туурь, Хөх чулуутын хадны сүг зураг, Дашинчилэн сумын Найдаг уулын агуйд байрлах Хятаны их бага бичгийн дурсгал зэрэг 8 үл хөдлөх дурсгалыг бүртгэн баримтжуулсан. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.7.3.1 | **Үйл ажиллагаа** | Соёлын биет болон биет бус өвийн хадгалалт хамгаалалтыг сайжруулж, өвлөн уламжлуулах ажлыг үе шаттай зохион байгуулна. | Шинээр бүртгэсэн баримтат өв | Тоо | 2024 | 20 | 25 | 25 | 100 | - | - | - | Иргэдийн гар дээр болон сүм хийдэд хадгалагдаж буй түүхэн тодорхой он цагийг илтгэх байгаль, нийгэм, түүх, соёл, урлаг, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдол бүхий мэдээлэл агуулсан баримтат өвийг бүртгэн баримтжуулах зорилгоор Баян-Агт сумын 1 иргэнд хадгалагдаж буй 225-300 жилийн түүхтэй шүрэн чимэгтэй эхнэр малгай, Сампин зангидаж оройг нь үүлэн хээгээр бүрсэн ширмэл оёдолтой лам малгай, Чин ван 13-р Далай ламын хантааз, Баяннуур сумын 1 иргэнд хадгалагдаж буй 1930-аад оны үед хамаарах бороонь хариулга судар, Бугат сумын 1 иргэнд хадгалагдаж буй 17-р зууны үед хамаарах Алтангэрэл судар, Булган сумын Дашчойнхорлин хийдэд хадгалагдаж буй 18-р зууны үед хамаарах төрийн долоон эрдэнэ мөнгөн цөгц, Бүрэгхангай сумын 1 иргэнд хадгалагдаж буй 18-р зууны үед хамаарах төвөд үсгээр муутуу цаасан дээр хар бэхээр бичсэн 400 гаруй хуудастай судар, Могод сумын хийдэд хадгалагдаж буй Өндөр гэгээн Занабазарын дэг сургуулиар нухмал алтаар бүрж хүрлээр цутгаж хийсэн нүд, мэлмий болон бусад зүйлсийг шороон будгаар бүтээсэн Ногоон дарь эх, Улаан жамсран бурхан, Сэлэнгэ сумын 1 иргэнд хадгалагдаж буй 1940-д оны үед хамаарах Цэнд судар, Сэлэнгэ сумын 1 иргэнд хадгалагдаж буй 18-р зууны сүүл үед хамаарах Цөгц, Гурванбулаг сумын 1 иргэнд хадгалагдаж буй 1930-аад оны үед хамаарах төвөд үсгээр муутуу цаасан дээр бичсэн судар, мөнгөн гуутай алтан бурхан, Сайхан сумын хийдэд хадгалагдаж буй 12 баримтат өв, жамсран сахиус цутгамал бурхан, дамдин сахиус бурхны зураг, хэнгэрэг шашны хөгжмийн зэмсэг, цан шашны хөгжмийн зэмсэг, дун шашны хөгжмийн зэмсэг, арван хангал сахиус ном судар, их манал бурхны зураг, сандуйнжүд судар ном, их чэжүү судар ном, ногоон дарь эхийн мандал шиваа судар ном, цагаан дарь эхийн мандал шиваа судар ном, Найман чого судар ном зэрэг нийт 25 баримтат өвийг бүртгэн баримтжуулсан. |
| | | | Сурталчлан таниулсан өв | Тоо | 2024 | 5 | 6 | 27 | 100 | 8 | 8 | 100 | 2025 онд соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгэгдсэн өвийг өвлүүлэн уламжлуулах зорилгоор 7 сумын соёлын төв монгол гэрийн уламжлалт зан үйл, бий биелгээ зэрэг соёлын боловсролын сургалтын 3 төрлийн өвийг сурталчлах хөтөлбөрийг хэрэгжүүлж, шавь сургалтад 630 хүүхэд тогтмол хичээллэж байна. Мөн соёлын биет бус өвийг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр 7 сумын соёлын төв 8 төрлийн тэмцээн уралдаанд 1147 иргэнийг хамруулж, Нүүдэлчин Монгол дэлхийн соёлын фестивальд соёлын боловсролын хөтөлбөрөөр дамжуулан 6 ай савын 24 өвийн төрлийг 10 мянга орчим хүнд түгээн дэлгэрүүллээ. |
| 1.7.3.2 | | Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжинэ. | Дэмжлэг үзүүлсэн ААН, иргэд | Тоо | 2024 | 2 | 3 | 9 | 100 | 8 | 8 | 100 | Орон нутгийн онцлог бүхий соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлж соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих зорилгоор 14 сумын Соёлын төв 15 удаа үзэсгэлэн зохион байгуулж, 97 соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчид металь урлал, модон эдлэл, зээлэн эдлэл, уран дархан, эсгий урлал зэрэг бүтээлүүдийг олон нийтэд сурталчлан таниуллаа. Мөн "Хойд бүсийн түншлэл хамтын ажиллагаа" үзэсгэлэн, орон нутгийн бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийн үзэсгэлэн арга хэмжээнд 12 сумын 34 соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгч, 4 аж ахуйн нэгж, "Айраг фестиваль" эвент арга хэмжээнд 10 сумын 39 соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгч, Нүүдэлчин дэлхийн соёлын фестивальд 6 сумын 9 соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчид орон нутгийн төсвөөс 8.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, "Миний Булганы алтан намар" үзэсгэлэнд 4 сумын 8 соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчийн бүтээлийг эдийн засгийн эргэлтэд оруулах нөхцөл боломжийг бүрдүүлж, 94.9 сая төгрөгийн орлого олсон байна. |
| | | | Хамрагдсан иргэд | Тоо | 2024 | 25000 | 26000 | 33700 | 100 | - | - | - | Утга зохиол, үндэсний бичиг соёлоор дамжуулан бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлэх чиглэлээр 18 сургалт, нөлөөллийн арга хэмжээнд давхардсан тоогоор 33700 иргэнийг хамруулаад байна. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **1.7.4.1** | | Хүн амын онцлог хэрэгцээнд нийцсэн соёлын олон талт үйл ажиллагааг зохион байгуулна. | Зохион байгуулсан арга хэмжээ | Тоо | 2024 | 24 | 26 | 18 | 69.2 | - | - | - | Аймгийн хэмжээнд бүх нийтийн соёлын боловсролыг түгээн дэлгэрүүлэх, иргэдийн соёлын мэдлэг, боловсролыг дээшлүүлэх зорилгоор 4 зорилт, 19 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг боловсруулан батлуулж, 94.7 хувьтай хэрэгжүүлээд байна. Тус ажлын хүрээнд утга зохиол, үндэсний бичиг соёлоор дамжуулан бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлэх, урлаг, уран бүтээлээр дамжуулан бүх нийтэд гоо зүйн боловсрол олгох, түүх, соёлын дурсгалт газрууд болон соёлын өвийг таниулах замаар үндэсний соёлын дархлаатай иргэдийг нэмэгдүүлэх, нийгмийн харилцааны соёлыг дээшлүүлэх сургалт, нөлөөллийн 18 арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 33700 иргэнд соёлын үйлчилгээ үзүүллээ. Мөн "Соёлын орон зай-Бидний орчин" бүтээлч аяны хүрээнд 93 арга хэмжээг төлөвлөн зохион байгуулж, 7814 иргэнийг хамруулав. |
| **1.7.4.2** | | Хүүхэд залуучуудын соёл урлагийн авьяасыг нээн илрүүлэх, хөгжүүлэх ажлыг зохион байгуулна. | Соёлын урлагийн дугуйланд хичээллэж байгаа хүүхэд | Тоо | 2024 | 2220 | 2250 | 2300 | 100 | - | - | - | Аймгийн хэмжээнд Хөгжимт жүжгийн театр, соёлын төвүүдийн дэргэдэх 12 төрлийн шавь сургалт, бий биелгээ, морин хуур, шагайн харваа, уртын дуу, акустик гитар, бөмбөр, даралтат хөгжим, ардын бүжиг, чөлөөт бүжиг, ёочин, ятга зэрэг 23 төрлийн дугуйланд 2300 хүүхэд хамрагдаж байна. |
| | | | Дугуйлангийн төрөл | Тоо | 2024 | 21 | 22 | 23 | 100 | - | - | - | Аймгийн хэмжээнд Хөгжимт жүжгийн театр, Соёлын төвүүдийн дэргэдэх 12 төрлийн шавь сургалт, бий биелгээ, морин хуур, шагайн харваа, уртын дуу, акустик гитар, бөмбөр, даралтат хөгжим, ардын бүжиг, чөлөөт бүжиг, ёочин, ятга зэрэг 23 төрлийн дугуйлан тогтмол хичээллэж байна. |
| **1.7.4.3** | | Амьд хөгжим хөтөлбөр хэрэгжүүлнэ. | Хэрэгжилтийн хувь | Хувь | 2024 | 0 | 30 | 21 | 70 | 32 | 32 | 100 | “Амьд хөгжим” хөтөлбөрийг 5 зорилтын 22 арга хэмжээг төлөвлөн 10 шалгуур үзүүлэлтийн хамт аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 09 дүгээр сарын 29-ний өдрийн XI/75 тогтоолоор батлуулан орон нутгийн төсвийн 11.5 сая төгрөгөөр хамтран ажиллах гэрээг "DGL хөгжмийн академи"-тай байгуулсан. Тус хөтөлбөрийн хүрээнд Жаргалант хүүхдийн зусланд ЕБС-ийн 70 хүүхэд, 16 сум, 1 тосгоны 25 багшийг хамруулсан 7 хоногийн танхимын сургалт зохион байгуулж, мэргэжлийн урлагийн байгууллага болон 10 суманд амьд хөгжмийн дугуйланд 224 хүүхэд хичээллэж байна. Орон нутгийн төсвийн 16.1 сая төгрөгийн санхүүжилтээр Хөгжимт жүжгийн театрт иж бүрэн цахилгаан хөгжмийн хэрэгсэл, сургалтын зориулалттай 50 гитарыг мэргэжлийн урлагийн байгууллага, 7 суманд олгож тухайн жилийн төлөвлөгөөг 70 хувьтай хэрэгжүүллээ. |
| | | | Хамрагдсан иргэд | Тоо | 2024 | 150 | 230 | 224 | 92.5 | - | - | - | “Амьд хөгжим” хөтөлбөрийг 5 зорилтын 22 арга хэмжээг төлөвлөн 10 шалгуур үзүүлэлтийн хамт аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 09 дүгээр сарын 29-ний өдрийн XI/75 тогтоолоор батлуулан орон нутгийн төсвийн 11.5 сая төгрөгөөр хамтран ажиллах гэрээг "DGL хөгжмийн академи"-тай байгуулсан. Тус хөтөлбөрийн хүрээнд Жаргалант хүүхдийн зусланд ЕБС-ийн 70 хүүхэд, 16 сум, 1 тосгоны 25 багшийг хамруулсан 7 хоногийн танхимын сургалт зохион байгуулж, мэргэжлийн урлагийн байгууллага болон 10 суманд амьд хөгжмийн дугуйланд 224 хүүхэд хичээллэж байна. Орон нутгийн төсвийн 16.1 сая төгрөгийн санхүүжилтээр Хөгжимт жүжгийн театрт иж бүрэн цахилгаан хөгжмийн хэрэгсэл, сургалтын зориулалттай 50 гитарыг мэргэжлийн урлагийн байгууллага, 7 суманд олгосон. |
| **Аялал жуулчлал** | | | | | | | | | | | | | |
| **1.8** | **ТЕЗ** | Бүс, нутгийн аялал жуулчлалыг хөгжүүлнэ. | Бүсчилсэн аялал жуулчлалын маршрут | Тоо | 2024 | 0 | 5 | 0 | 0 | - | - | - | Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын тушаалаар батлагдсан Хойд бүс хариуцсан соёл, аялал жуулчлалын үзэл баримтлал боловсруулах судалгааны баг ирж, аймгийн аялал жуулчлалын өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлууд, хойд бүсийн нэгдсэн аялал жуулчлалын маршрут тогтоох асуудлаар санал солилцон, судалгааны үндсэн дээр бүсийн нэгдсэн аялал жуулчлалын маршрут гарахаар төлөвлөгдөж байна. |
| | | | Жуулчид | Тоо | 2024 | 180530 | 181530 | 182000 | 100 | - | - | - | Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжийн мэдээллийг шинэчлэн 2025 онд дайран өнгөрсөн болон зорин ирсэн гадаад, дотоодын 182000 аялагчид хүрэлцэн ирсэн тоон мэдээлэл гараад байна. |
| | | | Төсөлд хамрагдсан малчин өрх | Тоо | 2024 | 0 | 100 | 52 | 52 | 3 | 3 | 100 | Аймгийн хэмжээнд НИТАЖ үйл ажиллагааг 6 сумын 52 өрх эрхлэн явуулж байгаа бөгөөд тэдэнд зориулсан захиалгын үйлчилгээ бүхий Gerbook платформ танилцуулга болон зочлох үйлчилгээний сургалтыг Рашаант суманд зохион байгуулж, 20 өрхийг хамруулан бүртгэлжүүлэв. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **1.8.1** | **Хөтөлбөрийн** | Орон нутгийн онцлогт түшиглэсэн, төрөлжсөн, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ. | Шинээр баригдсан түр буудаллах цэг | Тоо | 2024 | 0 | 1 | 0 | 0 | - | - | - | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 189 дүгээр тогтоолын дагуу орон нутгийн эдийн засаг, аялал жуулчлал, үйлчилгээний салбарт түлхэц үзүүлж, зорчигчдын аюулгүй байдал, тав тухыг хангах зорилгоор Дашинчилэн сумын нутаг дэвсгэрт түр буудаллах цэг, үйлчилгээний цогцолбор байгуулахаар төлөвлөсөн. Тус ажлын гүйцэтгэгч шалгаран бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлээд байна. |
| | | | Хүлээн авсан жуулчид | Тоо | 2024 | 180530 | 181530 | 182000 | 100 | - | - | - | Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжийн мэдээллийг шинэчлэн 2025 онд дайран өнгөрсөн болон зорин ирсэн гадаад, дотоодын 182000 аялагчид хүрэлцэн ирсэн тоон мэдээлэл гараад байна. |
| **1.8.1.1** | | Аялал жуулчлалын B, C зэрэглэлийн зам дагуу амрах өртөө, зорин очих газруудад ариун цэврийн байгууламж бүхий түр буудаллах цэг байгуулна. | Шинээр байгуулсан түр буудаллах цэг | Тоо | 2024 | 0 | 1 | 0 | 0 | - | - | - | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 189 дүгээр тогтоолын дагуу орон нутгийн эдийн засаг, аялал жуулчлал, үйлчилгээний салбарт түлхэц үзүүлж, зорчигчдын аюулгүй байдал, тав тухыг хангах зорилгоор Дашинчилэн сумын нутаг дэвсгэрт түр буудаллах цэг, үйлчилгээний цогцолбор байгуулахаар төлөвлөсөн. Тус ажлын гүйцэтгэгч шалгаран бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлээд байна. |
| **1.8.1.2** | | Хөвсгөл, Булган, Орхон аймгийн нутаг дэвсгэрийг хамарсан Дархадын хотгор, Хөвсгөл нуур, Сэлэнгэ мөрний сав дагуух экосистемд түшиглэсэн байгалийн олон төрөлт аяллын чиглэлийг хөгжүүлэх "ХӨХ БААВГАЙ" аялал жуулчлалын кластерт нэгдэнэ. | Төлөвлөгөөний хэрэгжилт | Хувь | 2024 | 0 | 50 | 0 | 0 | 8 | 8 | 100 | Аймгийн аялал жуулчлалын 2025 оны төлөвлөгөөг 4 зорилт 22 арга хэмжээтэйгээр боловсруулан батлуулж, 72.6 хувьтай хэрэгжүүлэв. Тухайлбал, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгчдийн судалгааг шинэчилж, НИТАЖ эрхлэгчдэд зориулсан зочлох үйлчилгээний сургалт, "Жуулчны хөтөч тайлбарлагч бэлтгэх" сургалтад 51 аж ахуйн нэгжийн 132 иргэнийг оролцуулж, "Хангинахын шугуйн шагайн тойром-2025", "Айраг фестиваль" эвент арга хэмжээ зэрэг ажлуудад орон нутгийн төсвийн 230.0 сая төгрөгийг зарцуулан зохион байгуулж, гадаад дотоодын 34000 орчим жуулчид хүрэлцэн ирж үзэж сонирхлоо. |
| | | | Хамтран ажилласан байгууллага | Тоо | 2024 | 10 | 20 | 20 | 100 | - | - | - | Аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр 4 зорилт, 22 арга хэмжээ бүхий 2025 оны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, 72.6 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүллээ. Тус ажлын хүрээнд үндэсний 2 эвент арга хэмжээ, зочлох үйлчилгээний сургалт, жуулчны хөтөч тайлбарлагч бэлтгэх сургалтуудыг зохион байгуулан Монголын аялал жуулчлалын холбоо, аймгийн аялал жуулчлалын холбоо, бөх, сур, шагайн холбоо зэрэг 5 холбоо, 15 аж ахуйн нэгжтэй хамтран ажиллаж, төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг үр дүнтэй зохион байгууллаа. |
| **1.8.1.3** | | "Нэг өрх- Жуулчин гэр" НИТАЖ төслийг хэрэгжүүлнэ. | Төсөлд хамрагдсан малчин өрх | Тоо | 2024 | 0 | 100 | 52 | 52 | - | - | - | Аймгийн хэмжээнд нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын үйл ажиллагааг Рашаант, Хангал, Орхон, Хутаг-Өндөр, Сэлэнгэ суманд 52 өрх эрхлэн явуулж байгаа бөгөөд тэдэнд зориулсан захиалгын үйлчилгээ бүхий Gerbook платформ танилцуулга болон зочлох үйлчилгээний сургалтыг Рашаант сумандзохион байгуулж, 20 өрхийг хамруулан бүртгэлжүүлэв. Мөн "Нэг өрх – Жуулчин гэр" төслийн хүрээнд Сэлэнгэ сумын иргэн Б.Отгончимэг "Зочлох үйлчилгээний сургалт" үйл ажиллагаанд хамрагдаж, гэр жуулчны үйл ажиллагаагаа эрхэлж, Хутаг-Өндөр сумын иргэн Х.Энхбилэгийн гэр бүл "Хөдөөтэй танилцъя амралт, сургалт, аялал"-ыг санаачлан хүүхдийн хүмүүжлийн талаарх сургалт, завиар аялах, морь унах зэрэг жуулчдад чиглэсэн олон талт арга хэмжээг зохион байгуулан чанартай үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. |
| **1.8.1.4** | | Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудыг чадавхжуулж, үйлчилгээ, орчныг стандартын шаардлагад нийцүүлнэ. | Сургалтад хамрагдсан аж ахуйн нэгж | Тоо | 2024 | 0 | 30 | 51 | 100 | 9.9 | 9.9 | 100 | Орон нутгийн аялал жуулчлалын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, үйлчилгээний чанар, стандарт, хүртээмжийг сайжруулах, аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг бэлтгэх зорилгоор зочлох үйлчилгээний сургалт, жуулчны хөтөч тайлбарлагч бэлтгэх сургалтуудыг зохион байгуулж, 51 аж ахуйн нэгжийн 132 иргэнийг оролцуулан мэргэшүүлэх сургалтад хамрагдсан сертификат олголоо. Мөн "Стандарттай Булган" сэдэвт сургалт, нөлөөллийн арга хэмжээг 15 сум, 1 тосгонд зохион байгуулж, 550 хүнийг хамруулав. |
| | **Үйл ажиллагаа** | | Стандарт хангасан аж ахуйн нэгж | Тоо | 2024 | 67 | 87 | 81 | 70 | - | - | - | Аймгийн хэмжээнд аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгч 217 аж ахуйн нэгжээс 2024 онд 67 аж ахуйн нэгж боловсон ариун цэврийн байгууламжтай байсан бол 2025 онд 6 жуулчны бааз, 2 зочид буудал, 6 амралтын газар гадна ариун цэврийн байгууламжаа шинэчиллээ. Мөн үйлчилгээний чанар, стандарт, хүртээмжийг сайжруулах зорилгоор зочлох үйлчилгээний сургалтыг зохион байгуулж, 51 аж ахуйн нэгж, 100 гаруй иргэдийг хамруулж, үйлчилгээ болон орчны стандартын шаардлага хангасан 81 аж, ахуйн нэгжтэй болсон. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **1.8.1.5** | | Улсын болон орон нутгийн чанартай эвент арга хэмжээг нэмэгдүүлнэ. | Эвент арга хэмжээ | Тоо | 2024 | 2 | 2 | 2 | 100 | 230 | 230 | 100 | 2025 онд аймгийн хэмжээнд 2 эвент арга хэмжээг төлөвлөн “Хангинахын шугуйн шагайн тойром-2025” эвентэд 7 аймгийн 250 гаруй ахмад болон залуу харваачид цэц мэргэнээ сорин өрсөлдөж, "Айраг фестиваль 2025" хөхүүрийн шилдэг айргийг шалгаруулах, ардын уламжлалт ёс, зан үйлийг сэргээх, түүнийг дагасан уламжлалт 14 тэмцээн уралдааныг зохион байгуулж, Булган, Орхон, Хөвсгөл аймгаас 722 оролцогч бүртгүүлж, шилдгүүдээ тодруулаа. Эвентийг үзэж сонирхохоор ирсэн гадаад дотоодын 34 мянга орчим жуулчин 16 сум, 1 тосгоны орон нутгийн онцлогийг шингээсэн идээ ундааны соёлыг сурталчлах өргөө, гэр театрын үзвэр үйлчилгээг үзэн сонирхож, соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчид, урчууд, өвлөн уламжлагчид орон нутгийн онцлогийг харуулсан брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, айраг сүү, сүүн бүтээгдэхүүн худалдаа үйлдвэрлэгч малчин, иргэн худалдаа хийж, нийт 500.0 сая төгрөгийн борлуулалтын орлого олсон. |
| | | | Хүлээн авсан жуулчид | Тоо | 2024 | 180530 | 181530 | 182000 | 100 | - | - | - | Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжийн мэдээллийг шинэчлэн 2025 онд дайран өнгөрсөн болон зорин ирсэн гадаад, дотоодын 182000 аялагчид хүрэлцэн ирсэн тоон мэдээлэл гараад байна. |
| **1.8.1.6** | | Жорлонгоо өөрчилье, хогоо шийдье уриан дор байгальд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлнэ | Эко 00, хог хаягдлын цэгтэй аж ахуйн нэгж | Тоо | 2024 | 67 | 10 | 14 | 100 | - | - | - | "Ариун цэврийн өрөөгөөр чөлөөтэй үйлчлүүлэх нөхцөл бүрдүүлэх тухай" Аймгийн Засаг даргын 2025 оны А/317 дугаар захирамж гарган биелэлтийг хангуулахаар Байгаль орчны газрын даргын 1/295 дугаар албан бичгийг хүргүүлж, 2025 онд 6 жуулчны бааз, 2 зочид буудал, 6 амралтын газар, нийт 14 аж ахуйн нэгж гадна ариун цэврийн байгууламжаа шинэчлэн, стандартын шаардлага хангасан 81 байгууламжтай болсон. |
| **1.8.1.7** | | Аялал жуулчлалын бүсэд орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг худалдаалах нөхцөлийг бүрдүүлнэ. | Шинээр баригдсан борлуулалтын цэг | Тоо | 2024 | 0 | 1 | 0 | 0 | - | - | - | "Айраг фестиваль 2025" хөхүүрийн шилдэг айргийг шалгаруулах, ардын уламжлалт ёс, зан үйлийг сэргээх, түүнийг дагасан уламжлалт 14 тэмцээн уралдааныг зохион байгуулж, Булган, Орхон, Хөвсгөл аймгаас 722 оролцогч бүртгүүлж, шилдгүүдээ тодруулаа. Үүний үр дүнд соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчид, орон нутгийн онцлогийг харуулсан айраг, сүү, цагаан идээ зэрэг брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид 229.0 сая төгрөгийн борлуулалтын орлогыг олсон байна. Мөн “Миний Булганы алтан намар” үзэсгэлэнгийн хүрээнд соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчид болон айраг, сүү, цагаан идээ зэрэг орон нутгийн онцлог бүтээгдэхүүн үйлдвэрлэгч иргэн, аж ахуйн нэгжүүдтэй уулзалт зохион байгуулж, нэг цэгийн үйлчилгээ бүхий “Булганд үйлдвэрлэв” брэнд бүтээгдэхүүний борлуулалтын цэг байгуулахаар санал солилцов. |
| **1.8.1.8** | | Тусгай сонирхлын болон соёлын аялал жуулчлалыг хөгжүүлнэ. | Контентын тоо | Тоо | 2024 | 0 | 2 | 4 | 100 | - | - | - | Аймгийн аялал жуулчлалын 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан тусгай сонирхлын аялал жуулчлалыг сурталчлан таниулах ажлын хүрээнд 3 сумын түүх, соёлын дурсгалт газар, байгалийн үзэсгэлэнт орчин, нүүдлийн ахуй, үндэсний өв соёлын онцлогийг тусгасан түүх соёлын, байгалийн адал явдалт, рашаан сувилал, эрүүл мэндийн зэрэг 4 контентыг хэвлэл мэдээлэл, цахим сүлжээгээр дамжуулан олон нийтэд сурталчлан ажиллав. |
| | | | Тусгай сонирхлын аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж | Тоо | 2024 | 0 | 2 | 2 | 100 | - | - | - | Тэшиг сумын "Бүтэлэ", Сэлэнгэ сумын "Seven nuga" ресорт амралт жуулчны бааз нь загасчлах, моторт завь, явган аялал, морь унах зэрэг олон төрлийн үйл ажиллагаа бүхий хөтөлбөрт аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлж байна. |
| **ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН СЭРГЭЛТ** | | | | | | | | | | | | | |
| **Эдийн засаг** | | | | | | | | | | | | | |
| **2.1** | **ТЕЗ** | Төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлж, олон тулгуурт эдийн засгийг хөгжүүлнэ. | Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт | Тэрбум төгрөг | 2023 | 630.1 | 732.0 | 637.6 | 7.4 | | | | 2024 онд аймгийн ДНБ 601.6 тэрбум төгрөг болсон байна. 2025 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр аймгийн ДНБ 637.6 тэрбум төгрөгт хүрэх төлөвтэй байна. |
| **2.1.1** | | Аймгийн нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүнийг 15.0 сая төгрөгт хүргэнэ. | Нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ | сая.төг | 2023 | 10.3 | 12 | 10.6 | 17.6 | - | - | - | Аймгийн нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн 2024 онд 9.9 сая төгрөгт хүрсэн байна. 2025 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн 10.6 сая төгрөгт хүрсэн нь 2024 онтой харьцуулахад 6 хувиар өсөлттэй гарахаар байна. Үйлчилгээний салбар өмнөх оноос 9 хувиар өсөж, 46.4 тэрбум төгрөгийн өсөлттэй байна. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.2 | Хөтөлбөрийн | Татварын бааз суурь, төсвийн орлогыг нэмэгдүүлнэ. | Төсвийн орлогын төлөвлөгөөний хэрэгжилт | хувь | 2023 | 106.9 | 108 | 102.1 | 100 | | | | 2025 оны эхний 10 сарын байдлаар улсын төсөвт 2,356.9 сая төгрөг төвлөрүүлэхээс 2,558.1 сая төгрөг төвлөрүүлж орлогын төлөвлөгөөг 108.5 хувь, аймгийн төсөвт 29,592.5 сая төгрөг төвлөрүүлэхээс 30,610.2 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 103.4 хувь, сумын төсөвт 25,371.1 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 100 хувь, нийт 57,320.5 сая төгрөг төвлөрүүлэхээс 58,539.4 сая төгрөгийг төвлөрүүлэн төсвийн орлогын төлөвлөгөөг 102.1 хувиар биелүүлэн ажиллаж байна. Тайлант хугацаанд улсын бүртгэлийн байгууллагад шинээр үүсгэн байгуулагдсан 263 хуулийн этгээдийг шинээр татвар төлөгчөөр бүртгэсэн ба татвар төлөгчийн тоо 11.0 хувь, 1781 иргэнийг шинээр татвар төлөгчөөр бүртгэн бүртгэлтэй татвар төлөгч иргэний тоо 3.8 хувиар тус тус өссөн байна. |
| 2.1.3 | | Орон нутгийн өмчит компанийн үр ашгийг нэмэгдүүлнэ. | Орон нутгийн өмчит компанийн хөрөнгийн өгөөж (ROA) | хувь | - | - | 1.0 | 0.41 | 41.0 | | | | 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар орон нутгийн өмчит компани, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрууд 14,621.1 сая төгрөгийн орлого олж, 14,065.2 сая төгрөгийг зарцуулж, 555.9 сая төгрөгийн ашигтай ажилласан байна. Тэшиг ус ОНӨААТҮГ, ХААХИ ОНӨХХК-иуд ашигтай ажиллаж, Илчит хутаг ОНӨААТҮГ, Булган Мээж ОНӨХХК тус тус алдагдалтай ажилласан. Хөрөнгийн өгөөж дунджаар 0.41 байна. |
| 2.1.4 | | Бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэн, үйлдвэрлэлийг хөгжүүлж, эдийн засгийн өсөлтийг дэмжинэ. | Үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өртгийн өсөлт | тэрбум | 2023 | 250.1 | 275.1 | 292.96 | 100 | - | - | | 2024 онд аймгийн ДНБ 601.6 тэрбум төгрөгт хүрч үйлдвэрлэл үйлчилгээний салбар 48.7 хувь буюу 292.96 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байна. Үүнээс үйлдвэрлэлийн салбар нь 13.7 хувь буюу 82.4 тэрбум, үйлчилгээний салбар 35 хувийг буюу 210.56 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн тус тус үйлдвэрлэсэн байна. |
| 2.1.1.1 | | Хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг оновчтой тодорхойлж, төсөл хөтөлбөрүүдийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ. | Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ | Тэрбум төгрөг | 2024 | 61.6 | 62.0 | 101.2 | 100 | - | - | | 2025 онд 20 төсөл арга хэмжээний 101.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт батлагдсан байна. |
| | | | Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ | Тэрбум төгрөг | 2024 | 23.7 | 24.0 | 21 | 87.5 | - | - | | 2025 онд 112 төсөл арга хэмжээний 21.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт батлагдсан байна. |
| | | | Гадаадын зээл тусламж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын хэмжээ | Тэрбум төгрөг | 2024 | 1 | 2.0 | 2 | 100 | 2000.0 | 2000.0 | 100 | "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрын хөрөнгө оруулалтаар байгаль орчныг хамгаалах, аялал жуулчлалыг хөгжүүлэх, нүүдэлчин өв соёлыг түгээн дэлгэрүүлэх олон улсын болон орон нутгийн соёлын эвент, арга хэмжээ зохион байгуулах 50 сая төгрөг, уул уурхайг ашиглах, хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалахтай холбоотой хойд бүсийн чуулган, уулзалт, эдийн засаг, хөрөнгө оруулалтын форум зохион байгуулах 150 сая төгрөг, Хангал-Хялганат чиглэлийн орон нутгийн чанартай 53.6 км авто замын ашиглалт, хамгаалалт, арчилгааг хийх 50 сая төгрөг, Булган сумын 4 дүгээр баг Домын дэвсгэр үйлдвэржилтийн бүсэд цэвэр, бохир ус, дулааны шугам сүлжээг шинээр барихад дэмжлэг үзүүлэх 950 сая төгрөг, уул, уурхайг ашиглах хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалахтай холбогдуулан Булган аймагт нэн тэргүүнд хэрэгцээтэй мэргэжилтэн болон мэргэжилтэй ажилтан бэлтгэх 600 сая төгрөг, “Эрдэнэт цогцолбор” дээд сургуульд элссэн Булган аймгийн 35 оюутныг уул уурхайн чиглэлийн мэргэжилтнээр бэлтгэх 100 сая төгрөг, уул, уурхайг ашиглах, хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалахтай холбогдуулан шинээр ажлын байр бий болгох гарааны бизнес, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр 100 сая төгрөг, нийт 2.0 тэрбум төгрөгийг төлөвлөн хэрэгжүүлсэн. |
| 2.1.2.1 | | Татварын шинэчлэлийн хүрээнд бүсийн татварын бодлогыг хэрэгжүүлнэ. | Хамрагдах татвар төлөгчийн тоо | тоо | 2023 | - | 5 | 3 | 60 | | | | Бүсчилсэн хөгжлийн бодлого, хойд бүсийн "Шинэ хоршоо" хөдөлгөөний хүрээнд зохион байгуулагдсан "Хойд бүсийн хоршоологчдын нэгдсэн зөвлөгөөн"-д хамрагдсан шинээр үүсэн байгуулагдсан 45 хоршооны захирал, удирлагуудад татварын хууль тогтоомжийн талаар заавар зөвлөгөөг хүргэн шаардлагатай мэдээллээр хангаж ажилласан ба тайлант хугацаанд өөр аймаг дүүргээс 3 хуулийн этгээд Булган аймгийн үндсэн татвар төлөгчөөр шилжин бүртгэгдэж үйл ажиллагаагаа явуулж байна. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуульд орсон хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаарх нэмэлт өөрчлөлтийг аймгийн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдэд сурталчлах ажлыг татвар төлөгчийн ажлын байр болон танхимын сургалтыг зохион байгуулан ажиллаж байна. Тус хуулийн нэмэлт өөрчлөлтийн 3 удаагийн сургалтад 110 татвар төлөгчийг хамруулаад байна. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **2.1.2.2** | **Үйл ажиллагаа** | Татвар төлөгчийн татварын боловсролыг дээшлүүлнэ. | Зохион байгуулсан сургалтын тоо | тоо | 2023 | 138 | 138 | 291 | 100 | | | | Олон нийтийн татварын боловсролыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу татвар төлөгчийн зан хандлага, хэрэгцээ шаардлагад нийцүүлсэн 42 төрлийн 291 удаагийн сургалтыг бичил, жижиг сегментийн татвар төлөгчдөд ажлын байр болон танхим, цахим хэлбэрээр зохион байгуулав. |
| | | | Сургалтад хамрагдсан татвар төлөгчийн тоо | тоо | 2023 | 8442 | 8864 | 6773 | 76.4 | | | | Татварын баазад 2833 хуулийн этгээд, 47938 иргэн бүртгэлтэйгээс 13762 татвар төлөгч 1-р түвшин, 11328 татвар төлөгч 2-р түвшин, 31457 татвар төлөгч 3-р түвшин, 1786 татвар төлөгч 4-р түвшинд тус тус хамрагдаж байна. Тайлант хугацаанд 3, 4-р түвшний татвар төлөгчдөд зориулсан ажлын байранд болон танхим, цахим хэлбэрээр зохион байгуулсан сургалтад давхардсан тоогоор 6773 татвар төлөгчийг хамруулснаар татварын нэр төрлөөр татварт хамрагдалт өмнөх оны мөн үеэс 8 хувиар өссөн үзүүлэлттэй байна. |
| **2.1.2.3** | | Цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. | Цахимаар татвараа төлсөн татвар төлөгч | тоо | 2023 | 13550 | 13820 | 13250 | 95.8 | | | | Татварын байгууллагын үйл ажиллагаа 100 хувь цахимжсан ба эхний 10 сарын байдлаар 13250 татвар төлөгч цахим нэхэмжлэхийг үндэслэн татвараа төлсөн байна. |
| | | | Цахимаар төлсөн татварын хэмжээ | (сая.төг) | 2023 | 51980.4 | 53020 | 55870.3 | 100 | | | | Татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн 13250 татвар төлөгч цахим нэхэмжлэхийг үндэслэн 55,870.3 сая төгрөгийг улс, аймаг, орон нутгийн төсөвт төвлөрүүлээд байна. |
| **2.1.3.1** | | Орон нутгийн өмчит компаниудын засаглал, үйл ажиллагааг сайжруулна. | Компанийн засаглалын дундаж үнэлгээ | хувь | 2023 | 80 | 81 | 85 | 100 | | | | Орон нутгийн өмчит компани, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрууд санхүү, хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны 2025 төлөвлөгөөг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан, төлөөлөн удирдах зөвлөлийг шинэчлэн ажиллаж байна. Орон нутгийн өмчийн газраас "Булган Мээж" ОНӨХХК, “Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй” ОНӨХХК-ийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнд орж мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, санал зөвлөгөө өгч ажиллаж байна. Бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийн дундаж 92.0 хувьтай байна. Орон нутгийн өмчийн газраас "Булган Мээж" ОНӨХХК, “Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй” ОНӨХХК-ийн 2023, 2024 оны санхүү, үйл ажиллагаанд иж бүрэн шалгалт хийж алдаа зөрчлийг арилгах үүрэг даалгавар өгч хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Компанийн засаглалын үндэсний зөвлөл болон МУИС-тай хамтран компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга нарт зориулсан 36 цагийн цахим сургалтыг зохион байгууллаа. Тус сургалтад “Булган Мээж”, “Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй”, “Илчит Хутаг” ОНӨХХК-ийн ТУЗ-ийн 15 гишүүн хамрагдаж, сертификат авсан. "Булган Мээж" ОНӨХХК компанийн засаглалын үнэлгээ хийлгэж байна. 2024 оны компанийн засаглалын үнэлгээ 85 хувьтай байна. |
| **2.1.4.1** | | Жижиг, дунд үйлдвэрийн бүтээгдэхүүн, орон нутгийн худалдаа эрхлэгчдийг төрийн худалдан авалтаар дэмжинэ. | Орон нутгийн төсвийн худалдан авалтын дүн | Тэрбум төгрөг | 2023 | 2.2 | 2.3 | 1.6 | 69.5 | | | | Аймгийн Засаг даргын 2021 оны А/22 дугаар захирамжийн дагуу 2025 оны эхний 10 сарын байдлаар дотоодын худалдан авалтын мэдээгээр 1614.8 сая төгрөгийн худалдан авалт хийгдсэн байна. Бичиг хэрэг 149.1 сая төгрөг, хүнс 585.3 сая.төгрөг, техник тоног төхөөрөмж 101.5 сая төгрөг, эм эмнэлгийн хэрэгсэл 118.2 сая төгрөг, цэвэрлэгээ ариутгал халдваргүйтэлд 36.6 сая төгрөг, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэл 9.5 сая.төгрөг, автомашины сэлбэг хэрэгсэл 48.2 сая төгрөг, барилгын материал 220.0 сая төгрөг, шатах тослох материал 281.0 сая төгрөг, бэлэг дурсгал 19.3 сая төгрөг, бусад зардал 46.1 сая төгрөгийн дотоодын худалдан авалт хийгдсэн байна. |
| **2.1.4.2** | | Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд санхүүжилтийн олон эх үүсвэрээс дэмжлэг үзүүлнэ. | ЖДҮДС-д хамрагдсан төсөл | тоо | 2024 | 10 | 12 | 13 | 100 | 300 | 290 | 100 | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2025 оны А/240 дүгээр тушаалаар "Хангал суманд цэвэр үүлдрийн махны чиглэлийн үхэр үржүүлэх"-д дэмжлэг үзүүлэх 300.0 сая төгрөгийн эх үүсвэр бүхий хөнгөлөлттэй зээлийг "Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх хяналт тавих журам"-ын дагуу зохион байгуулж, 3 хоршоо 290.0 сая төгрөгийн зээлд хамрагдах боломжтой болсон. Орон нутгийн төсвөөс Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих санд хөрөнгө тусгагдаагүйгээс шалтгаалж, улсын төсвөөс бага хөрөнгө тусгагдсан болно. |
| | | | Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээлийн хэмжээ | сая.төг | 2024 | 705.0 | 800.0 | 1323.0 | 100 | 1323.0 | 1323.0 | 100 | "Хоршоо хөгжүүлэх сан"-аас Баян-Агт, Баяннуур, Булган, Бугат, Бүрэгхангай, Дашинчилэн, Сэлэнгэ, Могод, Тэшиг, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр сумын 26 хоршоог 1323.0 сая төгрөгийн зээлд хамруулж, шинээр 44 ажлын байр бий болгож, 68 ажлын байр хадгалагдах нөхцөлийг бүрдүүлэв. |
| **Уул уурхай** | | | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **2.2** | **ТЕЗ** | Хариуцлагатай уул уурхайг бий болгоно. | Техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийсэн аж ахуйн нэгж | тоо | 2024 | 5 | 6 | 8 | 100 | - | - | - | Аймгийн Засаг даргын 2024 оны А/654 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн Бүрэгхангай сумын Дэрст багийн нутаг дэвсгэрт уул уурхайн төсөл хэрэгжүүлэгч 8 аж ахуйн нэгжийн 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу 39 га техникийн нөхөн сэргээлт, 25 га биологийн нөхөн сэргээлт төлөвлөснөөс 42 га талбайд техникийн нөхөн сэргээлт, 51 га талбайд биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хүлээн авсан. |
| **2.2.1** | **Хөтөлбөрийн** | Уул уурхайн салбарын үйл ажиллагаанаас үүдсэн хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулна. | Уул уурхайн олборлолтын улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлт | га | 2024 | 55 | 60 | 70 | 100 | - | - | - | Бүрэгхангай сумын Дэрст багийн нутаг дэвсгэрт уул уурхайн төсөл хэрэгжүүлэгч "Мөнх нархан орд" ХХК, "Хос хас" ХХК, "Шижир алт" ХХК-ийн алтны үйлдвэр дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд тус багийн нутаг дэвсгэрт уул уурхайн улмаас эвдэрч эзэнгүй орхигдсон 15 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж, уул уурхайн олборлолтын улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлт 70 га талбайд хүрэв. Мөн уул уурхайн төсөл хэрэгжүүлэгч 7 аж ахуйн нэгж "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 177700 ширхэг мод бут тарьсан ажлыг хүлээн авсан. |
| **2.2.1.1** | **Үйл ажиллагаа** | Ашигт малтмалын олборлох, боловсруулах үйлдвэрлэлд байгаль орчинд ээлтэй дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэхийг дэмжинэ. | Шинээр нэвтэрсэн техник, технологийн тоо | тоо | 2024 | - | - | - | ХБ | - | - | - | Бүрэгхангай сумын Дэрст багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа “Платинум ланд” ХХК нь уул уурхайн төслийн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлын асуудлыг шийдвэрлэх зорилгоор HLPG загварын өндөр хэмд агаарт хорт утаа ялгаруулдаггүй, байгальд ээлтэй хог хаягдал шатаах зуухыг ашиглаж байна. |
| **2.2.1.2** | | Уул уурхайн үйлдвэрлэл болон авто замын бүтээн байгуулалтын нөлөөгөөр эвдэрч эзэнгүй орхигдсон газрын судалгаа хийж, нөхөн сэргээнэ. | Нөхөн сэргээсэн талбайн хэмжээ | га | 2024 | 20 | 40 | 35 | 75 | 50 | 47.5 | 95 | Эвдэрч, эзэнгүй орхигдсон газрын судалгааг байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулах эрх бүхий “Эх Монголын байгаль” ХХК-тай гэрээ байгуулан 50.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэлээ. Судалгааны үр дүнд 15 сумын нийт 176 нэгж талбар, 2554 га талбай эвдрэлд орсон бөгөөд сумын Засаг дарга нарт танилцуулж, санал авч, аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсгээр хэлэлцүүлэн хүлээн авсан. Мөн Бүрэгхангай сумын Дэрст багийн нутаг дэвсгэрт уул уурхайн төсөл хэрэгжүүлэгч 3 аж ахуйн нэгж дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд тус багийн нутаг дэвсгэрт уул уурхайн улмаас эвдэрч эзэнгүй орхигдсон 15 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэж хүлээлгэн өгсөн. |
| **2.2.1.3** | | Уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжүүдтэй нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж, байгаль орчин, эдийн засаг, нийгэм, дэд бүтцийн салбарт тулгамдаж буй асуудлуудад хөрөнгө оруулалт хийнэ. | Нийгмийн хариуцлагын гэрээ байгуулсан аж ахуйн нэгжийн тоо | тоо | 2024 | 5 | 6 | 7 | 100 | - | - | - | Ашигт малтмалын тухай хуульд заасны дагуу Бүрэгхангай суманд уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг 7 аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулж, 206.5 сая төгрөгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын нэмэлт дансанд байршуулж, Засаг даргын нэрэмжит оюутны сургалтын төлбөрт зарцууллаа. |
| **2.2.1.4** | | Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц /хайрга, дайрга, элс, хүрмэн чулуу/-ийг ашиглан барилгын материалын үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ. | Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж | тоо | 2024 | 7 | 8 | 8 | 100 | - | - | - | Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох нөхцөл хангасан байгууллагуудын хүсэлтийг хүлээн авч Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын бүртгэлийн системд бүртгэн, дүгнэлт гарсан байгууллагуудад аймгийн Засаг даргын захирамжаар зөвшөөрөл олгон, хууль журмын хүрээнд үйл ажиллагаа явуулахыг зөвлөн ажиллаж байна. Одоогийн байдлаар 8 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. |
| | | | Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж | тоо | 2024 | 1 | 2 | 2 | 100 | - | - | - | Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг Орхон сумын нутагт 72.23 га талбайд 43382.3 мян.тн барилгын материал (базальт)-ын нөөц тогтоосон "Хөх хайрга" ХХК-нд аймгийн Засаг даргын захирамжаар олголоо. Тус тусгай зөвшөөрлийг олгосноор аймгийн хэмжээнд 2 аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд улс, орон нутгийн бүтээн байгуулалтын ажилд хайрга, дайрга нийлүүлж байна. |
| **Авто зам** | | | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **2.3** | **ТЕЗ** | Аймгийн авто зам, замын байгууламжийг нэмэгдүүлнэ. | Байнгын ашиглалтад орсон авто зам | км | 2024 | 507.2 | 548.38 | 538.3 | 75.5 | | | | 2025 онд босоо тэнхлэгийн 39.68 км авто зам ашиглалтад орох байснаас "Идэр ширэгү" ХХК гүйцэтгэж буй 8.6 км, Рэс ХХК гүйцэтгэж буй 20 км хатуу хучилттай авто замыг байнгын ашиглалтад өгөхөөр улсын комисс ажиллуулах хүсэлт Зам тээврийн яам руу өгсөн байна. Гурванбулаг сумын төвд 1.5 км авто замын ажлыг 2025 онд гүйцэтгэсэн. Мөн орон нутгийн төсөвт Бугат, Бүрэгхангай, Рашаант суманд тус бүр 500.0 сая төгрөг тусгагдаж, Бугат 0.44 км, Бүрэгхангай сумын 0.56 км төвийн авто замыг байнгын ашиглалтад авсан. |
| **2.3.1** | **Хөтөлбөрийн** | Аймгийн авто зам, замын байгууламжийг өргөтгөж, шинэчилнэ. | Авто замын хэмжээ | км | 2024 | 507.2 | 548.38 | 538.3 | 75.5 | | | | 2025 онд босоо тэнхлэгийн авто замын ажлын хүрээнд "Идэр ширэгү" ХХК гүйцэтгэж буй 8.6 км, Рэс ХХК гүйцэтгэж буй 20 км хатуу хучилттай авто замыг байнгын ашиглалтад өгөхөөр бэлтгэл хангаж байна. Сайхан, Сэлэнгэ сумын авто замууд 2025 онд төлөвлөсөн ажлаа хийж гүйцэтгэсэн бөгөөд гэрээний хугацаа 2026 онд дууснa. Гурванбулаг сумын төвд 1.5 км авто замын ажлыг гүйцэтгэж, байнгын ашиглалтад өгөхөөр улсын комисс ажиллуулж байна. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 3 суманд тус бүр 500.0 сая төгрөг тусгаж авто замын ажлыг хийж гүйцэтгэсэн. Авто замын сангийн хөрөнгөөр Булган суманд 2000 м.кв авто зогсоол барьж ашиглалтад оруулсан. |
| **2.3.1.1** | **Үйл ажиллагаа** | Босоо тэнхлэгийн Булган-Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг чиглэлийн 133.7 км авто замыг үргэлжлүүлэн ашиглалтад оруулна. | Авто замын барилгын ажлын гүйцэтгэл | хувь | 2024 | 26 | 55.67 | 47.4 | 72.1 | 29,927.0 | 18,705.6 | 62.5 | Хишиг-Өндөр - Гурванбулаг чиглэлийн 59.2 км замыг барих ажилд 2025 оны улсын төсөвт 20.9 тэрбум төгрөг тусгагдаж, хоёр багц болгон тендер зарласан байна. Тендерийн дүнд “Идэр ширэгү” ХХК, “Рэс” ХХК нар шалгарч далангийн ажлыг эхлүүлсэн. Гурванбулаг - Хишиг-Өндөр чиглэлийн 8.6 км замыг ашиглалтад оруулах ажлын гүйцэтгэгчээр “Идэр ширэгү” ХХК ажиллаж байгаа бөгөөд энэ жил ашиглалтад оруулахаар бэлтгэл ажлыг хангаж байна. Хишиг-Өндөр-Орхон чиглэлийн 31.08 км авто замыг гүйцэтгэж буй Рэс ХХК үлдэгдэл санхүүжилт 2026 онд улсын төсөвт тусгагдсан тул ирэх жил ашиглалтад орно. |
| **2.3.1.2** | | Босоо тэнхлэгийн Бага-Илэнх боомт-Тэшиг-Хутаг-Өндөр чиглэлийн 137 км авто замын ажлыг эхлүүлнэ. | Авто замын барилгын ажлын гүйцэтгэл | хувь | 2024 | - | - | - | ХБ | - | - | - | Зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах нээлттэй тендер зарлаж, гүйцэтгэгч шалгарсан боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд хөрөнгө оруулалтыг царцаасан. Тухайн хөрөнгө оруулалтыг Засгийн газрын 2025 оны 204 дүгээр тогтоолын 1.2.3-т заасны дагуу 2026 оны улсын төсөвт Эдийн засаг, хөгжлийн сайдын багцад тусгуулаад байна. |
| **2.3.1.3** | | Булган сумын хатуу хучилттай авто замын сүлжээг өргөтгөж, авто зогсоолын хүртээмжийг нэмэгдүүлнэ. | Байнгын ашиглалтад орсон авто замын хүчин чадал | км | 2024 | 14.2 | - | - | ХБ | - | - | - | 2026 оноос Булган суманд авто зам хийгдэхээр төлөвлөлтөд тусгагдсан. |
| | | | Нэмэгдсэн авто зогсоолын хэмжээ | м.кв | 2024 | 27064 | 29064 | 29064 | 100 | 284.6 | 249 | 87.5 | Булган сумын нийтийн эзэмшлийн талбайд 2000 м.кв зогсоол шинээр барих ажлыг 3 багц болгон тендер зарлаж, 1, 3 дугаар багцад "Өвөлжөөн булаг" ХХК шалгарч 202.8 сая төгрөг, 2 дугаар багцад “Арвин ган бумба” ХХК шалгаран 59.3 сая төгрөгөөр гэрээ байгуулан гүйцэтгэв. Тус ажлуудыг Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын дагуу 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 11/2025, 12/2025, 13/2025 дугаар дүгнэлтээр байнгын ашиглалтад орууллаа. |
| **2.3.1.4** | | Сумын төвүүдийг аймгийн төвтэй хатуу хучилттай авто замаар холбох зураг төсвийг хийлгэж замын ажлыг эхлүүлнэ. | Замын ажлын зураг төсөв ТЭЗҮ боловсруулсан тоо | тоо | 2024 | - | 1 | - | ХБ | 80.7 | 80.0 | 99.1 | Гурванбулаг сумын төв - босоо тэнхлэгийн үлдэгдэл авто замын ажлын зураг төсөв боловсруулж дууссан. |
| **2.3.1.5** | | Сумын төвүүдийг хатуу хучилттай авто замтай болгох ажлыг үргэлжлүүлнэ. | Ашиглалтад оруулсан авто замын хүчин чадал | км | 2024 | 18.9 | 20.4 | 20.34 | 96.0 | 4405.1 | 4405.1 | 100 | 2025 онд Бугат, Бүрэгхангай, Рашаант сумын төвийн авто замын ажилд тус бүр 500.0 сая төгрөг тусгагдсан. Бугат сумын 0.44 км, Бүрэгхангай сумын 0.56 км авто замын гүйцэтгэлд улсын комисс ажиллаж байнгын ашиглалтад оруулсан. 2024 онд гэрээ байгуулсан Тэшиг сумын цемент бетон хучилттай 0.44 км авто зам 2025 онд ашиглалтад орлоо. |
| **2.3.1.6** | | Авто зам засварын шинэ технологи судалж, нэвтрүүлнэ. | Нэвтрүүлсэн технологийн тоо | тоо | 2024 | - | - | - | ХБ | - | - | - | Төлөвлөлтөд 2027 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан. |
| **Хөдөө аж ахуй** | | | | | | | | | | | | | |
| **2.4** | **ТЕЗ** | Хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ. | ДНБ-д хөдөө аж ахуйн салбарын эзлэх хэмжээ | Хувь | 2023 | 60.3 | 62.3 | 52.1 | 0 | 55 | 55 | 100 | Хөдөө аж ахуйн салбарын ДНБ-д эзлэх хэмжээ 52.1 хувьтай байна. Энэ нь 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын хүндэрлийн улмаас малын тоо толгой 584.2 мянган толгойгоор буурсантай холбоотой байна. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **2.4.1** | **Хөтөлбөрийн** | Мал аж ахуйн салбарын тогтвортой үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ. | ДНБ-д мал аж ахуйн салбарын эзлэх хэмжээ | Хувь | 2023 | 53.3 | 55.5 | 45.2 | 0 | | | | Мал аж ахуйн салбарын ДНБ-д эзлэх хэмжээ 45.2 хувьтай байна. Энэ нь 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын хүндэрлийн улмаас малын тоо толгой 584.2 мянган толгойгоор буурсантай холбоотой байна. |
| **2.4.2** | | Малын өвчлөлөөс урьдчилан сэргийлнэ. | Өвчлөлийн бууралт | Хувь | 2024 | 0.8 | 0.7 | 0.7 | 100 | 1,200.0 | 1,200.0 | 100 | Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 1.4 сая мал, амьтан хамруулахаас 938.5 мянган толгой мал амьтан хамруулж, 3 дугаар улирлын байдлаар 67 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ онд 23 голомтод 5 төрлийн халдварт өвчнөөр 77 мал өвчилж, 67 мал хорогдсон. Үүнд: Дуут хавдар өвчин Тэшиг сумандад, листериоз өвчин Баян-Агт, Булган сумандад, галзуу өвчин Баян-Агт, Сайхан суманд, цусан халдвар өвчин Бүрэгхангай, Гурванбулаг, Могод, Орхон, Сэлэнгэ, Тэшиг, Хангал суманд, дотрын халдварт хордлого өвчин Бугат, Бүрэгхангай, Могод, Орхон, Тэшиг, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр суманд тус тус оношлогдсон. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад өвчлөл 0.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна. |
| **2.4.3** | | Газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, хөдөө аж ахуйн зохистой дадлыг нэвтрүүлнэ. | ДНБ-д газар тариалангийн салбарын эзлэх хэмжээ | Хувь | 2023 | 6.8 | 7.5 | 6.7 | 0 | | | | Газар тариалангийн салбарын ДНБ-д эзлэх хэмжээ 6.7 хувьтай байна. Газар тариалангийн салбарын хувьд үр тариа, төмс, хүнсний ногоо, малын тэжээлийн үйлдвэрлэлийн хэмжээгээр дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг тооцдог. Энэ оны тариалалтын хэмжээ өмнөх оноос 18.4 мянган га талбайгаар буурснаас дотоодын нийт бүтээгдэхүүнд газар тариалангийн салбарын эзлэх хувь хэмжээ буурсан үзүүлэлттэй байна. |
| **2.4.1.1** | | Өндөр ашиг шимтэй малын нийт сүрэгт эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлнэ. | Нийт мал сүрэгт өндөр ашигт малын эзлэх хэмжээ | Хувь | 2024 | 25.4 | 26.5 | 26.5 | 100 | - | - | - | Аймгийн хэмжээнд махны чиглэлийн "Хар ангус", "Герефорд", "Сэлэнгэ", сүүний чиглэлийн "Монбилярд", мах-сүүний чиглэлийн "Алатау" зэрэг цэвэр үүлдрийн 250 гаруй хээлтүүлэгчийг ангилж, бүртгэлжүүлэх ажлыг хийлээ. Энэхүү ангилалт нь 2025 оны төлөвлөгөөт ажлын хүрээнд бүрэн гүйцэтгэгдэж, малын чанар, үржлийн удирдлага, үүлдрийн тогтвортой байдлыг сайжруулах үндэс суурийг бүрдүүлээд байна. Эдгээр ажлуудын үр дүнд өндөр ашиг шимтэй малын нийт сүрэгт эзлэх хэмжээ 26.5 хувьд хүрсэн үзүүлэлттэй байна. |
| **2.4.1.2** | | Бэлчээрийг нөхөн сэргээх, сэлгэх, тарималжуулах, хамгаалах, усжуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ. | Нөхөн сэргээсэн талбайн эзлэх хэмжээ | мян.га | 2024 | - | 12.0 | 3 | 25 | | | | Гурванбулаг сумын "Бэлчээрийг нөхөн сэргээх туршилт судалгааны суурин төв"-ийг түшиглэн "Хэт талхлагдсан бэлчээрийг нөхөн сэргээж бэлчээрийн ургацыг нэмэгдүүлэх арга, аргачлалыг малчдад таниулах" сургалтыг зохион байгуулж, туршилтаар 3 га талбайд нөхөн сэргээлт хийгээд байна. |
| | | | Усжуулсан талбайн эзлэх хэмжээ | мян.га | 2024 | 14.0 | 16.0 | 70 | 100 | 700 | 669 | 100 | Аймгийн хэмжээнд ашиглахад бэлэн инженерийн хийцтэй болон энгийн уурхайн худаг, усан сан бүхий 1228 уст цэг байна. Улсын төсвийн 99 сая төгрөгийн хөрөнгөөр Дашинчилэн, Рашаант, Могод суманд 3 худаг, сум орон нутгийн төсвийн 300 сая төгрөгийн хөрөнгөөр 18 худаг, малчдын санаачилгаар 9, нийт 30 худаг гаргасан байна. Үүний үр дүнд 175.0 мянган толгой мал усаар хангагдаж, 70.0 мянган га бэлчээрийг усжуулж, 250 орчим хүн усаар хангагдах боломж бүрдсэн байна. Мөн орон нутгийн төсвийн 270 сая төгрөгийн хөрөнгөөр 10 сумын 10 байршилд худаг гаргахаар "Баясах ус эрдэнэ" ХХК-тай гэрээ байгуулж, гүйцэтгэлийг 2026 онд хүлээн авахаар тусгасан. |
| **2.4.1.3** | | Бүс нутгийн уур амьсгал, газар нутгийн онцлогт нийцсэн мал аж ахуйн бодлогыг хэрэгжүүлнэ. | Боловсруулсан бодлогын хэрэгжилт | хувь | 2024 | - | - | - | ХБ | - | - | | 2026 оноос хэрэгжүүлэхээр төлөвлөлтөд тусгагдсан. |
| **2.4.1.4** | | Хөдөө аж ахуйн салбарын хүний нөөцийг бэлтгэх, залуу малчдыг чадавхжуулахад олон улсын туршлагыг нэвтрүүлнэ. | Хамрагдсан албан хаагч, малчид, тариаланч | тоо | 2024 | 1785 | 2385 | 2798 | 100 | 15 | 11.5 | 76.6 | Бугат, Могод, Хангал, Орхон, Рашаант, Хишиг-Өндөр, Бүрэгхангай сумын малчдын зөвлөгөөн зохион байгуулагдаж, нийт 1013 малчин, мэргэжилтнүүдэд хөдөө аж ахуйн салбарын бодлого чиглэл, цаашдын авч хэрэгжүүлэх арга хэмжээг танилцуулж, мэдээллээр хангасан. |
| **2.4.1.5** | | Мал аж ахуйн салбарт биотехнологи, ухаалаг технологи нэвтрүүлсэн төслүүдийг дэмжинэ. | Хамрагдсан төсөл | тоо | 2024 | 1 | 1 | 1 | 100 | - | - | - | Канадын Засгийн газрын санхүүжилт, буцалтгүй тусламжаар ЭККО ФАРМ төсөл нь Хутаг-Өндөр сумын Тээл багийн 180 орчим малчид, фермер эрхлэгчдэд хэрэгжиж байна. Төсөл энэ оны байдлаар 25 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байгаа бөгөөд орон нутгийн хөдөө аж ахуйн хүнсний тогтолцоог сайжруулах, малчдын орлого, эмэгтэйчүүд, залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхыг дээшлүүлэхэд чухал хувь нэмэр оруулж байна. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **2.4.1.6** | | Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадвартай мал аж ахуйн салбарыг хөгжүүлнэ. | Батлагдсан хөтөлбөрийн хэрэгжилт | хувь | 2024 | - | 30 | 0 | 0 | - | - | - | Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадвартай мал аж ахуйн салбарыг хөгжүүлэх хүрээнд 2026 онд бэлчээрийн менежментийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. |
| **2.4.1.7** | | Хөдөө аж ахуйн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө-Сэргэлт” хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ. | "Шинэ хөдөө-Сэргэлт" хөтөлбөрийн хэрэгжилт | хувь | 2024 | - | 15 | 17.8 | 100 | 65 | 65 | 100 | "Шинэ хөдөө-Сэргэлт" хөтөлбөрийг боловсруулж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн IX/63 дугаар тогтоолоор 6 зорилт, 36 арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлуулсан. Хөтөлбөрийн хэрэгжилт 3 дугаар улирлын байдлаар 17.8 хувьтай байна. Хөтөлбөрийн хүрээнд мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг аймгийн дүнгээр 86.6 хувь, сумдын дүнгээр 80.3-96.8 хувиар тус тус хангасан. Түүнчлэн Хишиг-Өндөр суманд Хөдөлмөрийн баатар, алдарт хоньчин З.Очирын мэндэлсний 120 жилийн ойд зориулсан улс, аймгийн аварга малчдын зөвлөгөөн, аймгийн Зөгийчдийн анхдугаар зөвлөгөөн гэх мэт нийт 4 удаагийн сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулж, 1150 малчин, тариаланч, зөгийчдийг хамруулж, салбарын бодлого чиглэлийн мэдээллээр хангалаа. Мал аж ахуйн салбарын үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх, төрөлжүүлэн хөгжүүлэх зорилгоор улсын хэмжээнд жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "Шилмэл мал-2025" гойд ашиг шимт малыг үзэсгэлэн, дуудлага худалдаанд Сэлэнгэ сумын малчин Э.Оюунхишигийн Сэлэнгэ үүлдрийн бух 1-р байр, тус сумын малчин Г.Нэргүйн Сэлэнгэ үүлдрийн үнээ 1-р байр, малчин Э.Мягмар-Очирын Сэлэнгэ үүлдрийн үнээ 3-р байранд орж амжилттай оролцсон. Мөн аймгийн "Миний Булганы алтан намар" үзэсгэлэн худалдааны үеэр "Гойд ашиг шимт мал шалгаруулах" үзэсгэлэнд 6 сумын 6 үүлдрийн 40 толгой малыг хамруулж, зохион байгууллаа. |
| **2.4.1.8** | | Малын үүлдэр угсааг сайжруулах зорилгоор үржлийн нэгжүүдийг Бүрэгхангай, Дашинчилэн, Сэлэнгэ, Хутаг-Өндөр, Хишиг-Өндөр суманд байгуулна. | Үржлийн аж ахуй байгуулсан сум | тоо | 2024 | - | 1 | 0 | 0 | - | - | - | Аймгийн хэмжээнд Бүрэгхангай, Дашинчилэн, Сэлэнгэ, Хутаг-Өндөр, Хишиг-Өндөр, Бугат, Орхон суманд 10 мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний нэгж бүртгэлтэй байдаг. Үүнээс Бүрэгхангай суманд 2, Дашинчилэн суманд 1, Сэлэнгэ суманд 2, Орхон суманд 1, нийт 6 аж ахуйн нэгж үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна. Хөрөнгө санхүүгийн дэмжлэг байхгүйн улмаас үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах боломжгүй байна. |
| **2.4.2.1** | | Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлнэ. | Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулсан мал, амьтан | тоо | 2024 | 800000 | 800000 | 938500 | 100 | 1,200.0 | 1,200.0 | 100 | Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 1.4 сая мал, амьтан хамруулахаас 938.5 мянган толгой мал амьтан хамруулж, 3 дугаар улирлын байдлаар 67 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ онд 23 голомтод 5 төрлийн халдварт өвчнөөр 77 мал өвчилж, 67 мал хорогдсон. Үүнд: Дуут хавдар өвчин Тэшиг суманд, листериоз өвчин Баян-Агт, Булган суманд, галзуу өвчин Баян-Агт, Сайхан суманд, цусан халдвар өвчин Бүрэгхангай, Гурванбулаг, Могод, Орхон, Сэлэнгэ, Тэшиг, Хангал суманд, дотрын халдварт хордлого өвчин Бугат, Бүрэгхангай, Могод, Орхон, Тэшиг, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр суманд тус тус оношлогдсон. |
| | **Үйл ажиллагаа** | | Гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулсан мал, амьтан | тоо | 2024 | 400000 | 500000 | 430000 | 86.0 | - | - | - | Гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 430.0 мянган мал амьтан хамруулаад байна. |
| **2.4.2.2** | | Мал эмнэлгийн салбарын чанар хүртээмж, үр дүнг сайжруулна. | Хөрөнгө оруулалтын хэмжээ | сая.төг | 2024 | - | 168 | 19.5 | 11.6 | 19.5 | 19.5 | 100 | Мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын үйл ажиллагаа, орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор Хутаг-Өндөр сумын Гуртын гүүрэнд явуулын пост нийлүүлсэн. |
| | | | Мэргэжилтэй боловсон хүчин | тоо | 2024 | 55 | 63 | 62 | 87.5 | - | - | - | Тайлант оны байдлаар 56 нэгж үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 45 их эмч 12 бага эмч, 5 техникийн ажилтан нийт 62 малын эмч, мэргэжилтнүүд ажиллаж байна. |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **2.4.2.3** | Мал эмнэлгийн ариун цэврийн стандартын шаардлага хангасан лабораторийг байгуулна. | Шинээр байгуулсан лабораторийн барилга | тоо | 2024 | - | - | - | ХБ | - | - | | “Либерал эмэгтэйчүүдийн оюун сан” ТББ-ын санаачилгаар “Эрүүл амьдрал – Идэвхтэй оролцоо” сэдэвт нийтийн зөвшилцөх сонсголыг мал эмнэлгийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдлын байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, Мал эмнэлгийн лабораторийн албан хаагчдыг эрүүл аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор зохион байгууллаа. Тус сонсголоос гарсан зөвлөмжид "Шинээр мал эмнэлгийн стандартын шаардлага хангасан лаборатори байгуулж, ажилтнуудыг эрүүл ахуй, чанарын шаардлага хангасан шинэ ажлын байранд нэн даруй шилжүүлэн ажиллуулах" талаар тусгаж, холбогдох дээд шатны байгууллагуудад уламжлаад байна. |
| **2.4.3.1** | Тариалангийн тогтвортой хөгжлийг дэмжих “Атар-4” аяныг хэрэгжүүлнэ. | Хөтөлбөрийн хэрэгжилт | хувь | 2024 | - | 20 | 27.6 | 100 | 50 | 1606.2 | 100 | "Атар-4 тариалангийн тогтвортой хөгжил" аяны хүрээнд хөдөө аж ахуйн тогтвортой үйлдвэрлэлийг дэмжих эргэлтийн хөрөнгийн зээлд 8 аж ахуйн нэгж, 10 иргэнд 1,523.0 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын зээлд 5 аж ахуйн нэгжид 1.1 сая төгрөгийн зээлийн гэрээ хийгээд байна. Тэжээлийн таримал ургамлын үрийг 20 хувийн хөнгөлөлттэй нөхцөлөөр олгож, 2 иргэн, 2 аж ахуйн нэгжид 12.1 сая төгрөгийн үр, тариалангийн 38 аж ахуйн нэгжид 46.0 мянган шон олгож, 227.9 мянган га талбайг хашаажуулсан. Мөн атаршсан газрыг эргэлтэд оруулах зорилгоор Баян-Агт, Бугат, Могод, Орхон, Тэшиг сумын нийт 2467.5 га талбайд хөрсний шинжилгээ хийлгэхээр гэрээ байгуулаад байна. "Атар 4" аяны төлөвлөгөөний хэрэгжилт 27.6 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. |
| **2.4.3.2** | Газар тариалангийн нийт 18.0 мянган га атаршсан талбайгаас 2.5 мянган га газрыг эргэлтэд оруулж, үр тариа, тэжээлийн ургамал тариалалтыг нэмэгдүүлнэ. | Нийт эргэлтэд оруулсан талбайн хэмжээ | мян.га | 2024 | 92.4 | 93 | 93.025 | 100 | | | | Баян-Агт, Бугат, Гурванбулаг, Дашинчилэн, Сайхан, Хангал, Хишиг-Өндөр Могод суманд 134 нэгж талбарын 556.4 га талбайг үр тариа, төмс хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалах зориулалтаар, Баян-Агт, Гурванбулаг, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр суманд 17 хоршоонд 68.6 га, нийт 625 га талбайг үр тариа, тэжээлийн ургамал тариалах зорилгоор нэмж олгосон байна. |
| | | Нутагшсан болон шинэ сортын үрийн хэмжээ | тоо | 2024 | 6 | 7 | 8 | 100 | - | - | - | Энэ онд Хөдөө аж ахуйн биржээр арилжаалсан 3 аж ахуйн нэгжийн гарал үүсэлтэй 9 сортын 684 тн үрийн буудайг 10 сумын 30 аж ахуйн нэгж, 1 иргэн төмсний 2 сортын үрийн шинэчлэл хийж, нийт 11 сортын үрийн шинэчлэл хийгдсэн. Тухайлбал "Дархан 193", "Дархан 144" сүпер элит сорт, "Алтайский 70" сорт, "Юнион" сорт, "Гонец" сорт, "Бурятская остистая" сортыг тариалж, 1 га талбайгаас дунджаар 11.4 цн буюу нийт 7797.6 тн ургац хураан авсан. |
| **2.4.3.3** | Хөдөө аж ахуйн тоног төхөөрөмжийн түрээсийн менежментийг боловсронгуй болгож, хувийн хэвшлийн санаачилгыг дэмжинэ. | Ажлын гүйцэтгэлээр | хувь | 2024 | 50 | 60 | 60 | 100 | - | - | - | "Хөдөө аж ахуй хөгжлийн ирээдүй" ОНӨХХК 35 нэр төрлийн техник, тоног төхөөрөмжийг түрээсээр ашиглуулж, ашиглалт 60 хувьтай байна. |
| **2.4.3.4** | Тариалангийн талбайг хөрсний элэгдэл эвдрэлээс хамгаалж, үржил шимийг сайжруулна. | Хашаажуулсан талбайн хэмжээ | мян.га | 2024 | 3.8 | 3.9 | 7.0 | 100 | - | - | - | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/263 дугаар тушаалаар тариалангийн талбайг хамгаалж ойн зурвас байгуулах зориулалтаар балансаас балансад шилжүүлсэн 51000 ширхэг энгийн шон, 550 ширхэг булангийн шон хүлээн авч, 38 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан 45591 ширхэг энгийн шон, 550 ширхэг булан шонг олгосноор 3248 га талбайг хашаажуулсан. |
| | | Ойн зурвас байгуулсан талбайн хэмжээ | км | 2024 | 2.2 | 3 | 36.2 | 100 | - | - | - | Рашаант сумын "Алтан зам Рашаант" ХХК 24 км тариалангийн талбайд ойн зурвас байгуулж, хайлаас 1168 ширхэг, бургас 125 ширхэг, сөөг мод 115 ширхэг, Булган сум 12.2 км хамгаалалтын зурвас байгуулж, 6108 ширхэг мод тарьж, аймгийн хэмжээнд нийт 36.2 км ойн зурвас байгуулсан байна. |
| | | Усжуулсан талбайн хэмжээ | га | 2024 | 900 | 1100 | 0 | 0 | - | - | - | Улсын болон орон нутгийн төсвөөс хөрөнгө шийдвэрлээгүй тул хэрэгжээгүй. |
| | Хүлэмжийн агро парк | Байгуулсан агропарк | тоо | 2024 | - | 1 | 2 | 100 | - | - | - | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар БНСУ-д үйлдвэрлэсэн 6х20 метр хэмжээтэй 120 м.кв талбай бүхий нийт 23 ширхэг иж бүрэн хүлэмжийг нийлүүлж, "Хөдөө аж ахуй- хөгжлийн ирээдүй" ОНӨХХК аж ахуйн нэгж, хоршоо, иргэнд гэрээгээр олгосон. Булган аймаг дахь Политехникийн коллежийн дэргэдэх “Багш суралцагчдын агро нэгдэл” хоршоо 6 ширхэг хүлэмж, Булган сумын “Үржих олонлог” хоршоо 15 ширхэг хүлэмж авч, 2 агропарк байгуулаад байна. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.4.3.5 | | Хүлэмжийн агро парк байгуулж, нөхөрлөл, хоршоодыг дэмжих замаар хүнсний ногооны хангамжийг нэмэгдүүлнэ. | Хүнсний ногооны хангамж | хувь | 2024 | 40.5 | 45.0 | 47.8 | 100 | - | - | - | Энэ онд төмс 373.03 га-д тариалж 2.2 мянган тн, хүнсний ногоо 209.13 га-д тариалж 7.0 мянган тн ургац хураан авсан нь өмнөх онтой харьцуулахад төмс тарьсан талбайн хэмжээ 1.1 хувиар буурч хураан авсан ургац 9.1 хувиар нэмэгдэж, хүнсний ногоо тарьсан талбайн хэмжээ 1.5 хувиар буурч хураан авсан ургац 10.3 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Хамгаалалттай хөрсний буюу хүлэмжийн аж ахуйн үйл ажиллагаагаа 242 иргэн, 1 хоршоо, 8 аж ахуйн нэгж эрхэлж байна. Өвлийн хүлэмжийн тариалалтыг 3400 м.кв-д, өргөст хэмх 400 м.кв, улаан лооль 250 м.кв, чинжүү 500 м.кв, хулуу, тарвас 100 м.кв, навчит ногоо 100 м.кв, бусад амтлагч ногоо 200 м.кв-д тариалж, нийт 71.5 тн ургац хурааснаар хүнсний ногооны дотоодын хэрэгцээг 47.8 хувиар хангаж байна. |
| 2.4.3.6 | | Төмс, хүнсний ногооны агуулах, зоорийг нэмэгдүүлнэ. | Ашиглалтад оруулсан агуулах, зоорь | тоо | 2024 | - | - | - | ХБ | - | - | - | Төлөвлөлтөд 2027 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан. |
| | | | | | | | **Байгаль орчин** | | | | | | |
| 2.5 | **ТЕЗ** | Байгалийн нөөц баялгийг хамгаалж, нөхөн сэргээх, зохистой ашиглаж, байгалийн унаган төрхийг хадгална. | Хамгаалагдсан талбайн хэмжээ | Хувь | 2024 | 38.4 | 39 | 43.2 | 100 | | | | Бүрэгхангай сумын Дархан багийн шар хад, Цахт багийн Баянтөгс, Бумбат, Дэрст багийн Цоохор морьт, Хутаг-Өндөр сумын Тахилт, Их булгийн рашаан зэрэг нийт 225721.9 га талбайг орон нутгийн хамгаалалтад авч аймгийн нийт газар нутгийн 43.2 хувийн улсын болон орон нутгийн хамгаалалтад авсан. |
| | | | Ойжуулалт хийсэн талбайн хэмжээ | га | 2024 | 100 | 200 | 150 | 75 | 20 | 19.7 | 98.5 | Сэлэнгэ, Хангал, Тэшиг, Бугат, Хутаг-Өндөр сумын мод бэлтгэлийн аж ахуйн нэгжүүд өөрийн хөрөнгөөр 2024, 2025 онд гүйцэтгэсэн 110 га талбайн ойжуулалтын ажилд хяналт тавьж арчилгаа, хамгаалалтыг сайжруулах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Бугат, Орхон, Хутаг-Өндөр сумандхийгдсэн ойн зурвас, ойжуулалтын ажлын 40 га талбайд хяналт тавьж, амьдралтын 50-86 хувьтай байгааг тогтоож ажиллалаа. |
| 2.5.1 | | Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг өргөтгөнө. | Улсын болон орон нутгийн тусгай хамгаалтад авсан газар нутгийн эзлэх хувь | хувь | 2024 | 38.4 | 39 | 43.2 | 100 | - | - | - | Бүрэгхангай сумын Дархан багийн шар хад, Цахт багийн Баянтөгс, Бумбат, Дэрст багийн Цоохор морьт, Хутаг-Өндөр сумын Тахилт, Их булгийн рашаан зэрэг нийт 225721.9 га талбайг орон нутгийн хамгаалалтад авч аймгийн нийт газар нутгийн 43.2 хувийн улсын болон орон нутгийн хамгаалалтад авсан. |
| 2.5.2 | **Хөтөлбөрийн** | Усны нөөцийг хамгаална. | Хамгаалагдсан усны сан бүхий газар, усан хангамжийн эх үүсвэр | тоо | 2024 | - | 1654 | 0 | 0 | 0 | | | Аймгийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 77.5 сая төгрөгийн хөрөнгөөр усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, усны эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс тогтоох ажлыг Орхон-Чулуут, Сэлэнгэ, Туул, Хануй, Хөвсгөл нуур-Эгийн голын сав газрын захиргаатай хамтран хэрэгжүүллээ. Энэ ажлын хүрээнд аймгийн нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд хамгаалалтын бүсийн цэг тогтоож, зураглал гарган сонсох ажиллагаа зохион байгуулж, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Барилга, хот байгуулалтын яамны дүгнэлт гаргуулан аймгийн ИТХ-ын хуралдаанаар 2 удаа хэлэлцүүлсэн боловч батлагдаагүй болно. |
| 2.5.3 | | Ойгоор бүрхэгдсэн талбайг нэмэгдүүлнэ. | Ойжуулалт, ойн зурвас хийсэн талбайн хэмжээ | га | 2024 | 100 | 220 | 156 | 70.9 | 67.5 | 65.9 | 97.6 | Улс, орон нутаг, аж ахуйн нэгжийн хөрөнгөөр гүйцэтгэсэн 150 га ойжуулалтын ажилд хяналт тавин мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч сум орон нутгийг мэдээллээр хангаж ажиллалаа. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд элсний нүүдлээс хамгаалах зурвасын ажил байгуулах ажлыг аймгийн байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар тендер зарлаж аймгийн Засаг даргын захирамжийн дагуу "Хөвөнтөн ой" ХХК-тай 65.9 сая төгрөгөөр Орхон, Сэлэнгэ суманд 6 га талбайд хийж гүйцэтгэв. Уг талбайд 4-5 настай хайлаас, монос, шар хуайс, гүйлс, буйлс зэрэг 9000 ширхэг мод тарьсан байна. |
| 2.5.4 | | Орчны бохирдлыг бууруулна. | Стандартын шаардлага хангасан цэвэрлэх байгууламж | тоо | 2024 | 8 | 9 | 9 | 100 | 600 | 591.5 | 100 | Сэлэнгэ сумын төвийн 24 м.куб/хоног цэвэрлэх байгууламж саарал ус шүүрүүлэх талбайн ажлыг байгаль хамгаалах сангийн 591.5 сая төгрөгөөр "Хулдын бүлээн" ХХК гүйцэтгэж, ашиглалтад хүлээлгэн өгсөн. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **2.5.1.1** | | Аймгийн хэмжээнд орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийг нэмэгдүүлнэ. | Тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хэмжээ | хувь | 2024 | 22.8 | 23 | 26.8 | 100 | | | | Бүрэгхангай сумын Дархан багийн шар хад, Цахт багийн Баянтөгс, Бумбат, Дэрст багийн Цоохор морьт, Хутаг-Өндөр сумын Тахилт, Их булгийн рашаан зэрэг нийт 225721.9 га талбайг орон нутгийн хамгаалалтад авч аймгийн нийт газар нутгийн 26.8 хувийг орон нутгийн хамгаалалтад авсан. |
| **2.5.1.2** | | Биологийн төрөл зүйл (амьтан, ургамал)-ийг хамгаалж, өсгөн үржүүлнэ. | Хамгаалсан, өсгөн үржүүлсэн амьтны зүйлийн тоо | тоо | 2024 | 6 | 6 | 9 | 100 | - | - | - | Тусгай хамгаалалттай газар нутагт биотехникийн арга хэмжээ хэрэгжүүлсэн аргаль хонь, молцог хандгай, халиун буга, бор гөрөөс, баданга хүдэр, цагаан зээр зэрэг амьтдыг хамгаалах, өсөн үржих боломжийг бүрдүүлсэн. Мөн Бугат сумын Ханжаргалант багийн Задын шар дэвсэг гэх газарт "Амьтан энэрэхүй" ТББ-тай хамтарч 50 тарвага, 5 зэрлэг гахай, 10 бугын илий, тус сумын Баянтөгөл багийн Өргөө булаг гэх газар 50 тарвага сэргээн нутагшуулсан. |
| | | | Хамгаалсан ургамлын зүйлийн тоо | тоо | 2024 | 2 | 3 | 4 | 100 | - | - | - | Аймгийн хэмжээнд заан хүж, бүрнүс, дүмбэрэй, чихэр өвс, гандигар, эгэл годил зэрэг ургамлыг орон нутгийн хамгаалалтад авсан. Могод сумын "Дулаан хар" уулыг орон нутгийн тусгай хамгаалалтад авсанаар 23 овог, 47 төрөлд хамаарах 62 зүйл ургамал бүртгэгдсэнээс нэн ховор ургамал болох ягаан цээнэ (Paeonia anomala), хөх нэрс (Vaccinium uluginosum) гэсэн 2 зүйл ургамал хамгаалагдаж байна. |
| **2.5.2.1** | | Гадаргын усны нөөцийг хуримтлуулна. | Хөв цөөрмийн тоо | тоо | 2024 | - | 2 | 0 | 0 | | | | Рашаант сумын Савангийн голын хар үзүүрт хөв цөөрөм байгуулах ажлын зардал төсвийн тодотголоор хасагдсан. |
| **2.5.2.2** | | Усны сан (булаг шанд, гол горхи, нуур тойром, рашаан) бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, усан хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс тогтоож, дэглэмийг мөрдүүлнэ. | Усны сан бүхий газар, усан хангамжийн эх үүсвэрийн тоо | тоо | 2024 | - | 1652 | 0 | 0 | 0 | | | Аймгийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 77.5 сая төгрөгийн хөрөнгөөр усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, усны эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс тогтоох ажлыг Орхон-Чулуут, Сэлэнгэ, Туул, Хануй, Хөвсгөл нуур-Эгийн голын сав газрын захиргаатай хамтран хэрэгжүүллээ. Энэ ажлын хүрээнд аймгийн нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд хамгаалалтын бүсийн цэг тогтоож, зураглал гарган сонсох ажиллагаа зохион байгуулж, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Барилга, хот байгуулалтын яамны дүгнэлт гаргуулан аймгийн ИТХ-ын хуралдаанаар 2 удаа хэлэлцүүлсэн болович батлагдаагүй болно. |
| **2.5.2.3** | | Хүн амын баталгаат усан хангамжийг сайжруулна. | Шинээр гаргасан худгийн тоо | тоо | 2024 | 10 | 20 | 0 | 0 | 270 | 0 | 0 | Энэ онд 10 сумын 10 байршилд хүн ам, бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зорилгоор худаг гаргах ажлын гүйцэтгэгчээр "Баясах ус эрдэнэ" ХХК-тай шалгаран, гэрээ байгуулж, гүйцэтгэлийг 2026 онд хүлээн авахаар тусгасан. |
| **2.5.2.4** | | Булган аймгийн усны нөөц, нийгэм эдийн засгийн салбаруудын усны эрэлт, усны балансын үнэлгээ хийнэ. | Усны эрэлт, усны балансын үнэлгээ хийгдсэн сав газрын тоо | тоо | 2024 | - | 2 | 0 | 0 | 0 | | | Усны эрэлт, усны балансын үнэлгээ хийхэд шаардлагатай багаж тоног төхөөрөмж худалдан авах зардлыг 2026 оны төсвийн саналд тусгаад байна. |
| **2.5.2.5** | | Усны менежментийн болон уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох арга хэмжээний төлөвлөлт хийнэ. | Сав газруудын батлагдсан менежментийн төлөвлөгөөний тоо | тоо | 2024 | - | 1 | 0 | 0 | 0 | | | Сэлэнгэ, Хануй голын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө боловсруулах ажлын зардлыг 2026 оны төсвийн саналд тусгаад байна. |
| **2.5.3.1** | | Ойн сангийн даацад тохируулан мод, ойн дагалдах баялгийг ашиглана. | Ахуйн зориулалтаар ашигласан модны хэмжээ | м.куб | 2024 | 58250 | 60000 | 58427 | 97.3 | | | | Аймгийн хэмжээнд 2025 онд хэрэгжүүлсэн байгаль хамгаалах, нөхөн сэргээх ажлын үр дүнд 15160 га талбайд нөхөн сэргээлт, хамгаалалтын үйл ажиллагаа хэрэгжүүллээ. Тухайлбал, 2024 онд хийгдсэн ойжуулалт, нөхөн сэргээлтийн талбайд арчилгаа, хамгаалалтын ажлыг 20 га, мөн насны I, II ангийн ойд арчилгааны огтлолтыг 70 га талбайд зохион байгуулж, нийт 90 га талбайд нөхөн сэргээх ажиллагаа хийв. Үүнээс гадна ойн сангийн 15,070 га талбайг хууль бус ашиглалт, хөнөөлт хүчин зүйлээс хамгаалах арга хэмжээнд хамруулж, тогтмол хяналт, хамгаалалтад авч ажиллалаа. 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн мод бэлтгэлийн ажлын гүйцэтгэлээр 58427 м.куб модыг ахуйн зориулалтаар ашигласан байна. |
| | **Үйл ажиллагаа** | | Ахуйн зориулалтаар ашигласан ойн дагалдах баялгийн хэмжээ | тн | 2024 | 1.5 | 1 | 36.7 | 100 | | | | 2025 оны 11 дүгээр сарын байдлаар үйлдвэрлэлийн зориулалтаар Тэшиг сум 18000 кг, Сэлэнгэ сум 12000 кг, ахуйн зориулалтаар Хутаг-Өндөр сум 3450 кг, Сэлэнгэ 3300 кг самар түүж бэлтгэн 275.7 сая төгрөгийн төсвийн орлого бүрдүүлсэн байна. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **2.5.3.2** | | Доройтсон ойг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг дэвшилтэт технологи ашиглан гүйцэтгэнэ. | Нөхөн сэргээж, хамгаалсан талбайн хэмжээ | га | 2024 | 100 | 220 | 190 | 75 | 1049 | 1026.7 | 97.9 | Аймгийн байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар ой бүхий сумдад ойн хөнөөлт шавжийн судалгааны ажлыг 919000 га талбайд 56.0 сая, тэмцлийн ажлыг 15000 га талбайд 923.0 сая төгрөгөөр чанарын 82-94 хувьтай гүйцэтгэлээ. Мөн ойн таварлаг чанарыг нэмэгдүүлэх ойн хортон шавжаас урьдчилан сэргийлэх зорилгоор насны I, II ангийн ойд арчилгааны огтлолтыг 70 га талбайд 28.0 сая төгрөгөөр ойн ангиудаар хийлгэж хүлээж авсан. Дээрх ажлуудын дүнд ойн сангийн 15070 га талбайг хамгааллаа. Хутаг-Өндөр, Бугат, Орхон суманд 2024 онд хийгдсэн ойжуулалт нөхөн сэргээлтийн арчилгаа хамгаалалтын ажлыг 20 га талбайд "Хөвөнтөн Ой" ХХК-тай гэрээ байгуулан 19.7 сая төгрөгөөр хийж гүйцэтгүүллээ. Арчилгаа, хамгаалалтын ажилд талбайг хашин шинэсний 3-5 настай суулгацаар нөхөн тарилтыг хийж хамгаалсан байна. |
| **2.5.3.3** | | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд жилд 1.5 саяас доошгүй ширхэг мод, бут, сөөг тарьж ургуулна. | Тарьж ургуулсан мод, бут, сөөгний тоо | тоо | 2024 | 466000 | 1966000 | 921105 | 30.3 | | | | Гурванбулаг, Рашаант, Баяннуур, Дашинчилэн суманд 12 га талбайд 1200 ширхэг мод тарьж, “Эко Ази” ТББ 100 га талбайд 10000 ширхэг мод тарьж, сурагчдад байгаль хамгааллын дадлага сургалт явуулсан. Аймгийн хэмжээнд 2025 оны хавар, намрын бүх нийтийн мод тарилтаар 443905 ширхэг мод, бут тарьж, "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлж эхэлснээс хойш тарьсан нийт модны тоо 921105 болсон байна. |
| **2.5.3.4** | | Цөлжилттэй тэмцэх, сэргийлэх, сааруулах зорилгоор элсний нүүдлийг тогтоон барих ойн хамгаалалтын зурвас болон механик хамгаалалт байгуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | Хамгаалалтын зурвас болон механик хамгаалалт байгуулсан талбайн хэмжээ | га | 2024 | 12 | 24 | 18 | 50 | 67.5 | 65.9 | 100 | "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд элсний нүүдлээс хамгаалах зурвасын ажил байгуулах ажлыг аймгийн байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар тендер зарлаж аймгийн Засаг даргын захирамжийн дагуу "Хөвөнтөн ой" ХХК-тай 65.9 сая төгрөгөөр Орхон, Сэлэнгэ суманд 6 га талбайд хийж гүйцэтгэв. Уг талбайд 4-5 настай хайлаас, монос, шар хуайс, гүйлс, буйлс зэрэг 9000 ширхэг мод тарьсан. Дээрх ажлын дүнд элсний нүүдлээс хамгаалсан зурвасын хэмжээ 18 га талбайд хүрсэн байна. |
| **2.5.4.1** | | "Цэвэр орчин-Цэмцгэр Булган" аяныг хэрэгжүүлнэ. | "Цэвэр орчин-цэмцгэр Булган" аяныг хэрэгжүүлсэн сумдын тоо | тоо | 2024 | 16 | 16 | 16 | 100 | - | - | - | Нийтийн эзэмшлийн талбайн эзэнгүй хог хаягдлыг багасгах чиглэлээр “Цэвэр орчин-Цэмцгэр Булган" аяныг аймгийн Засаг даргын 2025 оны А/193 дугаар захирамжийн дагуу 16 сум, 1 тосгон зохион байгуулж, 38531.03 га талбайн 3757.3 тонн, 132 гол горхины ойр орчмын 56.5 тонн хог хаягдлыг цэвэрлэхэд 70.1 сая төгрөгийг зарцуулсан. |
| **2.5.4.2** | | Сумдыг хог ангилан ялгах хогийн саваар үе шаттайгаар хангана. | Ангилан ялгах хогийн савтай болсон өрх | тоо | 2024 | 3860 | 4110 | 3923 | 25.2 | - | - | - | 2025 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Бугат сум 40, Баяннннуур сум 23 ширхэг ангилан ялгах хогийн сав хийлгэснээр аймгийн хэмжээнд өссөн дүнгээр 3923 хогийн сав ашиглагдаж байна. |
| **2.5.4.3** | | Сумдын хог хаягдлын техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг үе шаттайгаар нэмэгдүүлнэ. | Хангагдсан техник хэрэгслийн тоо | тоо | 2024 | 30 | 33 | 33 | 100 | 325 | 315 | 95 | Хог хаягдлын ачилт тээвэрлэлт, дарж булах ажлыг сум бие даан шийдэх боломжийг бий болгохоор сумдыг шаардлагатай тоног төхөөрөмж, техникээр үе шаттай хангах ажлын хүрээнд 2025 онд 3 суманд Байгаль хамгаалах сангийн 315 төгрөгөөр худалдан авч (Рашаант, Хангал, Сайхан) хүлээлгэн өгсөн. |
| **2.5.4.4** | | Хог хаягдлын менежментийг сайжруулж, байгальд сөрөг нөлөөгүй дэвшилтэт технологи ашиглана. | Дэвшилтэт технологи ашиглан боловсруулж, устгаж зайлуулсан хог хаягдлын хэмжээ | тн | 2024 | 3.5 | 5 | 11.3 | 100 | - | - | - | Хуванцар хог хаягдал дахин боловсруулах "TML пластик" ХХК-тай хамран ажиллаж Булган сумын Тохижилт үйлчилгээний анги 2025 онд 9.4 тонн, Хишиг-Өндөр сумын хог хаягдал зохицуулах төв 1.9 тонн дахивар нөөцийг цуглуулж үйлдвэрт нийлүүлснээр аймгийн хэмжээнд 11.3 тн хуванцар хаягдлыг байгальд ээлтэйгээр зайлуулсан байна. |
| **2.5.4.5** | | Айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудыг байгальд ээлтэй, стандартын шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжтай болгоно. | Стандартын шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжтай болсон айл өрх, аж ахуйн нэгжийн тоо | тоо | 2024 | 450 | 510 | 570 | 100 | - | - | - | "Цэвэр орчин-Цэмцгэр Булган" аяныг аймгийн Засаг даргын 2025 оны А/193 дугаар захирамжаар зарлаж, хөтөлбөрт нүхэн жорлонгоос стандартын жорлонтой болох арга хэмжээг тусгаснаар 2025 онд 40 айл өрх, 22 аж ахуйн нэгж хөрс бохирдуулагч нүхэн жорлонг буулгаж, 77 айл өрх 43 аж ахуйн нэгж "Нүхэн жорлон, угаадасны нүх MNS 5924:2015" стандартын шаардлага хангасан эко жорлонтой болсон. 2025 оны байдлаар 16903 жорлон аймгийн хэмжээнд ашиглаж байгаагаас өссөн дүнгээр 570 айл өрх, аж ахуйн буюу 3.3 хувь нь стандартын шаардлага хангасан жорлонтой болсон байна. |
| **ГУРАВ.БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛД БУЛГАНЫ СЭРГЭЛТ** | | | | | | | | | | | | | |
| **Газар зохион байгуулалт** | | | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **3.1** | **ТЕЗ** | Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан эрх зүйн харилцаа үүсгэх төлөвлөлтийн хэрэгжилтийг 27 хувиар нэмэгдүүлнэ. | Газар зохион байгуулалтын төлөвлөгөө | Хувь | 2024 | 45 | 54 | 48.7 | 41.1 | | | | 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу аймгийн хэмжээнд 72 иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 9.52 га газрыг өмчлүүлсэн бол 127 иргэн, хуулийн этгээдэд 154.3 га газрыг өргөдлийн дагуу болон дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулах журмын дагуу эзэмшүүлэв. |
| **3.1.1** | **Хөтөлбөрийн** | Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний дагуу газар олголтыг газрын хэрэгцээт байдлын үнэлгээнд нийцүүлэн олгоно. | Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | Хувь | 2024 | 56 | 62 | 33 | 53.2 | | | | Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системээр дамжуулан Засгийн газрын 2025 оны 119, 120 дугаар тогтоолоор батлагдсан газруудад цахимаар хүсэлтийг авч шинээр 4 иргэнд 0.25 га газрыг эзэмшүүлэн, 72 иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 9.52 га газрыг өмчлүүлж, 127 иргэн, хуулийн этгээдэд 154.3 га газрыг өргөдлийн дагуу болон дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулах журмын дагуу эзэмшүүлэн холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэрийг гаргуулан газрын кадастрын системд баталгаажуулан ажиллаж байна. 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт 33 хувьтай байна. |
| **3.1.1.1** | **Үйл ажиллагаа** | Аймгийн хэмжээнд 8 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулна. /Бугат, Орхон, Тэшиг, Хутаг-Өндөр, Дашинчилэн, Хангал, Хишиг-Өндөр, Сэлэнгэ/ | Шинэчлэн боловсруулсан нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө | тоо | 2024 | 16 | 1 | 0 | 0 | - | - | - | Сэлэнгэ сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө хийх хөрөнгө аймгийн 2025 оны төсөвт тусгагдаагүй тул уг ажил хийгдээгүй. |
| **3.1.1.2** | | Аймгийн хэмжээнд геодезийн цэг тэмдэгтийн тооллого зохион байгуулж бүртгэлжүүлнэ. | Бүртгэлжүүлсэн цэг тэмдэгт | тоо | 2024 | - | - | - | ХБ | - | - | - | Аймгийн ИТХ-ын 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн XI/83 дугаар тогтоолоор баталсан Булган аймгийн 2026 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд 82 сая төгрөг тусгагдсан болно. (Хугацаа болоогүй) |
| **3.1.1.3** | | Аймгийн хэмжээнд хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг бүрдүүлэн, мэдээллийн санг өргөжүүлнэ. | Бүрдүүлсэн өгөгдөл | тоо | 2024 | 21 | 45 | 200 | 100 | - | - | - | Сумдын хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд 2025 онд Могод сум 13, Бугат сум 14, Баяннуур сум 20, Бүрэгхангай сум 16, Баян-Агт сум 20, Гурванбулаг сум 13, Сэлэнгэ сум 14, Дашинчилэн сум 14, Булган сум 64 буюу нийт 200 барилга байгууламжийн мэдээллийг оруулсан байна. |
| **3.1.1.4** | | Газар зохион байгуулалт, хот төлөвлөлт, газрын кадастрын мэдээллийн цахим системээр газар олголтыг ил тод болгоно. | Тухайн жилд цахимаар олгосон нэгж талбар | хувь | 2024 | 52 | 59 | 100 | 100 | - | - | - | Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системээр дамжуулан Засгийн газрын 2025 оны 119 дүгээр тогтоолын дагуу цахимаар хүсэлтийг авч шинээр 4 иргэнд 0.25 га газрыг эзэмшүүлэн холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэрийг гаргуулан газрын кадастрын системд баталгаажууллаа. |
| | | | | | | **Барилга, хот байгуулалт** | | | | | | | |
| **3.2** | **ТЕЗ** | Сумдын шинэчилсэн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | Шинэчилсэн ерөнхий төлөвлөгөө хийсэн байршлын тоо | тоо | 2024 | 15 | 4 | 1 | 25 | 740 | | | Сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэх ажлын хүрээнд Рашаант сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг энэ оны 08 дугаар сард хүлээн авч, цахим системд оруулж, баталгаажуулсан. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны “Булган аймгийн 2025 оны төсөв батлах тогтоолд өөрчлөлт оруулах тухай” X/74 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2025 оны А/563 дугаар захирамжийн хавсралтад Булган сумын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хийх 150.0 сая төгрөг, Булган сумын суурьшлын бүс нэмэгдүүлэх хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хийх 80.0 сая төгрөг тусгагдсан. Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 3 удаа зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулав. Сэлэнгэ сум 100.0 сая, Хангал сумын 160 сая, Могод сум 100.0 сая, Орхон сум 60.0 сая төгрөг, Бүрэгхангай сум 90.0 сая төгрөгөөр тус тус зөвлөх үйлчилгээний тендерийг зарласан. Гүйцэтгэгч шалгараагүй байна. |
| **3.2.1** | **Хөтөлбөрийн** | Сумдын шинэчилсэн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу нийгмийн болон инженерийн дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлнэ. | Төвлөрсөн дэд бүтцэд холбогдсон хуулийн этгээд, өрхийн тоо | Тоо | 2024 | 1736 | 1786 | 2155 | 100 | 5247 | 5247 | 100 | Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу төвлөрсөн дэд бүтцийн системд 5247.0 сая төгрөгөөр 419 иргэн, аж ахуйн нэгжийг холбож, төвлөрсөн дэд бүтцэд холбогдсон иргэн, ахуйн нэгжийн тоо 2155 болсон байна. |
| | | | Нэг хүнд ноогдох ногоон байгууламжийн хэмжээ | м.кв | 2024 | 20.8 | 22 | 23.7 | 100 | - | - | - | Энэ оны байдлаар аймгийн хэмжээнд 178 га талбайд мод, бут тарьж ургууллаа. Ингэснээр нэг хүнд ноогдох ногоон байгууламжийн хэмжээ 23.7 м.кв болсон байна. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **3.2.1.1** | | Сумдын ногоон байгууламж, тохижилтыг нэмэгдүүлнэ. | Тухайн жилд гүйцэтгэсэн тохижилтын талбайн хэмжээ | м.кв | 2024 | 8000 | 10000 | 10000 | 100 | 284 | 284 | 100 | Булган сумын нийтийн эзэмшлийн талбайд 2000 м.кв зогсоол шинээр барих ажлыг 3 багц болгон тендер зарлаж, 1, 3 дугаар багцад "Өвөлжөөн булаг" ХХК шалгарч 202.8 сая төгрөг, 2 дугаар багцад “Арвин ган бумба” ХХК шалгаран 59.3 сая төгрөгөөр гэрээ байгуулан гүйцэтгэв. Тус ажлуудыг Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын дагуу 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 11/2025, 12/2025, 13/2025 дугаар дүгнэлтээр байнгын ашиглалтад оруулаа. Бугат, Хутаг-Өндөр, Баян-Агт суманд улсын төсвийн 750.0 сая төгрөгөөр хүүхдийн тоглоомын талбайг "Өвөлжөөн булаг" ХХК гүйцэтгэн ашиглалтад оруулаа. Мөн Бугат сумын Ханжаргалант багт орон нугийн төсвийн 68.5 сая төгрөгөөр "Түр амрах цэг"-ийн тохижилтыг "Гурван уулын хишиг" ХХК гүйцэтгэн ашиглалтад оруулсан. Булган сумын 4-р багт гэрэлтүүлгийн ажлыг орон нутгийн төсвийн 113.6 сая төгрөгөөр "Сайжрах шилтгээн" ХХК гүйцэтгэн ашиглалтад оруулав. |
| **3.2.1.2** | | Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд аймгийн төв болон сумдад 300 айлын орон сууц ашиглалтад оруулах, инженерийн дэд бүтэц газрын асуудлыг шийдвэрлэнэ. | Ашиглалтад орсон орон сууцны тоо /айл/ | тоо | 2024 | 80 | 75 | 146 | 100 | - | - | - | 2025 оны байдлаар хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар Булган суманд 3 блок 146 айлын орон сууц ашиглалтад орлоо. Булган сумын 2-р баг "Түмэн-Алт" ХХК-ийн 25 айлын орон сууц, Булган сумын 6-р баг "Хишиг дулаан" ХХК-ийн "Сайхан уул-3" 20 айлын орон сууц, Булган сумын 5-р баг иргэн Ш.Баттөрийн 56 айлын орон сууц, Булган сумын 5-р баг "Эрин гүрэн" ХХК-ийн 45 айлын орон сууц тус тус ашиглалтад орсон. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хутаг-Өндөр сумын төрийн албан хаагчдын 8 айлын орон сууцны барилга 11 дүгээр сард ашиглалтад орж, Булган сумын төрийн албан хаагчдын 15 айлын орон сууцны энэ оны төлөвлөгөөт ажлыг 100 хувь гүйцэтгэсэн. Бүрэгхангай суманд 20 айлын орон сууцны ажлыг эхлүүлсэн ба гүйцэтгэл 60 хувьтай, Могод, Сайхан суманд 24 айлын барилга барих архитектор төлөвлөлтийн даалгавар авч, орон сууцны ажлын зургийг боловсруулж байна. Ингэснээр орон сууцны хүртээмж нэмэгдэж, иргэдийн орон сууцтай болох нөхцөл сайжирлаа. |
| **3.2.1.3** | | Түрээслээд өмчлөх "Булган-Орон сууц" хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ. | Хөтөлбөрийн хэрэгжилт | айл | 2024 | 14 | 21 | 22 | 100 | 3048 | 1600 | 52.4 | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар "Булган орон сууц" хөтөлбөрийг батлуулж, 5 зорилтын 18 үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна. 2025 оны байдлаар хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар Булган суманд 3 блок 146 айлын орон сууц ашиглалтад орлоо. Үүнд: Булган сумын 2-р баг "Түмэн-Алт "ХХК-ийн 25 айлын орон сууц, Булган сумын 6-р баг "Хишиг дулаан" ХХК-ийн "Сайхан уул-3" 20 айлын орон сууц, Булган сумын 5-р баг иргэн Ш.Баттөрийн 56 айлын орон сууц, Булган сумын 5-р баг "Эрин гүрэн" ХХК-ийн 45 айлын орон сууц тус тус ашиглалтад орсон. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хутаг-Өндөр сумын төрийн албан хаагчдын 8 айлын орон сууцны барилга 11 дүгээр сард ашиглалтад орж, Булган сумын төрийн албан хаагчдын 15 айлын орон сууцны энэ оны төлөвлөгөөт ажил 100 хувь дууссан. Ингэснээр орон сууцны хүртээмж аймгийн хэмжээнд 15.3 нэмэгдэж, иргэдийн орон сууцтай болох нөхцөл сайжирлаа. |
| **3.2.1.4** | | Үерийн эрсдэлийн мастер төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ. | Сумдын инженерийн бэлтгэл арга хэмжээний дагуу баригдсан үерийн далангийн хэмжээ | урт/км | 2024 | 14.7 | - | - | ХБ | - | - | - | "Дэд бүтцийн сэргэлт" хөтөлбөрийн 4.3.1 дэх заалтад тусгагдсан бөгөөд аймгийн инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөөний төслийг боловсруулж, ХББОСЯ-нд хянуулахаар хүргүүлсэн. |
| | | | Төвлөрсөн дулаан хангамжид холбогдсон төрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэн | тоо | 2024 | 1736 | 1861 | 1840 | 83.2 | 565 | 565 | 100 | Баян-Агт сумын шинэ суурьшлын бүсийн ус дулаан хангамжийн шугам шинээр татах угсралтын ажлыг "Ээлт өлгий" ХХК 240.0 сая төгрөгөөр гүйцэтгэн ашиглалтад оруулж 24 айл холбогдсон. Хөрсний доройтлыг бууруулж, усыг зохистой ашиглах зорилгоор "Дан" байрны дулаан, цэвэр усны шугамын өргөтгөлийн 2-р шатны ажил (Хангал сум, Хялганат тосгон)-ыг "Сувдан элс" ХХК 325.1 сая төгрөгөөр гүйцэтгэн ашиглалтад оруулж 80 айл холбогдож, нийт 104 өрх төвлөрсөн системд холбогдов. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **3.2.1.5** | **Үйл ажиллагаа** | Сумдын ус, дулаан хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламжийн шугам сүлжээнд өргөтгөл хийж, холбогдоогүй сумдад шинээр барих ажлыг шат дараатай нэмэгдүүлнэ. | Төвлөрсөн усан хангамжид холбогдсон төрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэн | тоо | 2024 | 1641 | 1766 | 1795 | 100 | 2177.1 | 2177.1 | 100 | Баяннуур, Хишиг-Өндөр сумын цэвэр усан хангамжийн зураг төслийн ажлыг Эдийн засаг, хөгжлийн яамнаас гүйцэтгүүлэхээр судалгаа боловсруулж байна. Могод сумын цэвэр усан хангамжийн ажлыг орон нутгийн төсвийн 991.0 сая төгрөгөөр "Баатар шүтээн уул" ХХК гүйцэтгэж байна. Бугат сумын цэвэр усан хангамжийн зураг төслийн даалгаврыг боловсруулан тус суманд хүргүүлсэн. Гурванбулаг сумын усан хангамж, ариутгах татуургын барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах ажлыг "Хатанбаатар" ХХК-тай 81.0 сая төгрөгийн гэрээгээр эхлүүлээд байна. Сайхан сумын төвийн цэвэр усан хангамжийн 4 дүгээр ээлжийн ажлыг орон нутгийн төсвийн 540 сая төгрөгөөр гүйцэтгэж 2 байршилд шинээр ус түгээх ухаалаг худаг барьж ашиглалтад оруулсан. Баян-Агт сумын шинэ суурьшлын бүсийн ус хангамжийн шугам шинээр татах угсралтын ажлыг "Ээлт өлгий" ХХК 240.0 сая төгрөгөөр гүйцэтгэн ашиглалтад оруулж 24 айл холбогдсон. Хөрсний доройтлыг бууруулж, усыг зохистой ашиглах зорилгоор "Дан" байрны дулаан, цэвэр усны шугамын өргөтгөлийн 2-р шатны ажил (Хангал сум, Хялганат тосгон)-ыг "Сувдан элс" ХХК 325.1 сая төгрөгөөр гүйцэтгэн ашиглалтад оруулсан. Дээрх ажлуудын дүнд нийт 154 айл төвлөрсөн ус хангамжийн системд шинээр холбогдсон байна. |
| | | | Төвлөрсөн ариутгах татуургын системд холбогдсон төрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэн | тоо | 2024 | 1600 | 1725 | 1603 | 2.4 | 711 | 711 | 100 | Гурванбулаг сумын ахуйн үйлчилгээний гадна бохир усны шугамын угсралтын ажлыг "Баян-Өндөр булаг" ХХК 120.0 сая төгрөгөөр гүйцэтгэн ашиглалтад оруулж 1 аж ахуйн нэгж, Сэлэнгэ сумын төвийн цэвэрлэх байгууламж саарал ус шүүрүүлэх талбайн ажлыг байгаль хамгаалах сангийн 591.5 сая төгрөгөөр "Хулдын бүлээн" ХХК гүйцэтгэж ашиглалтад хүлээлгэн өгч 2 аж ахуйн нэгж холбогдсон. Хангал сумын төвийн цэвэрлэх байгууламж, ариутгах татуургын шугамын ажлын зургийг "Нарлаг хөхий" ХХК 60 сая төгрөгөөр гүйцэтгэж байгаа бөгөөд төсөвт өртөг 1.8 тэрбум төгрөг гарч хөрөнгө оруулалтад тусгуулахаар санал хүргүүлсэн. Орхон сумын цэвэрлэх байгууламжийн зураг төсөл боловсруулах ажил даалгаврын шатандаа явж байна. Могод сумын цэвэрлэх байгууламжийн зураг төсөл хийгдэж хөрөнгө оруулалтыг шийдвэрлэхээр холбогдох газарт санал хүргүүлсэн. Баяннуур сумын цэвэрлэх байгууламжийн зураг төслийг Эдийн засаг, хөгжлийн яамнаас хийлгэхээр судалгааны ажил хийгдэж байна. Гурванбулаг сумын цэвэрлэх байгууламжийн зураг төслийг "Хатанбаатар" ХХК 81.0 сая төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулах шатандаа байна. Бугат сумын цэвэрлэх байгууламжийн зураг төсөл боловсруулах даалгаврыг боловсруулан тус суманд хүргүүлээд байна. |
| **3.2.1.6** | | Үүрэн холбооны сүлжээнд холбогдоогүй 14 багийн төвийг үүрэн холбоо, өндөр хурдны интернэт ашиглах нөхцөлөөр хангана. | Сүлжээнд холбогдсон баг | тоо | 2024 | 61 | 65 | 64 | 75 | | 59.8 | 100 | Үүрэн холбооны сүлжээнд холбогдоогүй Сайхан сумын Мануулт баг, Тэшиг сумын Далан багийн Дулаан хан уул, Хужирт багт Мобиком үүрэн холбооны сүлжээг нэвтрүүлэх ажлыг зохион байгууллаа. Мөн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар "Монголын цахилгаан холбоо" ХК-ийн Булган аймаг дахь холбооны газар Сэлэнгэ суманд 59.8 сая төгрөгийн санхүүжилтээр гурвалсан (телевиз, интернэт, утас) үйлчилгээ, Хишиг-Өндөр суманд "Юнител" ХХК юнивишн үйлчилгээг тус тус нэвтрүүлж ашиглалтад оруулсан. |
| **3.2.1.7** | | Төр, иргэн, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шаардлагатай газруудад дахин төлөвлөлт хийнэ. | Хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ | тоо | 2024 | - | 4 | 4 | 100 | | - | - | Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд Булган сумын 2 дугаар багт "Эрин гүрэн" ХХК 1 блок 9 давхар 45 айлын орон сууц, Булган сумын 2-р баг "Түмэн-Алт" ХХК-ийн 25 айлын орон сууц, Булган сумын 6-р баг "Хишиг дулаан" ХХК-ийн "Сайхан уул-3" 20 айлын орон сууц тус тус ашиглалтад орсон. Бүрэгхангай суманд "Нүнжигт өргөө" ХХК 20 айлын орон сууцны энэ оны ажил 100 хувь дууссан бөгөөд 2026 оны 06 дугаар сард ашиглалтад орно |
| | | | Төвлөрсөн дулаан хангамжид холбогдсон төрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэн | тоо | 2024 | 1172 | 1247 | 1412 | 100 | | | | Булган сумын 6-р багийн 15, 16, 17-р гудамжны дулаан, цэвэр, хэрэглээний халуун усны шугам өргөтгөлийн ажлыг "Хулдын бүлээн" ХХК орон нутгийн төсвийн 797.5 сая төгрөгөөр гүйцэтгэж, шинээр 58 айл холбогдох боломж бүрдсэнээс 20 айл холбогдсон. Мөн 3-р багийн 5 хос шугамын ажил 300.0 сая төгрөгөөр хийгдэж 5 айл, 1 өрхийн эрүүл мэндийн төв холбогдсон. Булган сумын 5 дугаар багийн 3 дугаар ус дулаан дамжуулах төвөөс 7 дугаар цэцэрлэг хүртэлх чиглэлийн гадна дулаан, цэвэр, хэрэгцээний халуун усны шугамын өргөтгөл, шинэчлэлийн ажлыг "Гуа орд" ХХК 750.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэн 226 айл өрх холбогдсон. Нийт 252 айл өрх, аж ахуйн нэгж төвлөрсөн дулааны шугаманд холбогдсон. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **3.2.1.8** | | Аймгийн төвийн цэвэр, дулааны шугамын өргөтгөл, гадна системийн 5 хос шугамын ажлыг үе шаттай хийж гүйцэтгэнэ. | Төвлөрсөн хэрэгцээний халуун усанд холбогдсон төрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэн | тоо | 2024 | 250 | 325 | 490 | 100 | 2000 | 1847 | 100 | Булган сумын 6-р багийн 15, 16, 17-р гудамжны дулаан, цэвэр, хэрэглээний халуун усны шугам өргөтгөлийн ажлыг "Хулдын бүлээн" ХХК орон нутгийн төсвийн 797.5 сая төгрөгөөр гүйцэтгэж, шинээр 58 айл холбогдох боломж бүрдсэнээс 20 айл холбогдсон. Мөн 3-р багийн 5 хос шугамын ажил 300.0 сая төгрөгөөр хийгдэж 5 айл, 1 өрхийн эрүүл мэндийн төв холбогдсон. Булган сумын 5 дугаар багийн 3 дугаар ус дулаан дамжуулах төвөөс 7 дугаар цэцэрлэг хүртэлх чиглэлийн гадна дулаан, цэвэр, хэрэгцээний халуун усны шугамын өргөтгөл, шинэчлэлийн ажлыг "Гуа орд" ХХК 750.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэн 226 айл өрх холбогдсон. Нийт 252 айл өрх, аж ахуйн нэгж төвлөрсөн хэрэгцээний халуун усны шугаманд холбогдсон. |
| | | | Төвлөрсөн усан хангамжид холбогдсон төрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэн | тоо | 2024 | 1172 | 1247 | 1412 | 100 | | | | Булган сумын 6-р багийн 15, 16, 17-р гудамжны дулаан, цэвэр, хэрэглээний халуун усны шугам өргөтгөлийн ажлыг "Хулдын бүлээн" ХХК орон нутгийн төсвийн 797.5 сая төгрөгөөр гүйцэтгэж, шинээр 58 айл холбогдох боломж бүрдсэнээс 20 айл холбогдсон. Мөн 3-р багийн 5 хос шугамын ажил 300.0 сая төгрөгөөр хийгдэж 5 айл, 1 өрхийн эрүүл мэндийн төв холбогдсон. Булган сумын 5 дугаар багийн 3 дугаар ус дулаан дамжуулах төвөөс 7 дугаар цэцэрлэг хүртэлх чиглэлийн гадна дулаан, цэвэр, хэрэгцээний халуун усны шугамын өргөтгөл, шинэчлэлийн ажлыг "Гуа орд" ХХК 750.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэн 226 айл өрх холбогдсон. Нийт 252 айл өрх, аж ахуйн нэгж төвлөрсөн ус хангамжийн системд холбогдсон. |
| | | | Төвлөрсөн ариутгах татуургын системд холбогдсон төрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэн | тоо | 2024 | 1172 | 1247 | 0 | 0 | - | - | - | Булган хотын нийтийн орон сууцны 962 өрх, 42 төрийн байгууллага, 102 аж ахуйн нэгж төвлөрсөн ариутгах татуургын системд холбогдсон бөгөөд хоногт 3000 м.куб ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжаар дамжин цэвэрлэгдэж байна. Аймгийн төвд энэ онд ариутгах татуургын шугамын төсөл хэрэгжээгүй байна. |
| **3.2.1.9** | | “Дэд бүтцийн сэргэлт” хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ. | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | хувь | 2024 | 0 | 90 | 80 | 88.9 | - | - | - | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн IX/67 дугаар тогтоолоор “Дэд бүтцийн сэргэлт” хөтөлбөрийг батлуулсан бөгөөд 6 зорилтын 24 үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 80 хувьтай байна. Тус хөтөлбөрийн хүрээнд эрчим хүчний дэд бүцийн өргөтгөл, шинэчлэл хийх ажлын хүрээнд 15 сум, 1 тосгоны сумын төвийн хуучин ЦДАШ-ын модон тулгуурыг төмөр бетонд шинэчлэх ажлын зураг төсвийг бүрэн хийсэн. Сумын төвийн төвлөрсөн ус хангамж, ариутгах татуургыг төвлөрсөн системд хамруулах хүрээнд Сэлэнгэ, Дашинчилэн, Могод, Хангал сумын ус хангамж, ариутгах татуургын шугамын ажил хийгдэж, 6 сумын зураг төслийн ажил хийгдэж байна. Зам тээврийн хүчин чадлыг нэмэгдүүлэхээр Гурванбулаг, Сайхан, Хишиг-Өндөр, Сэлэнгэ, Бугат, Бүрэгхангай, Тэшиг сумын төвийн автозамын ажил эхэлсэн ба Орхон-Хишиг-өндөр-Гурванбулаг сум чиглэлийн хатуу хучилттай авто замын үргэлжлэл ажил гүйцэтгэгдэж байна. Дэд бүтцийн салбарт 43 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэн 28.0 тэрбум төгрөгийн бүтээн байгуулалтын ажил хийгдсэн байна. |
| | | | | | | **Эрчим хүч** | | | | | | | |
| **3.3** | **ТЕЗ** | Эрчим хүчний найдвартай, аюулгүй, тогтвортой байдлыг дээшлүүлнэ. | Өргөтгөж, засвар шинэчлэл хийсэн шугам сүлжээний урт | км | 2024 | 150 | 100 | 16.2 | 16.2 | 160 | 160 | 100 | "ЭБЦТС" ТӨХК өөрийн хөрөнгөөр энэ онд гүйцэтгэлийн зураг төсвийн дагуу 550 цахилгааны модон тулгуураас 162 ширхэгийг төмөр бетон тулгуураар шинэчилсэн. Үлдсэн тулгуурыг үе шаттайгаар шинэчилнэ. |
| **3.3.1** | **Хөтөлбөрийн** | Эрчим хүчний эх үүсвэр, дэд станц, тоноглол, шугам сүлжээний найдвартай байдлыг хангуулна. | Шинээр болон өргөтгөл, засвар хийх эрчим хүчний тоноглол, шугам сүлжээний эзлэх хувь | Хувь | 2024 | 1.5 | 1 | 1 | 100 | 340 | 340 | 100 | Хутаг-Өндөр сумын Тээл багт Эрчим хүчний яамны хөрөнгө оруулалтаар 10/0.4кВт-н 100кВА-н дэд станц, 10кВт-н төмөр бетон цахилгаан дамжуулах агаарын шугамын ажил хийгдсэн. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **3.3.1.1** | **Үйл ажиллагаа** | Аймгийн төв болон сумдын эрчим хүчний өргөтгөл шинэчлэлийн ажлыг шат дараатай гүйцэтгэнэ. | Эрчим хүчний 10, 35 кВ-ын шугам сүлжээний ажлын зураг боловсруулж батлуулсан тоо | Тоо | 2024 | 0 | 2 | 16 | 100 | - | - | - | Аймгийн 16 сумын төвийн хуучин модон тулгууртай агаарын 0.4 кВ-ын шугамыг төмөр бетон тулгуур бүхий сип кабель шугамд шилжүүлэх ажлын зураг төсөв хийгдсэн. 2026 оны улсын төсөвт тусгуулахаар санал хүргүүлсэн. |
| **3.3.1.2** | | Ногоон эдийн засаг, ногоон амьдралын хэв маягийг дэмжсэн иргэн, хувийн хэвшлийн санаачилгаар хийгдэж буй сэргээгдэх эрчим хүчний төслүүдийг дэмжинэ. | Дэмжлэг үзүүлсэн төслийн тоо | Тоо | 2024 | 0 | - | - | ХБ | - | - | - | 2026 оноос хэрэгжүүлэхээр төлөвлөлтөд тусгагдсан. |
| **3.3.1.3** | | Эгийн голд эрчим хүчний нэгдсэн системийн горим тохируулгын үндсэн эх үүсвэр 310 МВт-ын хүчин чадалтай усан цахилгаан станц барихад орон нутгийн зүгээс шаардлагатай дэмжлэгийг үзүүлнэ. | Орон нутгийн зүгээс дэмжлэг үзүүлсэн ажлын гүйцэтгэлийн хувь | хувь | 2024 | - | 100 | 100 | 100 | - | - | - | Эгийн голын усан цахилгаан станцын төслийн нэгжээс зарласан "Эгийн голын усан цахилгаан станц барихад байгаль орчин нийгмийн нөлөөллийн судалгаа"-ны ажилд "Хатандалай ЕАСС" ХХК шалгарч судалгааны ажлыг 1.8 жилийн хугацаанд гүйцэтгэж байна. Тухайн судалгаа хийж буй аж ахуйн нэгжид орон нутгаас шаардлагатай мэдээ судалгааг цаг тухай бүрт нь гарган өгч хамтран ажиллалаа. Мөн усан сан үүсэх талбайд байрлаж буй одоогийн суурьшлын бүсийг нүүлгэн шилжүүлж, шинэ байршилд суурьшуулах хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө ТЭЗҮ хийлгэх ажлын зардлыг Эдийн засаг, хөгжлийн сайдын 2026 оны багцад тусгуулахаар санал хүргүүлсэн. |
| **Үйлдвэрлэл, үйлчилгээ** | | | | | | | | | | | | | |
| **3.4** | **ТЕЗ** | Нөөцийн давуу талд түшиглэсэн орон нутгийн онцлогтой бизнесийн тэргүүлэх чиглэлийг хөгжүүлж, эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ажлын байрыг нэмэгдүүлнэ. | Боловсруулах аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ | Тэрбум төгрөг | 2023 | 68.7 | 73.7 | 82.4 | 100 | - | - | - | Аймгийн хэмжээнд үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний 1130 гаруй аж ахуйн нэгж, цэг, салбар үйл ажиллагаа явуулж, үйлдвэрлэлийн салбар ДНБ-ий 13.7 хувь буюу 82.4 тэрбум, үйлчилгээний салбар 35 хувийг буюу 210.56 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн тус тус үйлдвэрлэсэн байна.<br>Боловсруулах салбарын үйлдвэрлэл өмнөх оноос 104.3 хувиар өссөн байна. Орон нутгийн нөөцөд түшиглэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж, үйлчилгээг сайжруулах зорилтын хүрээнд улсын төсвийн 764.1 сая төгрөгийн санхүүжилтээр бичил болон жижиг, дунд үйлдвэрлэлийн 283 тоног төхөөрөмж нийлүүлснийг орон нутгийн өмчид бүртгэж, ашиглалтын гэрээ байгуулж, захиалагч иргэдэд олгож, чадавхжуулснаар ажлын байр шинээр бий болох хадгалагдах нөхцөлийг бүрдүүлэв. Булган сум орон нутгийн төсвөөс "Хоршоо хөгжүүлэх сан"-ийн эх үүсвэрийг 500.0 сая төгрөгөөр, Бүрэгхангай сум 7.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, шинээр зээлд хамрагдах нөхцөлийг бүрдүүлэв. |
| **3.4.1** | **Хөтөлбөрийн** | Орон нутгийн хөгжлийн төвүүдэд хүнсний үйлдвэрлэл үйлчилгээ, худалдаа, бирж, тээвэр логистикийн цогцолборыг кластераар хөгжүүлэх хувийн хэвшил, хоршоодыг дэмжинэ. | Кластерт нэгдсэн жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн тоо | Тоо | 2024 | 10 | 20 | 20 | 100 | 500.0 | - | - | Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэнгээс зарласан Булган аймгийн орон нутгийн хөгжлийн төвд хөдөө аж ахуйн нөөцөд тулгуурлан үйлдвэрлэл үйлчилгээ, бирж, тээвэр, логистикийн цогцолбор байгуулах ТЭЗҮ боловсруулах тендерт “Системийн динамик загварчлал” ТББ шалгарч ажлыг гүйцэтгэж байна.<br>Хутаг-Өндөр сумын төвд орон нутгийн хөгжлийн сангийн 8.0 сая төгрөгөөр малчдад зориулсан “Мах борлуулах цэг”, Булган сумын 6-р багт "Өнө мөнх бадрах" хоршоо малчдаас шууд хэрэглэгчдэд мах худалдан борлуулах цэг гаргаж, мал мах бэлтгэлийн кластер үүсгэж, иргэд хямд үнэтэй мах худалдан авах нөхцөл бүрдлээ. Хутаг-Өндөр сумын Мэргэн хөтөлд хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн борлуулах 18 павилоныг “Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй” ОНӨХХК орон нутгийн төсвийн 100.0 сая төгрөгөөр байрлуулж Баян-Агт, Сайхан, Хутаг-Өндөр сумын малчид улирлын чанартай түр ажлын байраар хангагдаж, цагаан идээгээ борлуулан, өрхийн орлогоо нэмэгдүүлэх боломжийг бүрдүүллээ. Дашинчилэн сум хоршоо хөгжүүлэх сангаас "Адуун толгой хошуу" хоршоонд "Стандарт хадгалалт, хөргүүртэй зоорь" төсөлд 50.0 сая төгрөг, мах, махан бүтээгдэхүүн боловсруулах цехийн үйл ажиллагаа эрхэлдэг "Товчлох хурд" ХХК-ийн дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэсэн бол Хутаг-Өндөр сум хоршоо хөгжүүлэх сангаас "Хорголжин тэжээлийн үйлдвэр" өргөтгөх төсөлд 30.0 сая төгрөгийн зээл олгож, арьс шир нэхий боловсруулах цехийг 31.5 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн дэмжлэгт хамруулсан байна. Мөн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багцаас Хутаг-Өндөр өсөлтийн төвд 271.5 сая төгрөгийн 39 нэр төрлийн 102 тоног төхөөрөмжийг бичил болон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд ашиглалтын гэрээгээр хүлээлгэн өгч байна. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **3.4.1.1** | **Үйл ажиллагаа** | “Булган үйлдвэр технологийн парк”-ийн ТЭЗҮ-ийг шинэчлэн, төлөвлөлтийн дагуу үргэлжлүүлнэ. | Ажлын гүйцэтгэлийн хувь | Хувь | 2024 | 5 | 15 | 12 | 70 | - | - | - | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 209 дүгээр "Хойд бүсэд үйлдвэрлэл, технологийн паркийн хөгжлийг дэмжих зарим арга хэмжээний тухай" тогтоолд Хойд бүсийн мал аж ах ахуйн гаралтай бүтээгдэхүүний үйлдвэр технологийн паркийг Булган аймагт байгуулахаар тусгагдав. “Булган үйлдвэр технологийн парк”-ийн ажлын даалгаврыг боловсруулж, ТЭЗҮ, зураг төсөв боловсруулахад шаардагдах санхүүжилтийг улсын төсвийн хөрөнгө оруулалтад тусгах, шийдвэрлүүлэх албан бичгийг ЭЗХЯ-д хүргүүлээд байна. |
| **3.4.1.2** | | Орон нутгийн түүхий эдийн нөөц, газар зүйн онцлогт тулгуурлан мах, дайвар бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, барилгын материал, гурил, тэжээл, бордоо дахин боловсруулах үйлдвэр байгуулахад эдийн засгийн хөшүүрэг, дэд бүтцээр дэмжинэ. | Үйлдвэрийн тоо | Тоо | 2024 | 12 | 13 | 13 | 100 | 771.0 | 771.0 | 100 | Дашинчилэн сум хоршоо хөгжүүлэх сангаас "Адуун толгой хошуу" хоршоонд "Стандарт хадгалалт, хөргүүртэй зоорь" төсөлд 50.0 сая төгрөг, мах, махан бүтээгдэхүүн боловсруулах цехийн үйл ажиллагаа эрхэлдэг "Товчлох хурд" ХХК-ийн дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэсэн бол Хутаг-Өндөр сум хоршоо хөгжүүлэх сангаас "Хорголжин тэжээлийн үйлдвэр" өргөтгөх төсөлд 30.0 сая төгрөгийн зээл олгож, арьс шир нэхий боловсруулах цехийг 31.5 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн дэмжлэгт хамруулсан байна. Мөн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багцаас 764.1 сая төгрөгийн 283 тоног төхөөрөмжийг Баян-Агт, Баяннуур, Булган, Бугат, Бүрэгхангай, Гурванбулаг, Дашинчилэн, Могод, Орхон, Рашаант, Сайхан, Сэлэнгэ, Хангал, Хишиг-Өндөр, Тэшиг сумын орон нутгийн өмчид бүртгэж, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд ашиглалтын гэрээ хийж олгосоноор үйлдвэрлэл эрхлэгчдэд бодит дэмжлэг болж байна. Хутаг-Өндөр суманд 271.0 сая төгрөгийн 39 нэр төрлийн 102 тоног төхөөрөмжийг ашиглалтын гэрээгээр хүлээлгэн өгсөн. Тэшиг суманд 25.0 сая төгрөгийн багсармал тэжээлийн тоног төхөөрөмж нийлүүлэгдэв. Тэшиг сумын сүүний үйлдвэрлэлийн үйл ажиллагаа 2026 оноос эхэлнэ. |
| **3.4.1.3** | | Түүхий эдийн нөөцөд түшиглэсэн боловсруулах үйлдвэр байгуулахад шаардлагатай инженерийн дэд бүтцэд төрөөс дэмжлэг үзүүлж, хөрөнгө оруулагч нарт ээлтэй орчныг бүрдүүлнэ. | Хөрөнгө оруулалтын хэмжээ | сая.төг | 2024 | 30.0 | 100.0 | 1548 | 100 | 1548.0 | 1548.0 | 100 | Орхон сумын Залуугийн голын түүхий эдийн захын инженерийн шугам сүлжээний ажлыг улсын төсвийн энэ онд батлагдсан 600.0 сая төгрөг нийт 2.39 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2023-2025 онд бүтээн байгуулж, улсын комисс ажиллахад бэлэн болоод байна. 2025 онд түүхий эдийн захыг хашаажуулахаар 948.0 сая төгрөгийн тендер зарлаад байна. Орон нутгийн өсөлтийн төв буюу сум дундын үйлдвэрлэлийн төвүүдэд үйлдвэр байгуулахад шаардлагатай дэд бүтцийн өргөтгөл шинэтгэлийн судалгаа ТЭЗҮ хийхээр төлөвлөж байна. Мах, махан бүтээгдэхүүн боловсруулах цехийн үйл ажиллагаа эрхэлдэг "Товчлох хурд" ХХК-ийн дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэв. |
| **3.4.1.4** | | Стратегийн чухал ач холбогдолтой хүнсийг дотоодын үйлдвэрлэлээр хангах бодлогыг хэрэгжүүлнэ. | Хямд үнэтэй бэлтгэн нийлүүлсэн махны хэмжээ | тн | 2024 | 10 | 15 | 7.5 | 100 | - | - | - | Засгийн газрын "Стратегийн нөөц бүрдүүлэх тухай" тогтоолын дагуу аймгийн Засаг даргын 2025 оны А/192 дугаар захирамжаар Орхон аймгийн “Эрдмийт” ХХК-тай 10 тн мах нийлүүлж, 1 кг тутамд 2300 төгрөгийн урамшуулал олгохоор 1 кг үхрийн махыг 12500 төгрөг, хонины махыг 10500 төгрөг, ямааны махыг 8500 төгрөгөөр борлуулж, борлуулалт хийсэн дэлгүүрүүдэд 1 кг тутамд 200 төгрөгийн урамшуулал олгохоор гэрээ хийсэн. Аймгийн төвийн 6 багийн 9 дэлгүүрээр нөөцийн мах худалдаалагдаж, 7.5 тн мах борлуулагдаж, 17.25 сая төгрөгийн урамшуулал, худалдан борлуулсан 9 дэлгүүрт 1.06 сая төгрөгийн урамшуулал тус тус олгосон байна. |
| | | | Урамшууллын дүн | сая.төг | 2024 | 20.0 | 37.0 | 18.31 | 100 | 25.0 | 18.31 | 73.2 | Энэ онд 7.5 тн мах борлуулагдаж, 17.25 сая төгрөгийн урамшуулал, худалдан борлуулсан 9 дэлгүүрт 1.06 сая төгрөгийн урамшуулал, нийт 18.31 сая төгрөг зарцуулав. |
| **3.5** | **ТЕЗ** | Үйлдвэрлэл үйлчилгээг хөгжлийн төвүүдэд тулгуурлан хөгжүүлж, чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ. | Стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлчилгээний тоо | Тоо | 2024 | 210 | 220 | 223 | 100 | 5.5 | 5.5 | 100 | Стандартчилал тохирлын үнэлгээний шаардлага хангасан 4 төрлийн 13 бүтээгдэхүүнийг баталгаажуулалтын орон тооны бус зөвлөлөөр хэлэлцүүлж, тохирлын гэрчилгээ олгов. Үүнд: Мах махан бүтээгдэхүүн, сүү сүүн бүтээгдэхүүн, кимчи, цэвэр ус зэрэг байна. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **3.5.1** | **Хөтөлбөрийн** | Үйлдвэрлэл, үйлчилгээний стандарт хангалт, зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ. | Стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлчилгээний тоо | Тоо | 2024 | 210 | 220 | 360 | 100 | 5.5 | 5.5 | 100 | Энэ онд 11 төрлийн 137 үйлчилгээ, 4 төрлийн 13 бүтээгдэхүүнд холбогдох стандартаар тохирлын үнэлгээ хийж баталгаажуулалтын орон тооны бус зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэрлүүлж тохирлын гэрчилгээ олгосон. Үүнд: Хүнсний худалдаа 80, нийтийн хоол 31, амралт жуулчны бааз 13, 1 зочид буудал, 4 дэн буудал, 1 халуун ус, 2 үсчин, 1 гоёлын гоо засал, 2 хүүхдийн зуслан, 1 рашаан сувилал, 1 саун хамрагдсан байна.<br>Аймгийн хэмжээнд тохирлын үнэлгээний шаардлага хангасан 347 үйлчилгээ үйл ажиллагаа явуулж, тохирлын баталгаатай 38 бүтээгдэхүүн зах зээлд нийлүүлэгдэж байна. Аймгийн хэмжээнд амралт, аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгжүүдэд стандартыг сурталчлан таниулах “Стандарттай Булган” сэдэвт сургалт, нөлөөллийн арга хэмжээг 15 сум, 1 тосгонд зохион байгуулж, 550 хүнийг хамруулав. |
| **3.5.1.1** | | “Үйлдвэрлэлийн сэргэлт” хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ. | Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | хувь | 2024 | - | 25 | 25 | 100 | 809.2 | 809.2 | 100 | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны XI/78 дугаар тогтоолоор батлагдсан “Үйлдвэрлэлийн сэргэлт” хөтөлбөрийн хүрээнд “Миний Булганы Алтан намар 2025” үзэсгэлэн худалдааг Булган суманд 2025 оны 10 дугаар сарын 31-ээс 11 дүгээр сарын 01-ний өдрүүдэд Төрийн банктай хамтран зохион байгууллаа. Үзэсгэлэнд орон нутгийн мал, мах, сүү, цагаан идээ, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ зэрэг бүтээгдэхүүн борлуулагдсан. Мөн аймгийн Засаг даргын 2025 оны А/709 дүгээр захирамжаар орон нутгийн түүхий эдийн нөөц, газар зүйн онцлогт тулгуурласан онцлог “Брэнд бүтээгдэхүүн”-ий нэрсийг баталж, батламж гардуулж цаашид брэнд бүтээгдэхүүнийг үндэсний болон гадаадын зах зээлд гаргах зорилго тавьж байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багцаас Баян-Агт, Баяннуур, Булган, Бугат, Бүрэгхангай, Гурванбулаг, Дашинчилэн, Могод, Орхон, Рашаант, Сайхан, Сэлэнгэ, Хангал, Хишиг-Өндөр, Тэшиг сумдад 493.1 сая төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж нийлүүлж, орон нутгийн өмчид бүртгэж, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчидтэй ашиглалтын гэрээ байгуулсан. Хутаг-Өндөр сумд 271.0 сая төгрөгийн жижиг, дунд үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн. Тэшиг сумд Цөцгийн тосны үйлдвэр барих ажлыг улсын төсвийн 3695.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Сейф транс" ХХК гүйцэтгэж тоног төхөөрөмж суурилуулах ажил хийгдэж байна. |
| **3.5.1.2** | | “Бизнес инкубатор төв”-ийг байгуулж, бизнес эрхлэгчдийг чадавхжуулж, дэмжлэг үзүүлнэ. | Барилгын гүйцэтгэлээр | хувь | 2024 | - | | - | ХБ | - | - | - | Засгийн газрын 2025 оны 204 дүгээр "Хойд бүсийн хөгжлийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай" тогтоолд “Бизнес инкубатор төв”-ийн барилгын хөрөнгө оруулалтыг 2026 оны улсын төсвөөс шийдвэрлэхээр тусгагдлаа. Гарааны бизнест дэмжлэг үзүүлж, зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх “Бизнес инкубатор төв”-ийг бүтээн байгуулах 2507.76 сая төгрөгийн ТЭЗҮ хийгдэж, газрын асуудал шийдэгдсэн. 2026 оны төсөвт санал хүргүүлсэн. |
| | | | Дэмжлэгт хамрагдсан бизнес эрхлэгчдийн тоо | тоо | 2024 | - | - | | ХБ | | | | "Стандарттай Булган" сэдэвт сургалт, нөлөөллийн арга хэмжээг 15 сум, 1 тосгонд зохион байгуулж, 550 хүнийг хамруулав.<br>"Зочлох үйлчлэх салбарын сургалт хөгжлийн төв" Хорека институттэй хамтран 100 ажилтныг сургалтад хамруулж чадавхжуулав. "Сүүн зам" сургалтад 20 хүнийг хамруулав. |
| **3.5.1.3** | **Үйл ажиллагаа** | Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангуулна. | Чанар, аюулгүй байдлын үзүүлэлт | Хувь | 2024 | 75 | 77 | 77 | 100 | - | - | - | Төлөвлөгөөт хяналтаар 53 объект хамрагдаж (88.3 хувь), 272 дутагдал илрүүлснээс 65 хувийг нь газар дээр нь арилгуулж, эрсдэл бууралт 50 орчим хувьд ажиглагдав. Урьдчилан сэргийлэх хяналтаар цагаан сар, хүүхдийн баяр, айраг фестивальд зориулан 135 объект шалгаж, 79 зөрчлийн 75.9 хувийг арилгуулж, 3 зөвлөмж хүргүүлэн, 223 алба хаагчид сургалт хийв. Шинжилгээтэй хяналтаар үрийн болон хүнсний буудайн 99 дээжийг лабораторид шинжлүүлж, дүнг үндэслэн 5 удаагийн улсын байцаагчийн дүгнэлт гаргаж хүргүүллээ.<br>Хүнсний аюулгүй байдлын сорилтын лабораторийн чадамжийг бэхжүүлэхэд улсын төсвийн 45.1 сая төгрөгийн хөрөнгөөр автоклав, спектофотометр, био аюулгүйн кабинет, татах шүүгээгээр хангагдлаа. Тус лабораторид 343 аж ахуйн нэгж, иргэний ирүүлсэн 933 дээжийг хүлээн авч 1472 сорьцыг дэд лабораториудад хуваарилан 4969 үзүүлэлтээр нян судлал, хими, таримал ургамлын үр, хорио цээрийн шинжилгээг хийж, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эрсдэл болон бохирдлыг эрүүл ахуйн зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эсэхэд шинжилгээ хийж, үнэн бодит үр дүнг тайлагнаж, ажиллалаа. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **3.5.1.4** | | Аймгийн хэмжээнд нийтийн халуун усны засвар, шинээр барих асуудлыг бүрэн шийдвэрлэнэ. | Стандартын шаардлагад нийцсэн халуун усны тоо | Тоо | 2024 | 2 | 6 | 5 | 75 | 271.0 | 271.0 | 100 | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр сумдад шинээр барих халуун усны нэг маягийн зураг төслийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэн хүлээж авав. Баян-Агт сумын халуун усны гадна цахилгааны ажлыг орон нутгийн төсвийн 40.0 сая төгрөгөөр "Тэгш ургах" ХХК, Гурванбулаг суманд орон нутгийн хөгжлийн сангийн 231.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Баян Өндөр булаг" ХХК халуун ус шинээр барьж 2025 оны 10 дугаар сард ашиглалтад оруулав. Мөн Могод сумын халуун усны барилгыг ашиглалтад оруулаа. |
| **3.5.1.5** | | Орон нутгийн хөгжлийн төв Булган, Хутаг-Өндөр, Хишиг-Өндөр, Дашинчилэн суманд үйлдвэрлэл худалдаа үйлчилгээний кластер хөгжүүлэх хувийн хэвшил, хоршоодыг бодлогоор дэмжинэ. | Кластерт нэгдсэн жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн тоо | Тоо | 2024 | 6 | 8 | 8 | 100 | 108.0 | 108.0 | 100 | Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэнгээс зарласан Булган аймгийн орон нутгийн хөгжлийн төвд хөдөө аж ахуйн нөөцөд тулгуурлан үйлдвэрлэл үйлчилгээ, бирж, тээвэр, логистикийн цогцолбор байгуулах ТЭЗҮ боловсруулах тендерт “Системийн динамик загварчлал” ТББ шалгарч ажлыг гүйцэтгэж байна. Булган, Хутаг-Өндөр, Дашинчилэн, Хишиг-Өндөр сумын Засаг дарга нар, газрын даамал, жижиг, дунд үйлдвэрлэл, хоршоо хариуцсан мэргэжилтнүүдтэй аймгийн Засаг даргын орлогч, ХХААГ, ГХБХБГ, БОГ, “Системийн динамик загварчлал” ТББ хамтарсан уулзалтыг зохион байгуулж, орон нутгаас хамаарсан судалгаа мэдээллээр хангаж хамтран ажиллаж байна. Хутаг-Өндөр сумын төвд орон нутгийн хөгжлийн сангийн малын тоо толгойн албан татварын 8.0 сая төгрөгийн санхүүжилтээр малчдад зориулсан "Мах борлуулах цэг"-ийг ашиглалтад оруулсан. “Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй” ОНӨХХК жил бүрийн төсвөөс тодорхой хувийг өрхийн орлогийг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох зорилгоор төлөвлөн ажиллаж, аймгийн ИТХ-ын 2025 оны 8 дугаар хуралдааны 59 дүгээр тогтоолоор 100.0 сая төгрөг батлуулж, Хутаг-Өндөр сумын Мэргэн хөтөлд хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн борлуулах 18 ширхэг павилон байрлуулснаар Баян-Агт, Сайхан сумын Ундрах баг, Угалз баг, Сайхан-Овоо баг, Хутаг-Өндөр сумын Унът багийн малчид иргэдийг улирлын чанартай түр ажлын байраар хангаж, цагаан идээгээ борлуулах, өрхийн орлого нэмэгдүүлэх боломж бүрдэж байна. |
| **ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН СЭРГЭЛТ** | | | | | | | | | | | | | |
| **Хууль, эрх зүй** | | | | | | | | | | | | | |
| **4.1** | **ТЕЗ** | Амар тайван, аюулгүй орчныг бий болгоно. | Гэмт хэрэг, зөрчлийн гаралтын тоо | тоо | 2023 | 383 | 375 | 397 | 0 | | | | Аймгийн Засаг даргын 2025 оны А/360 дугаар захирамжаар 2025 онд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 40 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн. Аймгийн хэмжээнд 2025 онд 397 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 12.1 хувиар өсөж, зөрчил 2134 бүртгэгдэн өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2.8 хувиар буурсан. |
| **4.1.1** | **Хөтөлбөрийн** | Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг нэмэгдүүлнэ. | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | тоо | 2024 | 12 | 15 | 35 | 100 | | | | 2025 оны байдлаар гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох, илрүүлэх, үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй “Шинэ жил-2025”, “Сар шинэ-2025”, “Цахим архи-Худалдаа”, “Хуулиа мөрдөе”, “Хүн бүр хүүхэд хамгаалагч”, “Анзаар-2”, “Байгалиа хамгаалъя”, "Мал мах- 2025", "Залгая, лавлая", “Хуулийн хэрэгжилт”, "Орон нутгийн зам хөдөлгөөний соёл-2025" зэрэг 11 нэгдсэн арга хэмжээ, орон нутагт “Тандалт”, “Тамхины хяналт”, “Тусгай зөвшөөрөл”, “Сургалт”, “Торгууль нөхөн төлүүлэлт”, “Телеграмм залилан”, “Хөлсний байр”, “+21 нас”, “Устгал”, “Цэргийн баяр”, “Давхар дуудлага”, “Замын хөдөлгөөн-Цагаан толгой”, "Нэгдэе", "Уусан бол бүү жолоод", "Хурдаа хас", "Гэрэлтүүлэг", "Хичээл эхэллээ", "Давтамжтай дуудлага" зэрэг 24 хэсэгчилсэн арга хэмжээг төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран зохион байгуулсан. Эдгээр арга хэмжээнүүдийг зохион байгуулахад "Амар тайван Булган" хөтөлбөрийн зардлаас 22.1 сая төгрөг шийдвэрлэсэн. |
| **4.1.1.1** | | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх “Амар тайван Булган” хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ. | Хөтөлбөрийн хэрэгжилт | хувь | 2024 | 0 | 70 | 80.9 | 100 | 40 | 40 | 100 | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын VII/38 дугаар тогтоолоор “Амар тайван Булган” хөтөлбөрийг батлуулсан. Хөтөлбөрийн 3 зорилтын хүрээнд 20 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 2025 оны төлөвлөгөөг боловсруулсан. Төлөвлөгөөний хүрээнд 11 нэгдсэн болон 18 хэсэгчилсэн арга хэмжээг 7 иргэний нийгмийн байгууллагатай хатран зохион байгуулсан. Согтууруулах ундаа тогтмол хэрэглэдэг 30 иргэнийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх албадан хөдөлмөр хийлгэх газарт хүргүүлсэн. Сүүлийн жилүүдэд гэмт хэрэг тогтмол өссөн нэр бүхий сумдад "орлоготой өрх" арга хэмжээг зохион байгуулан ажиллалаа. 2025 оны байдлаар хөтөлбөрийн хэрэгжилт 80.9 хувьтай байна. Аймгийн Засаг даргын 2025 оны А/360 дугаар захирамжаар 2025 онд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 40 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **4.1.1.2** | **Үйл ажиллагаа** | Ухаалаг камерын хяналтын нэгдсэн системийг сайжруулна. | Камержуулалтын гүйцэтгэл | хувь | 2024 | 40 | 50 | 50 | 100 | 400 | 400 | 100 | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийтийн эзэмшлийн гудамж талбайг камержуулах “Ногоон сум” ажил арга хэмжээг зохион байгуулахаар 2025 оны орон нутгийн төсөвт 11 суманд 382.0 сая төгрөг, аймгийн теле хяналтын камерын дэд төвд ухаалаг программ хангамж нэвтрүүлэх, аж ахуйн нэгжийг холбох чиглэлээр аймгийн 2025 оны төсөвт 400 сая төгрөг, мөн төвийн урсгал зардалд 197.5 сая төгрөгийг тус тус шийдвэрлэсэн. Аймгийн хэмжээнд шинээр 10 цэгт 22 камер суурилуулсан бөгөөд Булган сумын төвийн 44 цэгийн 99 камераас эвдрэлтэй 51 камерыг засварласан. "Амар тайван Булган" хөтөлбөрийн хүрээнд Булган сумын 19.8 сая төгрөгийн санхүүжилтээр дугаар танигчтай 4 камер, чиглэлийн 20 камерыг засварласан. 2025 оны 10 дугаар сарын байдлаар дэд төв нь 88 ширхэг чиглэлийн, 8 ширхэг PTZ, 4 тусгай зориулалтын камерыг хэвийн ажиллагаанд оруулж, 31 аж ахуйн нэгж, байгууллагыг дэд төвтэй холбосон байна. Булган сумын 6 багт нийт 1230 метр шилэн кабелыг татаж шинэчилсэн. Мөн Булган сумын 6 багийн хүүхдийн 8 тоглоомын талбайг дэд төвтэй холбосон бөгөөд камержуулалтын гүйцэтгэл 90 хувьтай байна. |
| **4.1.1.3** | | Хууль, эрх зүйн салбарын байгууллагуудын ажиллах орчин нөхцөлийг сайжруулна. | Тухайн жилд хууль, эрх зүйн салбарын байгууллагуудад дэмжлэг үзүүлсэн тоо | тоо | 2024 | 6 | 7 | 16 | 100 | 220.7 | 220.7 | 100 | 2025 онд хууль, эрх зүйн салбарын байгууллагуудад нийт 16 удаагийн дэмжлэг үзүүлж, аймгийн Засаг дарга болон 11 сум, 1 тосгоноос 220.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Энэ дэмжлэг нь аюулгүй байдал, хүүхэд хамгааллын үйлчилгээ болон тээврийн хэрэгсэл, техөөрөмжийн засвар үйлчилгээ зэрэг үйл ажиллагаанд зориулагдсан. Тус дэмжлэгийн хүрээнд хууль, эрх зүйн салбарын байгууллагуудын үйл ажиллагаа сайжирч, орон нутаг дахь хууль сахиулах үйл ажиллагааны чанар, үр ашиг нэмэгдсэн. |
| **4.1.1.4** | | Хууль хяналтын байгууллага мэргэжлийн байгууллагуудтай хамтран нэгдсэн болон тусгай, хэсэгчилсэн ажил арга хэмжээг зохион байгуулж ажиллана. | Зохион байгуулсан арга хэмжээ | тоо | 2024 | 12 | 15 | 35 | 100 | 30 | 30 | 100 | 2025 оны байдлаар гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох, илрүүлэх, үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр "Шинэ жил-2025”, “Сар шинэ-2025”, “Цахим архи-Худалдаа”, “Хуулиа мөрдөе”, “Хүн бүр хүүхэд хамгаалагч”, "Залгая, лавлая", “Хуулийн хэрэгжилт”, “Тандалт”, “Тамхины хяналт”, “Тусгай зөвшөөрөл”, “Сургалт”, “Торгууль нөхөн төлүүлэлт”, “Телеграмм залилан”, “Хөлсний байр”, “+21 нас”, “Цэргийн баяр”, “Давхар дуудлага”, “Замын хөдөлгөөн-Цагаан толгой”, "Нэгдэе", "Уусан бол бүү жолоод", "Хурдаа хас", "Гэрэлтүүлэг", "Хичээл эхэллээ", "Давтамжтай дуудлага" зэрэг 35 нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг төрийн хууль хяналтын болон иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран зохион байгуулсан. |
| **4.1.1.5** | | Орон нутгийн харьяаны хил хамгаалах байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ. | Хил хамгаалалтад туслах хүчний төлөвлөгөөний хэрэгжилт | хувь | 2024 | 80.6 | 82 | 100 | 100 | 80 | 80 | 100 | Тэшиг сум дахь Хилийн цэргийн 0286 дугаар ангийн албаны болон алба хаагчдын байрлах байрыг аж ахуйн аргаар барихад дэмжлэг үзүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2025 оны А/226, А/227, А/228 дугаар захирамжаар нийт 80 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэж, тухайн ажлыг 100 хувь гүйцэтгэж ашиглалтад оруулсан байна. Мөн Тэшиг сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс 12 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэн Хилийн цэргийн 0294 дүгээр салбарт алба хаагчдын хэрэглээнд ундны худаг гаргасан байна. Хил хамгаалах туслах хүчний 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувьтай байна. |
| **4.2** | **ТЕЗ** | Гамшгийн эрсдэлийг даван туулах чадварыг нэмэгдүүлнэ. | Зохион байгуулсан сургалт, дадлагын тоо | тоо | 2024 | 4 | 4 | 16 | 100 | | | | 2025 онд гамшгаас хамгаалах команд штабын сургуулийг ОБЕГ-аас Булган аймагт зохион байгуулахаар төлөвлөсний дагуу 16 суманд бэлэн байдлын дадлага сургуулийг зохион байгуулав.<br>Тайлант хугацаанд гамшгаас хамгаалах чиглэлээр 54 удаагийн сургалт, дадлага зохион байгуулж, 1010 хүн хамруулав. Булган аймагт үйл ажиллагаа эрхлэдэг "Сод Монгол", "Тэс петролиум", "Шунхлай" ХХК-ийн 42 ажилтан, түгээгч нарт шатахуун түгээх станцын галын аюулгүй байдал, стандартын хэрэгжилт болон эрсдэл учирсан үед авах хариу арга хэмжээний сургалт, дадлагыг зохион байгуулсан. Мөн аймаг, сумын төрийн байгууллагууд, мэргэжлийн алба, анги, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, сурагчид, эрүүл мэнд, хууль сахиулах байгууллагын ажилтан, алба хаагч, 16 сум, 1 тосгоны удирдлага, иргэд, хүүхдүүдийг хамруулан Галын аюулгүй байдлын тухай хууль, объектын гал түймрийн аюул, газар хөдлөлт, шар усны үерийн аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлийн танхимын сургалт болон дадлага сургуулийг зохион байгууллаа. Үүнээс гадна Булган сумын худалдаа, үйлчилгээ, олон нийтийн болон үзвэр үйлчилгээний байгууллагын 35 ажилтан, алба хаагчид гамшиг, аюулт үзэгдэл, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх сургалт, гал унтраагуур ашиглах дадлага, гал унтраах сургуулилт зохион байгуулж, гамшгаас хамгаалах бэлэн байдлыг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүллээ. |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **4.2.1** | **Хөтөлбөрийн** | Орон нутгийн гамшгийн эрсдэлийг бууруулна. | Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийсэн сумын тоо | тоо | 2024 | 1 | 4 | 16 | 100 | 10 | 10 | 100 | Тайлант хугацаанд аймгийн Засаг даргын захирамжийн дагуу гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг аймгийн бүх суманд бүрэн хийж, сум бүрийн гамшгийн төрлүүдийн аюулын түвшин, эмзэг байдал, өртөх байдал болон чадавхын үнэлгээг шинэчлэн тодорхойллоо. Ой, хээрийн түймрийн эрсдэлийн үнэлгээг 16 суманд хийж, 13 сумыг дунд эрсдэлтэй, 3 сумыг их эрсдэлтэйд үнэлсэн бол үерийн эрсдэлийн үнэлгээгээр 9 сумыг их, 7 сумыг дунд эрсдэлтэйд тус тус үнэлсэн. Ийнхүү 16 суманд гамшгийн эрсдэлийн үнэлгээг хийж, үнэлгээнд үндэслэн эрсдэлийг бууруулах төлөвлөгөө боловсруулах чиглэл, зөвлөмжийг сумдад хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажиллав. |
| **4.2.1.1** | **Үйл ажиллагаа** | Болзошгүй гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, сэргээн босгох чадавхыг бэхжүүлж, иргэдийн боловсролыг дээшлүүлнэ. | Ангиллын сургалтад хамрагдсан иргэд | Хувь | 2024 | 10 | 10 | 21.1 | 100 | 2 | 2 | 100 | Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангуулж аймгийн Засаг даргын 2025 оны А/366 дугаар захирамжаар аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсгийг 11 хэсэгтэйгээр байгуулсан. Онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сумын Засаг дарга, Тамгын газрын холбогдох албан тушаалтан төлөөллийг оролцуулан Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг 2025.09.24-26-ны өдрүүдэд зохион байгуулж “Хангалттай” үнэлгээ авсан. Гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах чиглэлээр иргэдийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор энэ онд 10000 хүнд сургалт, мэдээлэл олгох зорилт тавин ажиллаж, 214 удаагийн гамшгаас хамгаалах ангиллын сургалтыг 13088 хүнд хийсэн. Энэ нь нийт хүн амын 21.1 хувийг эзэлж байна. |
| **4.2.1.2** | | Орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхыг сайжруулж сургалт, дадлага зохион байгуулах, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсгийг ажиллах нөхцөлөөр хангаж техник, зэвсэглэмжийг нэмэгдүүлнэ. | Техник, зэвсэглэмжийн хангалт | Хувь | 2024 | 30 | 35 | 31 | 20 | 10 | 10 | 100 | 2025 онд сумдын гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсгүүдийн ажиллах нөхцөлийг хангах, багаж хэрэгсэл, техник, зэвсэглэмжийг сайжруулах ажлын хүрээнд 13 сум, 1 тосгонд 111.8 сая төгрөгөөр багаж хэрэгсэл авч, сургалт, дадлага зохион байгуулсан. Аймгийн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, хуулийн этгээдийн хүрээнд гамшгаас хамгаалах чадавхийг сайжруулахад 100.0 сая төгрөг зарцуулан техник хэрэгсэл, бэлэн байдлыг хангаж, Хутаг-Өндөр, Дашинчилэн сумын Эрэн хайх, аврах салбар бүлгийн үйл ажиллагааг “ИСУЗИ” маркийн хээрийн гал түймэр унтраах зориулалтын "Пикап" автомашин, сургалтын танхим, тоног төхөөрөмж, халаалтын шугам сүлжээ зэрэг техник, зэвсэглэмжээр ханган шинэчлэх ажлыг хийв. Аймгийн Шуурхай удирдлагын хөдөлгөөнт байрны бэлэн байдлыг ЗИЛ-131 автомашинаар тоноглон гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэх, удирдлага зохицуулалтаар хангах нөхцөлийг бүрдүүлсэн. |
| **4.2.1.3** | | Ус, цаг уурын ажиглалтын болон орчны хяналт-шинжилгээний сүлжээг өргөжүүлж, болзошгүй байгалийн гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлнэ. | Орон нутгийн өртөө харуулын ажиглалтын автомат станцын бэлэн байдлын түвшин | Хувь | 2024 | 60 | 70 | 70 | 100 | | | | Агаарын чанарын хяналтыг сайжруулах хүрээнд 24 цагийн ажиллагаатай агаарын чанарын автомат станц суурилуулж, ашиглалтад оруулаа. Уг станц нь тоосонцор (PM2.5), азотын давхар исэл, хүхэрлэг хий зэрэг бохирдуулагч бодисуудыг тогтмол хянах боломжийг бүрдүүлж байна. Аюултай болон гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх анхааруулга мэдээ 36, сэрэмжлүүлэг мэдээ 5, урьдчилан сэргийлэх мэдээ 2 удаа 72-12 цагийн өмнө гаргаж, “Багц мессеж”, “Булган аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв” фэйсбүүк хуудас, өөрийн “bulgan.weather.gov.mn” цахим хаягаар цаг тухайд нь шуурхай дамжуулж байлаа. Сэрэмжлүүлэг мэдээг 100 хувийн таарцтай зохиож үйлчилсэн байна. |
| **Батлан хамгаалах** | | | | | | | | | | | | | |
| 4.3 | **ТЕЗ** | Иргэдийн эх орноо хамгаалах бэлтгэлжилтийг дээшлүүлнэ. | Цэргийн бэлтгэл үүрэгтний хамрагдалтын хувь | Хувь | 2024 | 4 | 5 | 5 | 100 | 15 | 15 | 100 | Засгийн газрын 2017 оны 32 дугаар тогтоолоор батлагдсан Оюутан цэрэгт цэргийн мэргэжил олгох сургалтын журам, Батлан хамгаалахын сайдын 2025 оны А/43 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2025 оны А/204 дүгээр захирамжийн дагуу Булган аймгийн ХААИС-ийн харьяа Политехникийн коллежийн 9 оюутныг "Оюутан - цэрэг" сургалтад элсүүлж цэргийн албыг амжилттай хаалгаад байна. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2025 оны А/570 дугаар захирамжийн дагуу Булган аймагт цэргийн дүйцүүлэх албыг биеэр хааж буй иргэдийн цэргийн бэлтгэл сургалтыг 2025 оны 09 дүгээр сарын 19-28-ны өдрүүдэд 10 хоногийн хугацаатай Хангал сумын Хялганат тосгонд байрлах Зэвсэгт хүчний 234 дүгээр ангийг түшиглэн зохион байгуулаа. Дайчилгааны даалгавар бүхий Зэвсэгт хүчний 234 дүгээр ангид дайчилгааны бэлтгэл нөөцийн I зэргийн бэлтгэл үүрэгтний сургалтыг 2025 оны 06 дугаар сарын 23-28-ны өдрүүдэд зохион байгуулж, цэргийн үүрэгтний үнэмлэхэд тэмдэглэл хийж, сургалтын тайланг Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний жанжин штабт хүргүүлсэн. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **4.3.1** | **Хөтөлбөрийн** | Батлан хамгаалах хуулиар хүлээсэн үндсэн үүргийг хэрэгжүүлнэ | Цэргийн насны залуучуудын хамрагдалтын хувь | Хувь | 2024 | 9 | 10 | 10 | 100 | 30 | 30 | 100 | Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2025 оны мн/05 дугаар тушаалын дагуу аймгийн Засаг даргын 2025 оны А/181, А/583 дугаар захирамжаар 2025 оны I, II ээлжийн цэрэг татлагын товчоо байгуулагдан цэрэг татлага зохион байгуулж, ЗХЖШ-аас өгсөн хяналтын тоог 100 хувь биелүүлсэн. Цэрэг татлагаас оргон зайлж, зугтаасан 19 иргэнд Зөрчлийн тухай хуулиар торгох шийтгэл ноогдуулсан. |
| **4.3.1.1** | **Үйл ажиллагаа** | Батлан хамгаалах хууль тогтоомжийг хэрэгжүүлж, хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлнэ. | Иргэдэд батлан хамгаалах хууль, тогтоомжийг сурталчилсан арга хэмжээний тоо | тоо | 2024 | 2 | 3 | 3 | 100 | 15 | 15 | 100 | Батлан хамгаалах зарим чиг үүргийг Булган аймагт 2025 онд төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний дагуу цэрэг-спортын “Дөл” цогцолбор тэмцээнийг аймгийн Засаг даргын 2025 оны А/229 дүгээр захирамжаар Халхын голын дайны ялалтын 86 жилийн ойг тохиолдуулан БНМАУ-ын баатар нисгэгч Ч.Шагдарсүрэнгийн мэндэлсний 115 жилийн ойн нэрэмжит болгон 05 дугаар сарын 08-09-ний өдрүүдэд Булган суманд зохион байгууллаа. Тэмцээнд амжилттай оролцсон баг, тамирчдад шилжин явах цом, медаль, хүндэт өргөмжлөл хадгалуулан нийт 2,8 сая төгрөгөөр шагнаж урамшууллаа.<br>Булган сумын ЗДТГ-тай хамтран ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчдын дунд сурагчдын өөрийгөө илэрхийлэх хүүхэд багачуудын хүсэл сонирхлыг дэмжих, үндэсний өв соёлыг таниулах, эх орноо хайрлан хамгаалах, тэдний дотоод ертөнц дэх авьяас чадварыг нээн таниулах зорилгоор “Мэтгэлцээн”, “Дэвжээ”, “Нумт сурын харваа”, “Үндэсний шагайн харваа”, “Бид эх орныхоо төлөө юу хийж чадах вэ?” сэдэвт контент бүтээх уралдаан, тэмцээнийг тус тус зохион байгуулж эхний 3 байр эзэлсэн баг тамирчдад өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан. Аймгийн 16 сумын ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд “Эх оронч үзэл-Үндэсний бахархал” сэдэвт эсээ бичлэгийн уралдааныг зохион байгуулав. |
| **4.3.1.2** | | Орон нутгийн томилгоот нэгжийн дадлага сургуулилтыг улс болон аймгийн хэмжээнд бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулна. | Зохион байгуулсан цэргийн сургалтын тоо | тоо | 2024 | 2 | 2 | 2 | 100 | 4.5 | 4.5 | 100 | Төвийн бүсийн орон нутгийн томилгоот нэгжийн цэргийн бэлтгэл сургалтыг аймгийн Засаг даргын 2025 оны А/384 дүгээр захирамжаар зохион байгуулж, сумдын томилгоот 76 хүн оролцож батлан хамгаалахын болон орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн мэдлэг, гүйцэтгэх үүргийн дадлага чадвар эзэмшсэн. |
| **4.3.1.3** | | Орон нутаг дахь Зэвсэгт хүчний алба хаагчдын эрүүл, тогтвортой ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ. | Цэргийн штаб, цэргийн анги байгууллагын хийгдэж буй бүтээн байгуулалтын гүйцэтгэлийн хувь | Хувь | 2024 | 0 | 50 | 0 | 0 | | | | Энэ онд Зэвсэгт хүчний 234 дүгээр ангийн аврах ажиллагаанд зориулж усны зориулалтын хувцас хэрэгсэл авахад аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 5.3 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. |
| | | | | | | **Цахим засаглал** | | | | | | | |
| **4.4** | **ТЕЗ** | Төрийн үйлчилгээг иргэдэд хурдан шуурхай, ил тод хүргэнэ. | Цахим үйлчилгээ авсан иргэд | хувь | 2024 | 11.1 | 15 | 30.4 | 100 | | | | 2025 онд хүн, хуулийн этгээдэд 9119 лавлагаа, тодорхойлолт болон нэг ба олон шатлалт үйлчилгээг хүргэн ажилласан байна. Мөн Төрийн цахим үйлчилгээний хэлтэс, аймгийн төвд байрлах 6 киоск, 16 сум, 1 тосгонд байрлах 23 ХУРДАН киоск төхөөрөмж, 11 суманд байрлах 24/7 цахим үйлчилгээний төвөөр дамжуулан нийт 18368 төрийн үйлчилгээг иргэдэд хүргэв. Энэ нь нийт иргэдийн 30.4 хувийг эзэлж байна. |
| **4.4.1** | **Хөтөлбөрийн** | Төрийн үйлчилгээг цахимжуулна. | Төрийн цахим үйлчилгээний тоо | Тоо | 2024 | 61 (7.7%) | 63 (8.02%) | 63 | 100 | | | | Аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсээс 2025 онд бүтээгдэхүүн үйлчилгээний баталгаажуулалтын үйл ажиллагаа, стандартын мэдээлэл, лавлагаа зэрэг үйлчилгээнүүдийг цахим (https://cert.masm.gov.mn/, https://estandard.gov.mn/)-д шилжүүлснээр аймгаас цахимаар үзүүлж буй үйлчилгээний тоо 63 болсон байна. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4.4.1.1 | | Төрийн үйл ажиллагааны хурд, бүтээмжийг дээшлүүлж, иргэдэд түргэн шуурхай, хялбар үйлчилгээ үзүүлэх "Цахим Булган" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | Хувь | 2024 | 0 | 100 | 95 | 95 | 60 | 60 | 100 | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн XI/82 дугаар тогтоолоор төрийн үйл ажиллагааны хурд, бүтээмжийг нэмэгдүүлэх "Цахим Булган" хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлж байна.<br>Хөтөлбөрийн хүрээнд Орхон аймагтай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний дагуу олгогдсон 100 сая төгрөгийн санхүүжилтээр “И-Оффис” программ хангамжийг “Анар Системс” компаниар гүйцэтгүүлж, аймгийн төрийн байгууллагуудын өдөр тутмын үйл ажиллагаанд үе шаттай нэвтрүүлэхээр ажиллаж байна. Кибер халдлагын эрсдэлийг бууруулах, цахим орчны зөв хэрэглээг төлөвшүүлэх зорилгоор “Булганчууд залилуулахгүй”, “Цахим орчны зөв, боловсон хэрэглээ” сэдвийн хүрээнд төр, төсвийн байгууллагын мэдээлэл технологийн ажилтан болон мэдээлэл зүйн багш нарын давхардсан тоогоор 100 хүн хамрагдсан сургалтуудыг зохион байгууллаа. 2025 онд 9119 лавлагаа, тодорхойлолт, ХУР, E-Mongolia зэрэг нэг болон олон шатлалт төрийн 18368 үйлчилгээг иргэдэд үзүүлэв. Эдгээр үйлчилгээг аймгийн төвд байрлах 6 киоск, 16 сум, 1 тосгонд байрлах 23 “ХУРДАН” киоск, 11 сумын 24/7 цахим үйлчилгээний төвүүдээр дамжуулан үзүүлсэн бөгөөд энэ нь аймгийн нийт иргэдийн 30.4 хувьд хүрсэн үзүүлэлт юм. Аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсээс бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалт болон стандартын мэдээлэл, лавлагааны үйлчилгээг cert.masm.gov.mn, estandard.gov.mn системээр дамжуулан цахимд бүрэн шилжүүлснээр Булган аймагт үзүүлж буй цахим үйлчилгээний төрөл 63 болж нэмэгдсэн. “Цахим Булган” хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр 2025 онд 14 арга хэмжээ төлөвлөн 60.0 сая төгрөг батлуулснаас төлөвлөгөөний хэрэгжилт 95 хувьтай, төсвийн гүйцэтгэл 100 хувьтай байна. |
| 4.4.1.2 | **Үйл ажиллагаа** | Төрийн мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллана. | Аймгийн ил тод байдлын үнэлгээний хувь | Хувь | 2024 | 53 | 80 | 75 | 81.4 | | | | Аймгийн хэмжээнд “Нээлттэй мэдээллийн систем”-д 171 байгууллага бүртгүүлэхээс татан буугдсан 9 байгууллагыг хасаж, тайлан илгээх 162 байгууллагыг системд бүрэн бүртгэсэн. 2025 оны 1 дүгээр улиралд 43 байгууллага, 2 дугаар улиралд 39 байгууллага, 3 дугаар улиралд 40 байгууллага тайлангаа илгээсэн. Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд байгууллагуудын систем хариуцсан албан хаагчид, сумдын Засаг даргын тамгын газар, сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн төв, соёлын төвүүдийн холбогдох ажилтнуудад аймгийн Засаг даргын Тамгын газар болон Төрийн цахим үйлчилгээний хэлтэс хамтран танхимаар 4 удаа, цахимаар 3 удаагийн сургалт, арга зүйн зөвлөгөө өгч, сургалтад 245 албан хаагчийг хамруулсан. Аймгийн төрийн мэдээллийн ил тод байдлын үнэлгээ 2025 оны 3 дугаар улирлын байдлаар 75 хувьтай байна. |
| 4.4.1.3 | | Төрийн захиргааны байгууллагуудын барилгын өргөтгөл, шинэчлэл, засварын ажлыг хэрэгжүүлнэ. | Төрийн байгууллагад хийгдсэн засвар, өргөтгөлийн тоо | тоо | 2024 | 5 | 8 | 9 | 100 | | | | 2025 онд төрийн захиргааны 9 байгууллагад барилгын өргөтгөл, шинэчлэл засварын ажлыг хийж, нийт 467.1 сая төгрөг зарцууллаа. Хялганат тосгоны Захирагчийн ажлын алба конторын гадна болон дотор их засварыг 54.5 сая төгрөгөөр, Хутаг-Өндөр сум ОНХС-ийн 15.0 сая төгрөгөөр Хантай 2-р багийн захиргааны байрны засварыг хийсэн. Бүрэгхангай сумын ЗДТГ хуучин барилгын засварын зардалд 25.0 сая төгрөг, Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газрын барилгын их засварын ажлыг аймгийн төсвийн 205.0 сая төгрөгөөр, ОНХС-ийн 85.0 сая төгрөгөөр өрөө тасалгааг шинэчлэн засварласан байна. Сэлэнгэ сум ЗДТГ-ын байрны гадна засварт 4 сая төгрөг, Рашаант сумын Засаг даргын Тамгын газрын дээврийн засварт 14.8 сая төгрөг зарцуулж засварласан байна. Дашинчилэн сум Засаг даргын Тамгын газрын барилгын засварт байгууллагын төсвийн 29.0 сая төгрөгийн хөрөнгөөр, Лах багийн төвийн засварын ажлыг ОНХС-ийн 20.0 сая төгрөгийн хөрөнгөөр тус тус хийж гүйцэтгэсэн байна. |
| **Түүхт ойг тэмдэглэн өнгөрүүлэх** | | | | | | | | | | | | | |
| 4.5 | **ТЕЗ** | Булган аймаг байгуулагдсаны түүхт 90 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулна. | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | Хувь | 2024 | - | 25 | 0 | 0 | | | | Аймгийн 90 жилийн ойг 2027 онд зохион байгуулахтай холбогдуулан ажлын хэсэг байгуулах, ойг зохион байгуулах төлөвлөлтийн талаарх асуудлыг аймгийн ИТХ-ын ээлжит 12 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна. |
| 4.5.1 | **Хөтөлбөрийн** | Аймгийн 90 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулах төлөвлөгөөг батлан, хэрэгжүүлнэ. | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | хувь | 2024 | - | 25 | 0 | 0 | | | | Аймгийн 90 жилийн ойг 2027 онд зохион байгуулахтай холбогдуулан ажлын хэсэг байгуулах, ойг зохион байгуулах төлөвлөлтийн талаарх асуудлыг аймгийн ИТХ-ын ээлжит 12 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна. |
| 4.5.1.1 | **Үйл ажиллагаа** | Аймгийн 90 жилийн ойн баяр наадмыг зохион байгуулах 90 бүтээлч ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлнэ. | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | хувь | 2024 | - | 25 | 0 | 0 | | | | Аймгийн 90 жилийн ойг 2027 онд зохион байгуулахтай холбогдуулан ажлын хэсэг байгуулах, ойг зохион байгуулах төлөвлөлтийн талаарх асуудлыг аймгийн ИТХ-ын ээлжит 12 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна. |
| **Мэргэшсэн, ёс зүйтэй төрийн алба** | | | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **4.6** | **ТЕЗ** | Мэргэшсэн, ёс зүйтэй төрийн албыг бэхжүүлнэ. | Мэргэжил ёс зүйд иргэдийн өгсөн сэтгэл ханамжийн судалгаа | Хувь | 2023 | 60 | 70 | 62 | 20 | - | - | - | Байгууллагын хүний нөөцийг хөгжүүлэх, төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадвар, ажлын туршлагыг нэмэгдүүлэх зорилгоор 86 удаагийн дотоод сургалт, зөвлөгөөн, семинарыг зохион байгуулж, давхардсан тоогоор 5375 төрийн албан хаагч хамрагдсан байна. Үүнд: Танхимын 38 удаагийн сургалтад 2712 албан хаагч, цахим 24 удаагийн сургалтад 1132 албан хаагч, 24 удаагийн семинар, зөвлөгөөнд 1531 албан хаагч тус тус оролцсон. Сургалтад хамрагдсан нийт төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадвар, ажлын бүтээмж 30 хувиар нэмэгдсэн. Төрийн захиргааны албан хаагчдыг мэргэшүүлэхээр Удирдлагын академийн мэргэшүүлэх багц сургалтад 52 албан хаагч, төрийн албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалтад Бүрэгхангай, Сэлэнгэ, Могод, Орхон, Дашинчилэн, Баяннуур, Тэшиг сумын ИТХ-ын ажлын алба болон ЗДТГ-ын 195 албан хаагч хамрагдсан нь нийт төрийн захиргааны албан хаагчдын 43.4 хувийг эзэлж байна. Төрийн албан хаагчдад чиглэгдсэн сургалтын үр дүнд төрийн үйлчилгээг төрийн албан хаагчид иргэд, олон нийтэд хурдан шуурхай хүргэж, ажлын бүтээмжийг нэмэгдүүлж байна. |
| **4.6.1** | **Хөтөлбөрийн** | Төрийн албан хаагчдын ажлын туршлага, мэдлэг чадвар, ёс зүйг дээшлүүлнэ. | Төрийн албан хаагчдын мэдлэг ур чадварын үнэлгээ | Хувь | 2019 | 83 | 85 | 84 | 50 | - | - | - | Аймгийн хэмжээнд төрийн 118 байгууллагын дэргэд ёс зүйн дэд хороо үйл ажиллагаа явуулж, төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, гомдол мэдээллийг хүлээн авч шийдвэрлэх чиглэлээр тогтмол ажиллаж байна. Бүрэгхангай, Баяннуур, Баян-Агт, Бугат, Сэлэнгэ, Дашинчилэн, Могод, Гурванбулаг, Рашаант, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр, Тэшиг, Хангал сум болон Хялганат тосгоны нийт 28 байгууллагын 1680 албан хаагч төрийн албан хаагчдын ёс зүйн тухай хуулийн сургалтад хамрагдсан бөгөөд энэ нь аймгийн нийт төрийн албан хаагчдын 40.3 хувийг эзэлж байна. Тус онд зохион байгуулагдсан нийт сургалтын хамрагдалт 80.7 хувьд хүрч, шинэ албан хаагчдын чадавх 87 хувийн хамрагдалттайгаар сайжирсан. Мөн мэргэшил, боловсролын дэмжлэг бодитоор нэмэгдсэн нь хүний нөөцийн чанарын үзүүлэлтийг сайжруулж байна. |
| **4.6.1.1** | | Төрийн албан хаагчдыг дотоодод болон гадаадын улс орнуудад сургалтад хамруулж, туршлага судлуулан, мэдлэг ур чадварыг дээшлүүлнэ. | Гадаад, дотоодод туршлага солилцсон албан хаагчдын тоо | тоо | 2024 | 780 | 902 | 5570 | 100 | 40 | 40 | 100 | Байгууллагын хүний нөөцийг хөгжүүлэх, төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадвар, ажлын туршлагыг нэмэгдүүлэх зорилгоор 86 удаагийн дотоод сургалт, зөвлөгөөн, семинарыг зохион байгуулж, давхардсан тоогоор 5375 албан хаагч хамрагдсан байна. Төрийн захиргааны албан хаагчдыг мэргэшүүлэхээр Удирдлагын академийн мэргэшүүлэх багц сургалтад 52 албан хаагч, төрийн албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалтад Бүрэгхангай, Сэлэнгэ, Могод, Орхон, Дашинчилэн, Баяннуур, Тэшиг сумын ИТХ-ын ажлын алба болон ЗДТГ-ын 195 албан хаагч хамрагдсан нь нийт төрийн захиргааны албан хаагчдын 43.4 хувийг эзэлж байна. Төрийн албан хаагчдад чиглэгдсэн сургалтын үр дүнд төрийн үйлчилгээг төрийн албан хаагчид иргэд, олон нийтэд хурдан шуурхай хүргэж, ажлын бүтээмжийг сайжруулсан. |
| | | | Гадаадад туршлага судалсан албан хаагчдын тоо | тоо | 2024 | 40 | 80 | 145 | 100 | 60 | 60 | 100 | Төрийн албан хаагчдыг гадаадад туршлага судлуулах ажлын хүрээнд БНХАУ, БНСУ, Япон, ОХУ-д боловсролын салбарын багш, ажилчид, эрүүл мэндийн салбарын эмч, эмнэлгийн ажилтнууд, төрийн захиргааны чиглэлээр богино, дунд хугацааны сургалтад 145 албан хаагч хамрагдсан байна. |
| | **Үйл ажиллагаа** | Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, зөрчилгүй ажиллах соёлыг хэвшүүлж | Ёс зүйн өргөдөл гомдлын буурсан хувь | хувь | 2024 | Нийт 3467 өргөдлийн 128 буюу 3.6 хувь нь ёс зүйтэй холбоотой өргөдөл гомдол байна | 3.4 | 3.5 | 50 | - | - | - | Монгол Улсын Төрийн албаны зөвлөл, Ёс зүйн хорооноос зохион байгуулсан хойд бүсийн төрийн байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хороог чадавхжуулах сургалтад 30 байгууллагын дэргэдэх ёс зүйн хорооны дарга, гишүүн 45 албан хаагч оролцож, ёс зүйн зөрчлийг шийдвэрлэх ур чадварт суралцсан. Аймгийн хэмжээнд 2025 оны 3 дугаар улирлын байдлаар 2029 өргөдөл, гомдол бүртгэгдсэнээс 63 өргөдөл төрийн албан хаагчдын ёс зүйтэй холбоотой бөгөөд нийт өргөдлийн 3.5 хувийг эзэлж байна. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **4.6.1.2** | | ажиллах соёлыг хэвшүүлж, төрийн байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хороодыг чадавхжуулна. | Чадавхжуулах сургалтын тоо | тоо | 2024 | 6 | 10 | 12 | 100 | 15.0 | 15.0 | 100 | Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр", Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ыг баримтлан төрийн байгууллагын ёс зүйн дэд хороод салбар, байгууллагын түвшинд сургалт, соён гэгээрүүлэх үйл ажиллагаагаа тогтмол хэрэгжүүлж байна. 2025 онд давхардсан тоогоор 141 байгууллагын 3100 албан хаагчид танхим болон цахим хэлбэрээр 12 удаагийн сургалтыг зохион байгуулаад байна. Үүнээс 3 удаагийн сургалтыг төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдад зориулан зохион байгуулсан. |
| **4.6.1.3** | | Төрийн бүх шатны байгууллагад ажиллаж буй шинэ, залуу мэргэжилтнүүдийг чадавхжуулна. | Чадавхжуулах сургалтад хамрагдалтын хувь | хувь | 2024 | 50 | 60 | 87 | 100 | - | - | - | Аймгийн хэмжээнд 4161 төрийн албан хаагч ажиллаж байгаагаас 5 хүртэл жил ажиллаж буй албан хаагч 1158 буюу 27.8 хувийг эзэлж байна. Удирдлагын академиас зохион байгуулдаг төрийн жинхэнэ албанд анх томилогдон ажиллаж буй албан хаагчийг чиглүүлэх сургалтад 23 албан хаагчийг суралцуулсан. Шинээр томилогдсон албан хаагчдад зориулсан 3 удаагийн 8 цагийн ёс зүйн сургалтад 25 байгууллагын 411 албан хаагчийг хамруулав. Мөн төрийн байгууллагын албан хэрэг хөтлөлт болон бусад мэргэжлийн ажлын байранд дадлагажуулах, ур чадварыг дээшлүүлэх ажлыг төрийн байгууллага бүр хэрэгжүүлэн ажиллаж байна. Шинэ, залуу албан хаагчдыг чадваржуулах, ур чадварыг дээшлүүлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээг давхардсан тоогоор 30 удаа зохион байгуулж, 1-5 хүртэл жил ажиллаж буй 1007 албан хаагч буюу 87 хувийг нь хамруулсан байна. |
| **4.6.2** | **Хөтөлбөрийн** | Төрийн байгууллага, төрийн албан хаагчдын бүтээмжийг дээшлүүлнэ. | Иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа | Хувь | 2024 | - | 70 | 0 | 0 | 20 | 20 | 100 | Аймгийн Засаг даргын 2025 оны А/680 дугаар захирамжаар төрийн албан хаагчдад чиглэсэн сургалт, соён гэгээрүүлэх болон олон нийтийн оролцоотой арга хэмжээг зохион байгуулах зорилгоор “Чадварлаг төрийн албан хаагч-Хариуцлагатай төрийн алба” сарын аяныг зарлан, төрийн байгууллага, ажилтнуудын ажил мэргэжлийн онцлогийг танилцуулах видео контентын уралдаан, төрийн албан хаагчдын “Талархлын долоо хоног”, соён гэгээрүүлэх сургалт, мэдээлэл, нөлөөллийн арга хэмжээ, “Чадварлаг төрийн албан хаагч-Хариуцлагатай төрийн алба” сэдэвт илтгэлийн уралдаан, “Алтан хонх” хөгжөөнт танин мэдэхүйн тэмцээн, “Зөвлөн тусалж, өвлөн суралцъя” уулзалт, төрийн албан хаагчдын волейболын аварга шалгаруулах тэмцээнийг тус тус зохион байгууллаа. Сарын аяны хүрээнд төрийн байгууллагууд хамт олноороо шинэлэг санаачилга хэрэгжүүлж, ажлын байрны бүтээмж, чанар сайжирсан. |
| **4.6.2.1** | **Үйл ажиллагаа** | Төрийн албаны стандартыг хэрэгжүүлнэ. | Стандарт хэрэгжилтийн хувь | хувь | 2024 | - | 50 | 84.4 | 100 | - | - | | Төрийн албаны үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага MNS 7068:2025 стандарт батлагдан 2025 оны 5 дугаар сарын 19-ний өдрөөс хэрэгжиж эхлээд байна. Стандартыг бүх төрийн байгууллагуудад танилцуулан, хэрэгжүүлэх үүрэг чиглэлийг хүргүүлсэн. 2025 оны 10 дугаар сард төрийн ажлын зохион байгуулалт, стандартын хэрэгжилтийг аймагт үйл ажиллагаа явуулж буй 149 төрийн байгууллагад шалгаж дүгнэхэд 84.4 хувьтай дүгнэгдсэн. |
| **4.6.3** | **Хөтөлбөрийн** | Төрийн албан хаагчдын нийгмийн баталгаа хангагдаж, ажиллах орчин нөхцөл сайжирна. | Нийгмийн баталгааг хангахад зарцуулсан төсөв | тэрбум төгрөг | 2024 | 3.7 | 4.4 | 4.1 | 57.1 | | | | Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн 149 байгууллага төрийн албан хаагчдын сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлж байна. Сургалт нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд 4161 албан хаагчдад 1.4 тэрбум төгрөгийн тусламж, дэмжлэг үзүүлсэн. Төрийн албан хаагчдын боловсролын зэрэг, мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр 32 төрийн албан хаагчид 68.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлжээ. |
| **4.6.3.1** | | Төрийн албан хаагчдад олгох орон нутгийн нэмэгдлийн хамрах хүрээ, хувь хэмжээг үе шаттай нэмэгдүүлнэ. | Орон нутгийн төсвөөс олгож буй орон нутгийн нэмэгдлийн эзлэх хувь | хувь | 2024 | 27/665 | 32 | 50 | 100 | | | | Булган, Хангал сум улсаас 40 хувь, аймгаас 20 хувь, сумаас 40 хувиар тооцож 100 хувийн нэмэгдлийг олгож, бусад сум улсын 40, аймгийн 20 хувь, нийт 60 хувийн нэмэгдлийг төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдад олгож байна. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **4.6.3.2** | **Үйл ажиллагаа** | Төрийн байгууллагуудын техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлж, төрийн албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулна. | Төрийн албан хаагчдын техник хэрэгсэл тоног төхөөрөмжийн хангалтын хувь | хувь | 2024 | 20 | 35 | 35 | 100 | | | | Аймгийн хэмжээнд төрийн байгууллагууд албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулахаар орон нутгийн төсөв болон нийгмийн хариуцлагын хүрээнд 948.1 сая төгрөгөөр техник хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авсан байна. Ингэснээр төрийн албан хаагчдын техник, тоног төхөөрөмжийн хангалт өмнөх оноос 15 пунктээр нэмэгдэж, 35 хувьд хүрсэн байна. Мөн аймгийн ИТХ, ЗДТГ, Гурванбулаг, Бугат, Тэшиг, Бүрэгхангай, Баян-Агт, Хангал сум нийт 1.5 тэрбум төгрөгийн автомашин, техник хэрэгслээр хангагдсан байна. |
| **Гадаад харилцаа** | | | | | | | | | | | | | |
| **4.7** | **ТЕЗ** | Эдийн засгийн үр өгөөжтэй гадаад хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ. | Харилцаж буй улс, орон нутгийн тоо | тоо | 2024 | 6 | 13 | 13 | 100 | | 735 | 100 | БНХАУ-ын Ляонин мужийн Шэньян хотын Худалдааны газар, ӨМӨЗО-ы Хөх хотын консулын газар, БНСУ-ын Чүнчоннам мужийн захиргаа болоод тус мужийн Асан, Танжин хотуудын захиргаа, Сонжү мужийн захиргаа, Гёнсанбүг мужийн Дэгү хотын захиргаа, ОХУ-ын Буриад улсын Улаан-Үүд хот, Закамень аймаг, Япон улсын Хоккайдо мужийн Хигашикава хот, Зүүн хойд Азийн нутгийн захиргаадын холбоо (NEAR), Турк Улсын "Нэсэ Э Хөдөө аж ахуй" ХХК, Канад улсын ЭККО-Фарм төсөл зэрэг улс, орон нутаг, олон улсын байгууллагуудтай эрүүл мэнд, боловсрол, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл үйлчилгээний чиглэлээр хамтын ажиллагаа тогтоож хамтран ажиллаж байна. Тус онд эдгээр улс, орнуудтай 18 удаагийн уулзалт, айлчлал хийж 145 хүн хамрагдсан. |
| **4.7.1** | **Хөтөлбөрийн** | Гадаад улс, орон нутагтай харилцан ашигтай, хамтын ажиллагааг хэрэгжүүлнэ. | Харилцаж буй улс, орон нутгийн тоо | тоо | 2024 | 6 | 13 | 13 | 100 | | | | БНСУ-ын Чүнчоннам мужийн захиргаа болоод тус мужийн Асан, Танжин хотуудын захиргаа, Асан хотын Хусогийн Их сургууль, Хөдөө аж ахуйн технологийн төв, Эрүүл мэндийн төв, Кёнги аймгийн Шинхан Их сургууль, Гёнсанбүг мужийн Дэгү хотын Шинэ тосгон Холбоо, Сонжү муж, БНХАУ-ын Ляонин муж, Аншань хот, ӨМӨЗО-ы Хөх хот, ОХУ-ын Буриад улс, Закамень аймаг, Канад Улсын ЭККО-Фарм төсөл, Зүүн хойд Азийн нутгийн захиргаадын холбоо (NEAR)-ны Хэрэг эрхлэх газартай боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн салбарын харилцаа тогтоож, идэвхтэй хамтын ажиллагааг хэрэгжүүлж байна. Хамтын ажиллагааны хүрээнд 76 төрийн албан хаагч БНСУ, Япон, БНХАУ, ОХУ-д албан ёсны сургалт, олон улсын хурал, туршлага судлах арга хэмжээнд хамрагдаад байгаа бол боловсрол, соёлын салбарын 40 гаруй албан хаагчид туршлага судлах болон соёлын арга хэмжээнд оролцож, Хусогийн Их сургуульд энэ онд манай аймгаас 18 оюутан элсэн суралцахаар явсан. Мөн Асан хотын Хөдөө аж ахуйн технологийн төвөөс Булган аймагт ухаалаг хүлэмж нийлүүлэх, Эрүүл мэндийн төвөөс шүд зайлах аппаратыг нийлүүлэх зэрэг ажлуудыг хэрэгжүүлж эхлээд байна. Япон улсад суугаа МУ-ын ЭСЯ-аар дамжуулан Япон улсын Хоккайдо мужийн Хигашикава хоттой харилцаа тогтоож, аж үйлдвэрийн салбарт туршлага судлан, хамтын ажиллагааг хөгжүүлэх эхлэл тавигдсан. |
| **4.7.1.1** | | ОХУ, БНХАУ болон бусад улс орнуудтай харилцах гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлнэ. | Харилцаж буй улс, орон нутгийн тоо | тоо | 2024 | 6 | 13 | 13 | 100 | - | 152.7 | 100 | ОХУ-ын Буриад Улс, Закамень аймагтай боловсрол, эрүүл мэнд, мал аж ахуйн чиглэлээр хамтын ажиллагаа өргөжиж, төлөөлөгчдийн айлчлал, мэргэжил дээшлүүлэх сургалтууд багтсан нийт 7 удаагийн арга хэмжээ зохион байгуулагдлаа. Ялалтын баяр, Сурхарбан наадмын арга хэмжээнд аймаг, сумдын удирдлага оролцож харилцаа холбоогоо өргөжүүлсэн бөгөөд Буриадын Багшийн коллежид манай аймгийн 25 багшийг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулж, боловсролын салбарын чадавхийг нэмэгдүүлэв. Мөн ОХУ-ын ХАА-н академид шинээр 3 оюутан элсэж, хөдөө аж ахуйн мэргэжилтэн бэлтгэх суурийг бэхжүүллээ. БНХАУ-ын Ляонин муж болон ӨМӨЗО-той үйлдвэрлэл технологийн парк байгуулах чиглэлээр хамтын ажиллагааны шинэ боломжийг нээж, төслийн хэлэлцээг эхлүүлэв. БНСУ, Япон, Канад, Турк зэрэг бусад улс орнуудтай харилцаагаа тэлж, БНСУ-ын Асан, Танжин хотуудтай сум, орон нутгийн түвшний хамтын ажиллагаа тогтоон санамж бичиг байгуулахаар тохирч, хөдөө аж ахуй, технологи, боловсролын чиглэлээр туршлага солилцох болсон. Япон улсын Хигашикава тосгонтой ижил түвшний орон нутгийн харилцаа шинээр тогтоож, Баян-Агт сумын 100 жилийн ойд "Япон хоол, гоймонгийн өдөрлөг" зохион байгуулсан нь соёлын солилцоог бэхжүүлэх чухал ажил боллоо. Канад улсын хөрөнгө оруулалттай "Экко-Фарм" төсөл хэрэгжиж эхэлснээр уур амьсгалд зохицсон ухаалаг хөдөө аж ахуй, тогтвортой үйлдвэрлэлийн чиглэлд хамтран ажиллах шинэ шат нээгдлээ. Турк улсын "Нэсэ Э Хөдөө аж ахуй" ХХК-тай эрчимжсэн мал аж ахуй, экспортын чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцов. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Оюутан суралцаж буй гадаад улс, орон нутгийн тоо | тоо | 2024 | 3/ОХУ, БНСУ, БНБеларусь улс | 4 | 3 | 75 | - | 530 | 100 | Манай аймгаас Бүгд Найрамдах Солонгос Улсын Шинхан Их сургуульд 64 оюутан, Хусо Их сургуульд 18 оюутан, ОХУ-ын Буриад Улсын Хөдөө аж ахуйн академид 15 оюутан нийт 97 оюутан тус тус суралцаж байгаагаас 57 оюутны сургалтын төлбөр, дотуур байрны төлбөрт энэ онд 591.1 сая төгрөгийг зарцуулаад байна. |
| **4.7.1.2** | **Үйл ажиллагаа** | Сум бүрийг гадаад улс орнуудтай нийгэм, эдийн засаг, хөдөө аж ахуйн чиглэлээр хамтран ажиллах асуудлыг судалж, гадаад харилцааг хөгжүүлнэ. | Харилцаа тогтоосон орон нутгийн тоо | тоо | 2024 | 1 | 6 | 6 | 100 | - | 28.3 | 100 | Сум бүрийг гадаад улс орнуудтай нийгэм, эдийн засаг, хөдөө аж ахуйн чиглэлээр хамтран ажиллах асуудлыг судалж, гадаад харилцааг хөгжүүлэх зорилтын хүрээнд аймгийн болон Тэшиг сумын төлөөллүүд ОХУ-ын Буриад Улсын Закамень аймагт зочилж "Эв модны наадам"-д оролцсон. БНСУ-ын Тун Ён хотын захиргаатай тогтоосон хамтын ажиллагааны хүрээнд Хутаг-Өндөр сумын 18 иргэн тус хотын гүзээлзгэний аж ахуйнд богино хугацаагаар ажиллаад ирлээ. Баян-Агт сумын Засаг дарга Япон улсын Хоккайдо мужийн Хигашикава тосгонд зочлон Япон улсад суугаа МУ-ын Элчин сайд, Хоккайдо муж дахь Монгол Улсын консул, Хигашикава тосгоны захирагч болон холбогдох албаны хүмүүстэй уулзалт хийж ижил түвшний орон нутгийн харилцаа тогтоох, аж үйлдвэрийн салбарт туршлага судлан, хамтын ажиллагааг хөгжүүлэх эхлэл тавигдсан. Энэ хүрээнд 7 дугаар сард зохион байгуулагдсан Баян-Агт сумын 100 жилийн ойн баяр наадмын үеэр Япон хоол, гоймонгийн өдөрлөгийг зохион байгуулсан. Канад Улсын хөрөнгө оруулалтаар Хутаг-Өндөр сумандхэрэгжиж буй Экко-Фарм төслийх хүрээнд Канад улстай хөдөө аж ахуйн чиглэлээр харилцаа тогтоож эхлээд байна. Уг хамтын ажиллагааны хүрээнд Хутаг-Өндөр сумын төлөөллүүд Канад улсын Альберта болон Саскачеван мужуудад хөдөө аж ахуйн туршлагаас суралцаж, хүртээмжтэй, жендэрийн мэдрэмжтэй, уур амьсгалд зохицсон ухаалаг хөдөө аж ахуй, хөдөө аж ахуйн байгальд суурилсан шийдлүүд, эрт зарлан мэдээлэх тогтолцоо, гамшгийн эрсдэлийн менежментийн чиглэлийн сургалтад хамрагдсан байна. Манай аймгийн дүрслэх урлаг, зураг зүй, технологийн 25 багш ОХУ-ын Буриад улсын Багшийн коллежид мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдпаа. Тэшиг сумын ЭМТ-ийн эмч, сувилагч нар Солонгос улсын Бусан хотод Дорнын анагаах ухааны хуралд оролцож, туршлага судалсан. |
| | | | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | тоо | 2024 | 1 | 5 | 10 | 100 | - | 24.0 | 100 | Сумдын Засаг дарга нар БНСУ-ын Асан хотын захиргаа, ИТХ-д зочилж, Хюндэй автомашины үйлдвэр болон Хусо их сургуулийн үйл ажиллагаатай танилцах, Танжин хотын ХАА, технологийн төвд ажиллаж Ухаалаг хүлэмжийн системийн сайн туршлагаас судлах, аймгийн бүх сум Асан, Танжин хотуудтай хамтын ажиллагаа тогтоох санамж бичиг байгуулах, эрүүл мэндийн чиглэлээр Бусан хотод Тэшиг сумын ЭМТ-ийн эмч, сувилагч нар Дорнын анагаах ухааны хуралд оролцох зэрэг нийт 9 удаагийн уулзалт зохион байгуулж, 2 удаагийн мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан. ОХУ-ын Закамень аймагт албан айлчлал хийж “Эв модны наадам”, Ялалтын баярт оролцсон. Мөн 11 дүгээр сард аймгийн дүрслэх урлаг, зураг зүй, технологийн 25 багш ОХУ-ын Буриад улсын Багшийн коллежид мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдаж, ХАА-н академид Бүрэгхангай, Рашаант, Хангал сумын 3 оюутан шинээр элсэн суралцсан. Япон улсын Хигашикава тосгонд хийсэн айлчлалын хүрээнд Элчин сайд, консул, орон нутгийн удирдлагатай уулзалт хийсэн, Баян-Агт сумын 100 жилийн ойд “Япон хоол, гоймонгийн өдөрлөг” зохион байгуулаа. Канад улсын “Экко-Фарм” төслийг Хутаг-Өндөр суманд эхлүүлсэн бөгөөд Альберта, Саскачеван мужид хийсэн сургалт, туршлага судлах арга хэмжээнд Хутаг-Өндөр сумын төлөөлөл оролцлоо. Гадаад харилцааны хүрээнд 10 арга хэмжээг хэрэгжүүлж, боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, технологи, соёлын хүрээнд олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлж, орон нутгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулав. |